

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО**

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**СЭДЭВ: “МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ
БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, ҮНЭЛЭХ”**

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**

*Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг
уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС 2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 23-
НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/ ЗОХИОН БАЙГУУЛСАН “МАЛЧНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, ҮНЭЛЭХ” СЭДЭВТ
ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 9 цаг 34 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ даргалав.

Ерөнхий хяналтын сонсгол явуулсан сэдэв: “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх”

Сонсголд оролцогчид: Сонсголын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо (цаашид “БОХХААБХ” гэх)-ны Наранцэцэгийн Алтаншагай, Пүрэвийн Батчимэг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Ренчинбямбын Сэддорж, Очирбатын Амгаланбаатар, Буланы Бейсен, Сонгобайн Замира, Нанзадын Наранбаатар, Болдын Уянга, Жадамбын Бат-Эрдэнэ, Сайнхүүгийн Ганбаатар, Мэндбаярын Мандхай, Салдангийн Одонтуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 15 Улсын Их Хурлын гишүүн (цаашид “УИХ-ын гишүүн” гэх) хүрэлцэн ирж, 51,7 хувийн ирцтэйгээр сонсгол 09 цаг 35 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд эхлэж, 17 цаг 17 минутад дуусав.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий хяналтын сонсголд оролцож байгаа Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн сонсголд оролцсон хүрэлцэн ирсэн Байнгын хорооны гишүүдийг ирц бүрдсэн тул Монгол Улсын Их Хурлын БОХХААБХ-ноос зохион байгуулж байгаа “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага түүний удирдлага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт ерөнхий хяналтын сонсголын 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн сонсголыг нээснийг албан ёсоор мэдэгдэж байна.

Өнөөдрийн сонсголд УИХ-ын гишүүдээс гадна төрийн байгууллагын 32 төлөөлөл, ТББ, иргэдийн 40 төлөөлөл бүхий нийт 72 оролцогч оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-д “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу МҮОНРТ, “Малчин телевиз” болон Парламентын шууд дамжуулах суваг ажиллаж байгааг Та бүхэндээ мэдэгдье.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.4-т “Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.” гэж заасны дагуу хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, сонсголд оролцох, ажиглах боломжийг хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээр дохионы хэлмэрчтэй шууд дамжуулж байна.

Энэхүү Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа хяналтын сонсгол нь зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар явагддаг болохыг сонсгол эхлэхийн өмнө онцгойлон анхааруулж байна. Иймээс өнөөдрийн сонсголд оролцож байгаа Та бүхэн зөвхөн хуульд заасан дэг журмыг сахин оролцохыг мэдэгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “Сонсголд оролцогчийн эрх, үүрэг”-ийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

124.1.Сонсголд оролцогч дараах эрх эдэлнэ: 124.1.1.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх; 124.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах; 124.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах. 124.2.Сонсголд оролцогч дараах үүрэг хүлээнэ: 124.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх; 124.2.2.сонсголын дэг сахих; 124.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх; 124.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх; 124.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх гэж тус тус заажээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24-т “...Улсын Их Хурлын хяналтын сонсгол болон хяналт шалгалтын түр хорооны сонсголд оролцож байгаа этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ.”, 21.26-д “Энэ хуулийн 21.24-т заасан холбогдох албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, танилцуулсан гэж үзвэл гишүүн хуралдаан даргалагчид санал гаргаснаар Тамгын газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тухайн мэдээллийн үнэн зөв, бодит эсэхийг ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана.”, 21.28-д “...Улсын Их Хурлын хяналтын сонсголд ... худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлыг нам, эвслийн бүлэг, эсхүл 20-оос доошгүй гишүүн гарын үсэг зурсан бол энэ хуулийн 30.1.11-д зааснаар холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.”, 21.30-д “...Улсын Их Хурлын хяналтын сонсголд ... худал мэдээлэл ирүүлсэн, танилцуулсан, мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан нийтийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 32.8-д заасан хариуцлага хүлээлгэнэ. 21.31-д “...хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай ⁷ болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Энэ хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг тасалдуулсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.25-д заасан парламентыг үл хүндэтгэх үйлдэл гэж үзэн Төрийн

албаны тухай хууль, эсхүл Зөрчлийн тухай хууль заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 57.6-д “Шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.”, 57.7-д “...шинжээч, сонсголд оролцогч, ажиглагч, бусад хүн сонсголын дэг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 57.9-д “Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, эсхүл холбогдох тайлбар, мэдээлэл өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.”

Одоо Та бүхэнд Сонсгол даргалагчийн эрх, үүргийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу Сонсгол даргалагч нь сонсголын явцад асуулт, хариулт өгөх дарааллыг тогтоох бөгөөд тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох, сонсголын дэг зөрчсөн, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах, сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх, сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авах эрхтэй болохыг сануулъя.

За ингээд Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа өнөөдрийн сонсголын гол ач холбогдол бол мэдээлэл сонсох, цуглуулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн мэдэх эрхийг хангаж, саналыг сонсож, шийдвэр гаргах түвшиндээ нэгдсэн нэг ойлголттой болох, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөхөд чиглэх юм.

Та бүхэндээ сонсголын хөтөлбөр дэг, дарааллыг танилцуулъя. Бидний цаг хөтөлбөрт зааснаас бага зэрэг хойшилж яваа. Хөтөлбөрийн дагуу “Малчны тухай хууль”-ийн талаарх танилцуулгыг УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, дараа нь “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-ын танилцуулгыг Монголын Хуульчдын Холбооны судлаач О.Энххүслэн, 3-т “Малчны хөгжлийг дэмжих залгамж халааг бэлдэх” сэдвээр Боловсролын сайд Л.Энх-Амгалан танилцуулна. Үүний дараа сонсголын оролцогчдоос санал, тайлбар, үг хэлнэ. Үүний дараа сэдвийн дагуу хийсэн танилцуулгатай холбогдуулан УИХ-ын гишүүд 30 минутад багтаан асуулт асууж, хариулт авна. УИХ-ын гишүүд 20 минутад багтаан үг хэлнэ.

Дараагийн танилцуулга “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд авсан арга хэмжээ”-ний талаар Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулна. Үүний дараа сонсголд оролцогч иргэдээс санал, тайлбар, үг хэлнэ. Дараа нь УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Хөтөлбөрийн дагуу үдээс хойш “Цахим шилжилтийг малчны үйл ажиллагаанд хэрхэн нэвтрүүлж байгаа талаар” Цахим хөгжил, инновац, хөгжлийн холбо харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран танилцуулна. Танилцуулгатай холбоотой сонсголд оролцогч иргэдээс санал, тайлбар, үг хэлнэ. Дараа нь УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Дараа нь “Малчны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж” сэдвээр Эрүүл мэндийн сайд Э.Батшугар танилцуулга хийнэ. Танилцуулгатай холбоотой сонсголд оролцогч иргэдээс санал, тайлбар, үг хэлнэ. Дараа нь УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Үүний дараа “Бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулах,

хэрэгжүүлэх хүрээний зарим асуудал” сэдвээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай илтгэл тавина. Ингээд мөн адилхан сонсголд оролцогчид болон УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.7-д “сонсгол даргалагч сонсож байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулан сонсголын тэмдэглэлд тусгуулна;” гэж заасны дагуу урьдчилан бичгээр ирүүлсэн санал хүсэлт, мэдээллийн агуулгыг миний бие уншиж танилцуулна. Ингээд сонсголыг хааж миний бие үг хэлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-д заасны дагуу сонсголд оролцогч санал, мэдээллийг 3 минут багтаан танилцуулна. УИХ-ын гишүүдийн асуулт асууж хариулах хугацаа бүхэлдээ 30 минут байгаа. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.6-д зааснаар УИХ-ын гишүүд 5 минут багтаан үг хэлнэ. Ингээд хяналтын сонсголын дэг болон дарааллыг танилцуулж дууслаа. “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдлага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих” сэдэвт ерөнхий сонсголыг эхлүүлж байна. Ингээд хөтөлбөрийн дагуу “Малчны тухай хуулийн танилцуулга”-ыг УИХ-ын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Баярлалаа. Өнөөдөр энд хуран цугларсан Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид мөн өнөөдрийн сонсголд оролцож байгаа УИХ-ын гишүүд Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе!

Одоогоос бараг 2 жилийн өмнө тухайн үеийн Улсын Их Хурлын 17 гишүүн санаачилж Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болсон мал аж ахуй (МАА)-н салбарын хөгжлийг дэмжих, бодлогын зохицуулалт бүхий хууль батлагдаж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Өнгөрсөн жил хагас гаруй хугацаанд энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй, алдаа оноотой байгаа нь төрийн үйл ажиллагаанд тодорхой хүндрэл, доголдол гарч, хэрэгжилтийн явцад төрийн бодлого, шийдвэр хэрэгжихгүй байгаатай холбоотойгоор өнөөдрийн энэ ерөнхий хяналтын сонсголыг хуульд заасан эрхийн хүрээнд санал гарган, зохион байгуулж байна.

Өнөөдрийн Малчны тухай хуулийн хэрэгжилтийн талаар ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, энэ үйл ажиллагаа, санаачилгыг дэмжиж ажиллаж байгаа БОХХААБХ-ны хоо нийт гишүүдэд талархал илэрхийлье. Мөн энэхүү ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулахад санаалчлан гарын үсэг зурж, УИХ-д өргөн мэдүүлсэн гишүүддээ талархал илэрхийлье. Дэмжиж гарын үсэг зурсан 30 гаруй УИХ-ын гишүүд байгаа бөгөөд дийлэнх нь хөдөө, орон нутгаас сонгогдсон гишүүд байгаа.

Ерөнхий хяналтын энэхүү сонсгол 2 өдөр зохион байгуулагдах бөгөөд 70 орчим оролцогч, иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцохоор байгаа. Манай төрийн байгууллагууд энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар танилцуулаад явна. Мөн энэ салбарын талаар сэтгэл санаагаа зовоож явдаг, бие сэтгэлээ зориулсан эрдэмтэн, судлаачид бас оролцож байгаа. Бас хөдөө, орон нутгаас Монгол Улсынхаа өнцөг булан бүрээс, аймаг сум бүрээс хүрэлцэн ирж малчдынхаа дуу хоолойг хүргэхээр

Төрийнхөө ордонд хүрэлцэн ирсэн 60 орчим малчид маань байгаа. Та бүхэндээ юуны өмнө талархал дэвшүүлье.

Би эдгээр малчдын маань төлөөлөл, эрдэмтэн судлаачдын маань төлөөлөл болж оролцож байгаа онцолж хэлэх ёстой хэдэн хүмүүс байгаа. Манай “Малчин телевиз”-ийн “цаг уурын Шаагаа ах” гэж алдаршсан Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Шагдарсүрэн ах маань хүрэлцэн ирсэн байгаа. Монгол Улсын гавьяат малчин Д.Гомбо-Очир гуай маань хүрэлцэн ирсэн байна. Мөн Сүхбаатар аймгийн уугуул Монгол Улсын аварга малчин Р.Мөнхтөр ах маань хүрэлцэн ирсэн байна. Та бүхэнд зуны дунд сарын энэ бэлгэтэй сайхан өдрийн мэндийг өргөн дэвшүүлж, мэндчилж байгааг хүлээн авна уу.

Та бүхэнд хууль санаачлагчийн хувиар тухайн үед бид энэ хуулийн төслийг анх боловсруулахдаа ямар үзэл санаагаар, ямар зорилгоор, ямар зорилтыг биелүүлэхийн хүрээнд боловсруулсан талаарх мэдээллийг товчхон танилцуулъя. Манай улс орны эдийн засгийн тулгуур болсон энэ салбар дээр бид бодлогын өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага байна гэж үзэж энэ хуулийг анх өргөн барьж, батлуулж байлаа.

Би танилцуулгаа эхлэхээс өмнө нэг зүйлийг онцолж хэлэхэд УИХ-аас ерөнхий хяналтын сонголыг хуулийн хэрэгжилтийн талаар анх удаагаа санаачлан зохион байгуулж байгаа. Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 937 хууль байна. Энэ 937 хуулийн хэрэгжилт магадгүй 30-40 хувийн биелэлттэй, биелэлт муу байгаа хуулиудын нэг нь бол Малчны тухай хууль гэж би харж байгаа.

Маш олон хуулиуд дотроос магадгүй Ахмад настны тухай хууийн шинэчилсэн найруулга батлагдаад 2 жил, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдаад 10 орчим жилийг болж байна. Мөн Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдаад 7-8 жил болж байна. Эдгээр хуулиуд төрийн байгууллагын үйл ажиллагаа, төсөв нь батлагдаагүй, журам батлагдаагүй зэргээс шалтгаалаад өнөөдөр үндсэндээ иргэний эрх болон төрийн бодлого үгүйсгэгдэх түвшинд байгааг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр бид бүхэн өнөөдөр үндсэндээ улс орныхоо тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль батлахаас гадна батлагдсан хуулийнхаа хэрэгжилт дээр онцгойлон анхаарах зайлшгүй шаардлагатай байна гэдгийг хэлэх гэсэн юм. Юуны түрүүнд би та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн хэдэн заалтыг юуны түрүүнд онцолж хэлье гэж бодож байна.

Монголын төр Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй; Арван есдүгээр зүйлийн 1-д Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна., Хорьдугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална., Гучин наймдугаар зүйлийн 2.1-д Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах гэж заасан.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд буюу Монгол Улсын Засгийн газар Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1-д заасны дагуу Засгийн газраа удирдан, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг.

Өнөөдрийн ерөнхий хяналтын сонсголын зорилго нь Засгийн газраас хуулийн биелэлт болон хариуцлагыг нэхэн шаардахад оршиж байгааг Та бүхэнд танилцуулъя.

Эхлээд энэ хууль төрөн гарах үндсэн суурь шалтгааныг товч танилцуулъя. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болсон мал аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 11%-ийг, Монгол Улсаас экспортолж буй бараа бүтээгдэхүүний 5.6%-ийг тус тус бүрдүүлж байна. Мөн Монгол Улсын нийт ажиллах хүчний дөрөвний нэг буюу 25% нь, өөрөөр хэлбэл иргэн бүрийн дөрвөн хүн тутмын нэг нь өнөөдөр мал аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж байна.

Улсын хэмжээнд нийтдээ 250 мянга орчим малчин өрх байна. Мал, аж ахуй бол хүн төрөлхтний мөнхийн хэрэгцээг хангадаг, хүнсний хангамж болоод Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулдаг онцгой чухал салбар гэдгийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Энэ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой шууд уялдсан стратегийн чухал асуудал юм. Өнөөдөр бид Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн хараат байдлаас бүрэн ангижрах, нэг салбараас хамаарах байдлыг өөрчлөх асуудлыг олон жил ярьж байна. Үүний үндсэн гарц шийдэл нь манай улсын эдийн засгийг авч явсан уламжлалт энэ салбар дээр хуулийн хэрэгжилтийг нэхэх, хийгдсэн эрх зүйн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхийг шаардах зайлшгүй шаардлага байна гэдгийг онцлон хэлье.

Монгол Улсын газар нутгийн 80 орчим хувь нь мал аж ахуйд суурилсан эдийн засагтай бөгөөд нийт газар нутгийн 71.2%-д мал аж ахуйн үйлдвэрлэл явагдаж байна. Энэ нь 313 мянган малчны эрх ашигтай холбоотой онцгой чухал салбар юм.

Хуулийн үндсэн зорилго нь мал аж ахуйн салбарын хөгжлийг тодорхойлж, ирээдүйн зураглалыг гаргах, малчин хүний нийгмийн харилцаа, эдийн засгийн баталгаа, эрх зүйн үндсийг тэтгэвэрт гарах хүртэлх бүхий л үе шатыг анх удаа тодорхойлохыг зорьсон хууль. Энэ хууль нь мал аж ахуйн салбартай холбоотой бүхий л харилцааг иж бүрнээр нь анх удаа тодорхойлж, олон чиглэлээр цогц зохицуулалт бий болгосон ач холбогдолтой хууль юм. Нэг талаас энэ хууль нь мал аж ахуй эрхэлж буй 313 мянган малчны эрх ашгийг хамгаалах, тэдний ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн. Нөгөө талаас улс орны тулгуур салбар болсон мал аж ахуйг хэрхэн эдийн засагжуулах, төрөөс ямар бодлого, дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтыг хэрхэн дэмжих, хүний хөгжлийг төрийн бодлогоор хэрхэн хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бүтээмжийг хэрхэн бий болгох асуудлуудыг тусгасан.

Энэ хуульд малчдын мэдлэг боловсролын асуудлыг оруулж, салбарыг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх бодлогыг тодорхойлж өгсөн. Мөн салбарын боловсон хүчнийг дэмжих, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн. Малчдын эдийн засгийн баталгаа болсон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, хууль хоорондын уялдааг хангах асуудлыг тусгайлан гаргаж ирсэн. Иймээс энэ хууль нь нэг талаас хүнд чиглэсэн, нөгөө талаас эдийн засгийн чухал салбарыг эдийн засагжуулах, салбарт явагдаж буй бүхий л үйл явц, харилцааг зохицуулахад чиглэсэн зохицуулалт юм.

Гэвч энэ салбарт хуулийн хэрэгжилт удаашралтай байгаагаас үүдэн 10–20 жилийн турш тулгамдсан асуудлууд хэвээрээ байна. Өнөөдөр улсын хэмжээнд бэлчээрийн даац болон бэлчээрийн доройтлын асуудал 65 хувьтай байгаа. Малчдын газар ашиглах эрхийг баталгаажуулах асуудал хуулийн хэрэгжилтийн хувьд учир дутагдалтай, хариуцлагагүй уул уурхайн сөрөг нөлөөлөл тодорхой хэмжээгээр үргэлжилж байна. Хөдөө орон нутагт амьдарч буй 247 мянган малчин өрхийн тоо жилээс жилд буурч байна. Зөвхөн малчин өрхийн тоог авч үзвэл өнгөрсөн оноос энэ жилийн хооронд 1600 малчин өрх хот, суурин газар луу нүүдэллэн, шилжсэн мэдээлэл гарч байна. Залуу үеийн оролцоо, малчдын залгамж халаа болсон залуучуудын асуудал орхигдож байна. Нийт 313 мянган малчны дунд 35 хүртэлх насны залуучуудын эзлэх хувь дөнгөж 22%-тай байна.

Иймд бид нийгмийн баталгааг нь анхаарч, хүн ам зүйн бодлого дахь алдааг засаж залруулах зайлшгүй шаардлагатай байна. Хүйсийн харьцаа нийт малчдын дунд 40:60, залуу малчдын хувьд 70:30 байна. Малчин хүний хөдөлмөрийн үнэлэмж сул, түүхий эд болон зах зээл бүрдүүлэх, эдийн засгийн баталгаа, орлогын тогтвортой байдлыг хангах асуудал дээр төрөөс бодлогын түвшинд анхаарах зайлшгүй шаардлага байна. Хуулийн хэрэгжилт хангалтай байна гэж дүгнэж байна.

Бид малын тооноос илүүтэй ашиг шим, чанарын асуудлыг олон жил ярьж байна. Малын генетик нөөц, малын эрүүл мэндийн тухай хуулиуд болон холбогдох бодлогууд хөрсөн дээр бууж хэрэгжих тогтолцоо одоо болтол бүрдээгүй байна. Бодлогын хэрэгжилт бүх түвшинд, тэр дундаа Засгийн газрын буюу гүйцэтгэх засаглалын түвшинд хүндрэлтэй, хуулийн зохицуулалтууд бүрэн дүүрэн, жигд хэрэгжээгүй байгаа учраас энэ сонсголыг зохион байгуулж байна. Энэ хуулийг дагалдан Засгийн газраас нийт 11 журам, аймгийн засаг дарга, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 3 журам гарч, нэг мөр хэрэгжих зайлшгүй шаардлагатай байгаа эрх зүйн зохицуулалтууд бий...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн хууль санаачлагчийн хувьд хэлэх асуудал нэлээд байна. Цагийг 5 минутаар сунгая.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Яриагаа товчлон, үлдсэн хэсгийг бичгээр танилцуулья. Үндэсний хэмжээнд энэ хуулийн хэрэгжилтийг бодитой хангах, бодлогын уялдааг хангах, хэрэгжилтийн нөлөөг нэмэгдүүлэх нэн чухал шаардлага байна. Энэ хуульд төрөөс хэрэгжүүлэх, дэмжих бодлогуудыг тодорхой болгож, нийт төрийн эрх, үүргийг тодорхойлсон. Хууль хоорондын уялдааг хангах, хөдөө аж ахуйн хөгжлийн бодлогыг баталгаажуулах зохицуулалтыг хийсэн.

Анх удаа мал аж ахуйн салбарын бүтээмжийг тодорхойлж, түүнийг үнэлэх аргачлалыг боловсруулах ажлыг Засгийн газарт үүрэг болгосон. Малчин хүний үүргийг зохистой дадалтай нь уялдуулж, мал аж ахуйн салбарт хариуцлагатай үйлдвэрлэлийг бий болгох зохицуулалт хийж, малчин хүний хариуцлагатай байдлыг 4 багц, 28 зохистой дадлаар хуульд тусгасан. Тухайлбал, хуулийн 5.4.2-т малчин хүн малын хэвтэр, бууц, хашаа хороогоо байнга цэвэрлэж, өвөлжөөний хөрзөнг жил бүр авч, өтөг хөрзөн овоолон хэвтрийн нөөц бүрдүүлж байх гэх мэтээр өдөр тутмын гарын авлага болохуйц уламжлалт мал маллагааны арга ухааныг хүртэл хуульчлан зохистой дадал болгон тусгасан нь онцлогтой.

Энэ хуулиар малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарт суурилсан урамшуулал олгох журам гаргахыг Засгийн газарт даалгасан. Мөн мал аж ахуйн салбарт хөрөнгийн үнэлгээг бий болгох асуудлыг тавьсан. Нэгж мал ямар үнэ

өртөгтэй болохыг тодорхойлж, банкинд барьцаалагдаж буй малыг зөвхөн хонь, эсхүл бог, бод гэсэн нэгдсэн нэг үнэлгээтэй байлгахын оронд тухайн малласан малынх нь ашиг шим, амьдын жингээс хамаарсан нэгж ашиг шимээр нь хөрөнгийн үнэлгээг бүрдүүлэх, мал тус бүрийг үнэлдэг хөрөнгийн үнэлгээчдийг бий болгох асуудлыг хуульчилсан.

Энэ хуулиар малчны хөгжлийг тодорхойлж, малчдын залгамж халаа болох залуучуудыг бэлтгэх асуудлыг тусгасан. Улсын хэмжээнд малчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалтын нэгдсэн стандарт хөтөлбөртэй байж, түүнийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд болон их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулах асуудлыг тавьсан. Малчны хөгжлийн индексийг анх удаа тодорхойлж, малчин хүнийг хөгжүүлэхэд төрөөс боловсрол, эрүүл мэнд, мэргэжлийн талаас хэрхэн анхаарах вэ гэдгийг анх удаа хуульчлан тодорхойлсон. Мөн аймаг, сум бүрд малчны хөгжлийн сургалт, мэдээллийн төв байгуулах, малчин мэргэжлийн зэрэг дэв олгох зохицуулалтыг хийсэн.

Малчдын залгамж халаа болсон залуучуудыг мал аж ахуйн чиглэлээр дээд боловсролтой болгох, төрөөс суралцуулах, залуу гэр бүлд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зохицуулсан. Эрүүл мэндийн болон нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэж, мал бүртгэлтэй холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх эрхийг олгох асуудлыг тавьсан. Цаашид зөвхөн ухарч харалгүйгээр малчдын улирлын шинж чанартай орлоготой нь уялдуулан урьдчилан төлдөг, хагас жилд нэг удаа, тухайлбал ноолуурын улирлаар төлдөг байх зохицуулалтыг хуульчлахаар хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна.

Улсын хэмжээнд нийт малчдын 60 орчим хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан мэдээлэлтэй байна. Эрүүл мэндийн даатгал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох асуудалд анхаарах зайлшгүй шаардлагатай байна. Мөн малчин хүний хөдөлмөрийн үнэлгээг бий болгох, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх бодлого үгүйлэгдэж байна.

Энэ хуулийн хүрээнд төрөөс үзүүлэх санхүүгийн үйлчилгээ, зээл санхүүжилтийн асуудлыг анх удаа тусгасан. Өнөөдөр мал аж ахуйн салбар нь банкны хүү хамгийн өндөр тооцогддог, хамгийн эрсдэлтэй салбар тул төрөөс энэхүү стратегийн чухал салбарт онцгойлон анхаарах шаардлагатай.

Иймд бид нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийг хуульд тусгасан. Малчин хүний анхны суурь мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэхэд шаардлагатай үйл ажиллагаанд зориулж буюу өвөлжөөний хашаа саравч, өвс тэжээлийн нөөц, хөдөлмөр хөнгөвчлөх техник, технологи, хадлан тэжээл, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, хөв цөөрөм, худаг ус гаргах зэрэгт зориулсан нэн хөнгөлөлттэй зээлийг тусгайлан тусгасан...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Малчны тухай хуулийн танилцуулгыг хууль санаачлагч УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн танилцууллаа. Өнөөдөр энэ сонсголд мөн хууль санаачлагч УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар ирсэн байна.

Та бүхэнд нэг зүйлийг танилцуулъя. БОХХААБХ-ны 2026 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор энэхүү сонсголын бэлтгэл, зохион байгуулалтын ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: УИХ-ын гишүүн Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, Л.Мөнхбаясгалан, У.Отгонбаяр, Р.Сэддорж, Г.Туваан, Г.Тэмүүлэн гишүүд болон миний бие ажилласан. Энэ ажлын

хэсгээс өнөөдрийн сонголд УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан, Г.Тэмүүлэн, Р.Сэддорж нар хүрэлцэн ирсэн байна.

Дараагийн танилцуулга “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-ын талаар Монголын хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн танилцуулна. Хугацаа 15 минут байгаа.

Монголын хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн:

Эрхэм гишүүд болон сонголд оролцогч Та бүхэнд өглөөний мэндийг хүргэе. Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс захиалж, Монголын хуульчдын холбоо хөндлөнгийн үнэлгээг хийсэн. Үнэлгээг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн.

Малчны тухай хууль нь 2024 онд батлагдсан, 16 зүйл бүхий хууль юм. Судалгааны хүрээнд голлох 12 зүйл, заалт дээр дүн шинжилгээ хийсэн. Энэ нь судалгааны үр дүнг хэлэлцүүлж байгаа тул хуулийн аль заалт нь хэрэгжиж байгаа, аль нь сул, аль нь хэрэгжихгүй байгааг ерөнхийд нь товч танилцуулъя.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын хувьд хамгийн эхэнд хуулийн зорилтоос эхэлье. Хуулийн 1.1-д заасан хуулийн үндсэн санаа нь Монгол Улсын Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг хууль, бодлогын баримт бичигт тулгуурлан гарсан.

Хуулийн зорилтыг гурван чиглэлд авч үзэж болно: нэгд, малчны эрх зүйн байдлыг тодорхойлох; хоёрт, малчны ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг хөгжүүлэх; гуравт, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэх.

Эдгээр зорилгын хүрээнд хуулийн зохицуулалтууд тусгагдсан бөгөөд жишээ нь малчдын хөгжил, сургалт, мэдлэгийг дээшлүүлэх, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтууд зорилттойгоо нийцэж байна.

Харин гол асуудал нь хэрэгжилттэй холбоотой байна. Хэрэгжилтийн хувьд хуулийн 5 болон 9 дүгээр зүйлийг хэрэгжиж буй гэж үзэж байна. Хуулийн 6, 7, 11, 12, 15 дугаар зүйл сул хэрэгжиж байгаа буюу хэрэгжиж байгаа ч зарим хэрэгжилт нь сул гэж үзэж байна. Огт хэрэгжээгүй заалт буюу 13 дугаар зүйл байна гэж судалгааны баг дүгнэсэн.

Зүйл тус бүрээр авч үзвэл, хуулийн 5 дугаар зүйлд малчны таван төрлийн эрх, дөрвөн төрлийн үүргийг хуульчилсан. Малчдын амьдрах нөхцөл, эрх зүйн статус, боловсрол, нийгмийн баталгааг хөгжүүлэх талаар зохицуулалтыг тусгасан нь сайшаалтай. Мөн шинэ хоршоо, чинээлэг малчин хөдөлгөөн, цагаан алт үндэсний хөтөлбөр, алтан хайч улсын уралдаан зэрэг арга хэмжээний хүрээнд малчны эрх, үүрэгтэй холбоотой үйл ажиллагаа сайн хэрэгжсэн тул энэ нь хэрэгжиж буй зүйл заалтын ангилалд орсон. Хэрэгжиж байгаа дараагийн зохицуулалт нь малчны бүтээмжийг нэмэгдүүлэх заалт юм. Тэжээлийн хангамж, усан хангамж, зохиомол хээлтүүлэг зэрэг бүтээмжид нөлөөлөх үйл ажиллагааг хууль хэрэгжүүлэгчид хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн гоц халдварт өвчний голомтыг бууруулах, урамшуулах тогтолцоог бий болгох чиглэлд үйл ажиллагаа явуулсан.

“Цагаан алт” болон “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” зэрэг үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Гэвч бүтээмжтэй холбоотой хэрэгжээгүй асуудал нь

хуулийн 9.1-д заасан малчны бүтээмжийг тооцох арга зүй одоо хүртэл батлагдаагүй явдал юм. Мөн малчныг сонсох өдрийг зохион байгуулна гэсэн боловч тогтмол зохион байгуулагдахгүй байна.

Дараагийн зүйл заалт болох 6 дугаар зүйл буюу малчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлд “Атрын IV аян”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” зэрэг аяны хүрээнд нийт 10 аймагт малчдад сургалт зохион байгуулсан. Гэвч эдгээр сургалт нэгдсэн сургалтын хөтөлбөргүй байна. Хуулийн 6 дугаар зүйлд малчдын сургалт ямар хөтөлбөртэй байхыг тогтоож өгсөн ч явагдаж буй сургалт нэгдсэн хөтөлбөрт баригдахгүй байгаа тул сул хэрэгжилттэй гэж үзэж байна.

Малчны хөгжлийг дэмжих чиглэлд дээр дурдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээнүүд хэрэгжиж байна. Мал бордох аж ахуй байгуулах жишиг төсөл, газар тариалангийн газрыг бий болгох зэрэг төслүүд хэрэгжиж байгаа ч асуудалтай зүйл бий. Малчны хөгжлийг дэмжих хамгийн гол асуудал нь малчны хөгжлийн индекс батлагдах ёстой байтал одоо хүртэл боловсруулалт, хэлэлцүүлгийн шатад явж байгаа явдал бөгөөд энэ нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж буй нэг хүчин зүйл юм.

Уур амьсгалын өөрчлөлт болон эрсдэлийн удирдлагын хувьд 2024 онд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2014 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдаж, 2020 онд холбогдох стандарт батлагдсан. Эдгээр үйл ажиллагаа хэрэгжиж байгаа ч малчид эрсдэлийн санг байгуулж болно гэсэн зохицуулалт огт хэрэгжээгүй тул хэрэгжилтийн түвшин сул байна.

Хариуцлагын тогтолцоо буюу 15 дугаар зүйлд Малчны тухай хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр заасан. Зөрчлийн тухай хуульд иргэнийг 100 нэгж, аж ахуйн нэгжийг 1000 нэгжээр торгох ерөнхий зохицуулалттай боловч Малчны тухай хуулийн ямар заалтыг зөрчсөн тохиолдолд ямар ялгамжтай шийтгэл оногдуулах тухай нарийвчилсан тусгай зохицуулалт байхгүй. Иймд хариуцлагын механизм ерөнхий байдлаар зохицуулагдсан тул сул хэрэгжилттэй түвшинд хамаарч байна.

Огт хэрэгжээгүй зохицуулалтуудыг товч авч үзье.

Нэгдүгээрт, хуулийн 13 дугаар зүйлд заасан Малчны хөгжлийн сан. Уг санг урамшууллын эх үүсвэр болон уул уурхайн орлогоос санхүүжүүлж, 30 хувийг малчдын гамшиг, эрсдэлд, үлдсэнийг жил бүр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар зохицуулсан ч одоо боловсруулалтын шатад явж байна.

Хоёрдугаарт, хуулийн 13 дугаар зүйлд заасан малчны хөгжлийн индекс. Үүнийг боловсруулна гэсэн боловч одоогийн байдлаар боловсруулаагүй бөгөөд Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Үндэсний статистикийн хороо хамтран батлахаар зохицуулсан.

Гуравдугаарт, хуулийн 14 дүгээр зүйлд заасан, 6 дугаар зүйлтэй холбоотой малчны хөгжлийн төв. Энэ нь зохион байгуулагдана гэсэн боловч бодит амьдрал дээр одоогоор бий болоогүй байна.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, манай баг нийт 16 зүйлээс 12 зүйл

буюу 80 орчим хувьд судалгаа хийсэн. Үүнээс хэрэгжиж буй зохицуулалт 26.7 хувь, сул хэрэгжиж буй зохицуулалт 33.3 хувь, малчны хөгжлийн төв, малчны хөгжлийн индекс зэрэг огт хэрэгжээгүй зохицуулалт 20 хувийг эзэлж байна.

Судалгааны дүгнэлт, санал нь дараах байдалтай байна.

Малчны тухай хуулиар 2024 онд малчны эрх зүйн статус, нийгмийн баталгаа, боловсрол болон малчныг хөгжүүлэх чиглэлд эрх зүйн үндсийг анх удаа бий болгосон хэдий ч анхаарах хэд хэдэн асуудал байна. Үйлдвэрлэл, бүтээмжийн талын зохицуулалт хэрэгжиж байгаа ч малчны хөгжлийг дэмжих, малчны хөгжлийн индекс зэрэг зохицуулалт хэрэгжилтийн хувьд сул байна. Иймд судалгааны багийн зүгээс малчны хөгжлийн санг яаралтай бий болгох, малчны хөгжлийн төвийг үе шаттай байгуулах, малчны хөгжлийн индексийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох, мөн 33.3 хувийг эзэлж буй сул хэрэгжилттэй зохицуулалтын хэрэгжилтийг цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Хуульчдын баг энэхүү судалгаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, дээрх үр дүнг гаргалаа. Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн танилцуулга “Малчны хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх талаарх” танилцуулгыг Боловсролын сайд Л.Энх-Амгалан хийх ёстой байсан. Сайд эзгүй тул түүнийг орлон Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир танилцуулна.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир:

Та бүхэнтэй мэдээлэл хуваалцъя. 2025–2026 оны хичээлийн жилд боловсролын бүх түвшний сургалтын байгууллага болон насан туршийн суралцахуйн төвд нийт 171,488 малчин өрхийн хүүхэд, залуус хамрагдаж байгаа нь нийт суралцагчдын 13.3 хувийг эзэлж байна. Үүнээс сургуулийн өмнөх боловсролд 30,312 хүүхэд, ерөнхий боловсролд 130,111 суралцагч, мэргэжлийн болон техникийн боловсролд 9,093 суралцагч, дээд боловсролд 322 оюутан, насан туршийн суралцахуйн төвд 1,650 суралцагч тус тус хамрагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын талаар авч үзвэл, малчин өрхийн 2-оос 5 насны 30,312 хүүхэд өдрийн бүлэг буюу үндсэн бүлэгт хамрагдаж байгаа бол 10,048 хүүхэд хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Хувилбарт сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн 70.6 хувь нь нүүдлийн бүлэгт, 29.3 хувь нь гэр бүлд суурилсан сургалтад хамрагдаж байна. Сүүлийн 5 жилийн статистикийг авч үзвэл малчдын хүүхдийн цэцэрлэгийн хамралт 2021–2023 онд өссөн, 2024–2026 онд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн тоо буурч байгаатай холбоотой гэж үзэж байна.

Малчин өрхийн хүүхдийг сургуульд бэлтгэх зорилгоор 2024 оноос хувилбарт сургалтын багшийг цэцэрлэгийн үндсэн орон тоонд ажиллуулж эхэлсэн бөгөөд 2025–2026 оны хичээлийн жилд 109 хувилбарт сургалтын багш цэцэрлэгийн үндсэн орон тоонд ажиллаж байна. Одоогоор хувилбарт сургалтын багш байхгүй 51 сум байгаа бөгөөд эдгээр сумдад 71 хувилбарт сургалтын багш шаардлагатай байгаа тооцоо судалгаа гарсан.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 2023 оноос малчин өрхийн хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан таблеттай багш арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг дэмжих, бага насны хүүхэдтэй

малчин өрхийг хүүхэдтэйгээ ажиллах арга зүйгээр хангах зорилготой энэхүү арга хэмжээнд 19 аймгийн 320 сумын 9,650 малчин өрхийн 13,500 хүүхдийг хамруулсан үр дүн гарсан.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т сургуулийн өмнөх боловсролыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлэх бөгөөд 200-аас доошгүй цагийн сургалтад хамруулсан байх зохицуулалтыг 2023 оны хуулийн шинэчилсэн найруулгаар тусгасан. Хувилбарт сургалт болон таблеттай багш зэрэг хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал улсын хэмжээнд 96 хувьд хүрсэн үр дүнтэй мэдээлэл гарсан. Салбарын яамнаас сургуулийн өмнөх боловсролын салбарт хувилбарт сургалтад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэд хэдэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Сургуулийн өмнөх боловсролын чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ дараах байдалтай байна.

Нэгдүгээрт, газар зүйн байршил, орон нутгийн онцлог, уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн хувилбарт сургалтыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан туршиж, сайн туршлагыг нэвтрүүлэх, мөн одоогоор гэр цэцэрлэгүүд ашиглаж буй орчин үеийн зөөврийн сууцуудыг турших;

Хоёрдугаарт, хүний нөөцийг тогтвортой байлгах үүднээс хувилбарт сургалтын багшийг үндсэн орон тоогоор ажиллуулах бодлогыг тогтвортой үргэлжлүүлж, бүтэц орон тоог нь цэцэрлэгийн орон тоонд батлуулах;

Гуравдугаарт, хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахын тулд багш болон хүүхдэд зориулсан сургалтын багцуудыг хэрэглэгдэхүүний багцад нэмж батлах;

Дөрөвдүгээрт, хувилбарт сургалтад хамрагдах хүүхдэд ноогдох хувьсах зардлын итгэлцүүрийг нэмэгдүүлэх;

Тавдугаарт, гэр бүлд суурилсан сургалтыг илүү чанартай, үр дүнтэй болгох зорилгоор эцэг эх, асран хамгаалагчийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлыг давхар зохион байгуулах.

Эдгээр ажлыг хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын талаар авч үзвэл, 2025–2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 819 мянган хүүхэд суралцаж байгаагийн 130,111 нь малчин өрхийн хүүхэд буюу нийт суралцагчдын 15.9 хувийг эзэлж байна. Эдгээр хүүхдийн 48 мянга нь хотын сургуульд, 82 мянга нь орон нутгийнхаа сургуульд суралцаж байна. Улсын хэмжээнд 2025–2026 оны хичээлийн жилд хамран сургах тойрогтоо сурах ёстой 6–14 насны 304 хүүхэд сургуулийн гадна буюу хамран сургах тойргийнхоо сургуульд суралцахгүй байгаагийн 164 нь малчин өрхийн хүүхэд байна.

Эдгээр хүүхдийг сургуульд бүрэн хамруулах арга хэмжээ авч байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 34,117 суралцагч амьдарч байгаагийн 25,065 нь малчин өрхийн хүүхэд буюу нийт хүүхдийн 73.5 хувийг эзэлж байна.

Монголын нүүдэлчин амьдралын хэв маяг, өргөн удам газар нутаг, сийрэг суурьшлын онцлогоос шалтгаалан сургуулийн дотуур байр, ялангуяа сумдын төвүүдийн дотуур байр нь 10 жилийн турш боловсролын хүртээмж, сургуулийн

хамралтыг өндөр байлгах гол хөшүүрэг болсоор ирсэн. Иймд дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, засаж тохижуулах ажлууд үе шаттай хийгдэж байна. Тухайлбал, 2022 онд 8, 2023 онд 7, 2024 онд 11, 2025 онд 12 дотуур байрны барилга байгууламжийг ашиглалтад оруулсан бол одоо 20 гаруй сургуулийн дотуур байрны барилга шинээр баригдаж байна.

Малчдын тулгамддаг асуудлын нэг нь үр хүүхдийнхээ боловсрол, сургалтын асуудал юм. Хэдийгээр 2023 онд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд хүндэтгэх шалтгааны улмаас хүүхдийг 7 настай элсүүлэх зохицуулалтыг хийсэн боловч малчдын амьдралд тулгардаг хүндрэл бэрхшээл хэвээр байна. Иймд салбарын яамнаас амьдралын хэв маяг, нүүдэл, улирлын онцлогийг харгалзан малчин өрхийн хүүхдийг 7, 8, 9 хүртэлх насанд нь гэрийн сургалтаар сургах боломжийг дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан, хүүхдийн сурах эрхийг хүндэтгэж, сургалтын олон хэлбэрийг бий болгон хөгжүүлэхээр зорьж ажиллаж байгааг энд хэлэх нь зүйтэй.

Боловсролын яам, Хаан банк, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран хил орчмын алслагдсан бүс нутгийн малчин иргэдийн хүүхдэд гэрт нь ойр бага боловсрол эзэмшүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор 2025 оноос багийн бага сургуулийн төслийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлсэн. Одоогоор Ховд аймгийн Үенч сумын хилийн цэргийн застав, Увс аймгийн Боршоо боомт, Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг, Цогт-Өндөр шинэ суурьшлын бүс, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тарни баг зэрэг газарт эрчим хүчний хэмнэлттэй технологиор бага сургуулийн барилга барьж, хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлсэн. Энэ санаачилгыг үргэлжлүүлэн энэ жил дахин 4–6 баг дээр багийн бага сургууль байгуулахаар ажиллаж байна. Ингэснээр бага насны малчин өрхийн хүүхэд бага боловсролыг эцгийнхээ дэргэд, гэртээ ойр, тухтай орчинд эзэмших боломж нэмэгдэнэ.

Мэргэжлийн болон дээд боловсрол, насан туршийн суралцахуйн чиглэлд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 10 байгууллага малчин хөтөлбөрийг нээсэн. 2025–2026 оны хичээлийн жилд 214 суралцагч энэ хөтөлбөрөөр хичээллэж байгаагаас Хөдөө аж ахуйн Их Сургууль (цаашид “ХААИС” гэх)-ийн харьяа Заамарын Политехник коллежид 25 суралцагч, Төв аймаг дахь Политехник коллежид 35 суралцагч, Завхан аймаг дахь Политехник коллежид 20 суралцагч малчин хөтөлбөрөөр суралцаж төгссөн. Мөн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагууд хөдөө аж ахуй, газар тариалангийн мэргэжлийн чиглэлээр 9 хөтөлбөрөөр 2,307 суралцагч, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 7 хөтөлбөрөөр 659 суралцагчийг тус тус сургаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн жагсаалтад мал аж ахуй, мал зүй, мал, амьтны эмнэлзүй, фермийн аж ахуй, ноос, эсгий боловсруулалт, арьс шир, үслэг эдлэлийн бүтээгдэхүүн зэрэг мэргэжлийг эрэлттэй, тэргүүлэх мэргэжилд тодорхойлж баталсныг дуулгая.

Хөдөө аж ахуйн чиглэлийн суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор суралцагчдыг дадлага сургалтад хамруулах, салбар дундын дадлагын бааз байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, сургалтын хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх, ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодтой салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, төгсөгчдийг ажлын байраар хангах, мэргэжлийн багш нарыг гадаад, дотоодод мэргэшүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлж байгаагаа Та бүхэнд дуулгая.

Хамгийн гол асуудал болох Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулахаар заасан. Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолд энэ асуудлыг тусгаж, 10-аас доошгүй жил тасралтгүй мал малласан малчны нэг хүүхдийг дээрх чиглэлээр суралцуулж, 2025 оны 9 дүгээр сараас санхүүжилт олгож эхэлсэн. Энэ хүрээнд 2025 онд 15, 2026 онд 8, нийт 56,1 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэлийн жагсаалтад хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүйн салбарт малчдын залгамж халааг бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр хөтөлбөрүүд батлагдан мөрдөгдөж байна. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлээр мах, сүү үйлдвэрлэлийн технологийн хөтөлбөрөөр бакалавр, магистрын түвшинд; малчдын үйлдвэрлэлд нэн шаардлагатай бэлчээрийн менежмент, тэжээл, бэлчээр судлалын хөтөлбөрөөр докторын түвшинд; мал аж ахуй, мал зүйн хөтөлбөрөөр бакалавр, магистр, докторын түвшинд сургалт явуулахаар индексүүдийг баталсан. Энэ хичээлийн жилд мал аж ахуйн чиглэлийн хөтөлбөрийг 3 сургууль, мал зүйн чиглэлийн хөтөлбөрийг 5 сургууль, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн хөтөлбөрийг 3 сургууль тус тус хэрэгжүүлж байна.

Малчны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д сумын Засаг дарга малчинд насан туршийн боловсрол, мэдлэг олгохтой холбогдуулан чиг үүрэг хэрэгжүүлэхээр заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтийг дэмжих, малчин хүүхэд, залуучуудад бие даан бизнес эрхлэх энтрепренёршипт суурилсан хувь хүний чадварыг хөгжүүлэх зорилгоор малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих арга хэмжээг Боловсролын сайдын 2025 оны 77 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээг 4 жилийн туршид 21 аймагт үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэ арга хэмжээний хүрээнд 2025 онд Зүүн бүсийн малчин хүүхэд, залуучуудын боловсролд хамрагдалтын тандан судалгааг хийж, нийт хүүхэд, залуучуудын 71.8 хувийг хамруулсан үр дүн гарсан. Судалгааны үр дүнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран боловсролын үйлчилгээнд хамрагдах, боловсрол нөхөн эзэмших, хэрэгцээт ур чадвараа нэмэгдүүлэх амьдрах ухааны сургалтыг орон нутгийн буюу аймгуудын насан туршийн суралцахуйн төвүүдэд түшиглэн зохион байгуулсан. Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Төв аймгийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежтэй хамтран мал аж ахуй, бэлчээрийн менежментийн чиглэлээр чадамжийн гэрчилгээ олгох сургалтад 25 залууг хамруулсан. Мөн ХААИС-ийн мэргэжлийн багш нартай хамтран хувь хүний ур чадвар эзэмшүүлэх, өрхийн санхүүгийн тооцоолол хийх, өрхийн бизнес эрхлэх, багаар ажиллах, манлайлах, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, бэлчээрийн менежмент, өрхийн хүнсний ногоо тариалалт зэрэг сэдвээр 700 гаруй залуу, нийт мянга гаруй залууг зүүн бүсэд сургалтад хамруулсан.

Түүнчлэн энтрепренёршипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургагч багш бэлтгэх, малчин залуу манлайлагч бэлтгэх сургалтад зүүн бүсийн аймгуудын мал аж ахуйн газар, насан туршийн сургалтын төвүүдтэй хамтран 50 сургагч багшийг бэлтгээд байна. 2026 оны эхний хагас жилд малчин өрхийн гишүүний боловсролыг дэмжих арга хэмжээг хангай, хойд, төвийн бүсэд зохион байгуулж, нийт 10,760 малчин залууг хамруулсан үр дүн гарсан.

Цаашид малчдын хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх, орон нутагт дэд бакалавр болон мэргэжлийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх, насан туршийн суралцахуйн төвд малчдын хэрэгцээнд нийцсэн сургалтуудыг зохион байгуулах, салбар хоорондын уялдааг сайжруулах асуудлыг бодлогын тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр мал аж ахуйн салбарын залгамж халааг бэлтгэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөөгийн хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт бодит үр дүнгээ өгнө гэж үзэж байна. Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бид хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн “Малчны тухай хуулийн танилцуулга”, Хуульчдын холбооны судлаач О.Энххүслэнгийн “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, мөн Боловсролын яамны ТНБД-ын танилцуулсан “Малчны хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх талаарх” гэсэн гурван илтгэл, танилцуулгатай танилцлаа. Одоо танхимд хүрэлцэн ирсэн малчид, иргэдийн төлөөллөөс үг хэлүүлэх боломжийг хангана. Нийт 5 хүний нэр ирсэн байна. Оролцогчид нэрсийн дарааллаар 3 минутад багтаан асуулт, саналаа хэлнэ. Эхний хүн нь Дорноговь аймгийн Айраг сумын малчин М.Бямбаахүү үг хэлнэ байна.

Оролцогч М.Бямбаахүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Дорноговь аймгийн Айраг сумын залуу малчин М.Бямбаахүү байна. Малчдын боловсролын тал дээр энэ хуульд зааснаар малчны нэг хүүхдийг мал аж ахуйн чиглэлээр онцгойлон, тусгайлан үнэ төлбөргүй сургана гэсэн. Энэ нь нэг талаас дэмжиж байгаа боловч нөгөө талаас хязгаарласан байна гэдгийг урьд өмнө нь хэлж байсан. Малчны хүүхдэд хүссэн сургуульдаа, хүссэн мэргэжлээрээ суралцах боломжийг нь хангаж өгөөч. Тэгвэл малчны хөгжлийг бодитоор дэмжиж байгаа нөхцөл бүрдэнэ.

Манай говийн бүсийн гишүүд хөдөө орон нутгаар явахдаа малчны хүүхдийн боловсролыг, тэр дундаа бага насны хүүхдийг цахимаар сургах боломжтой гэж ярьж байсан. Үүн дээр нэг талаас болгоомжлох зүйл бий. Учир нь цахимаар, бага наснаасаа суралцсан хүүхэд танхимаар суралцсан хүүхдээс хичээлийн хоцрогдолтой болох магадлал үүснэ. Дээрээс нь тусдаа, гэртээ суралцаж байсан учраас танхимд ороход “малчны хүүхэд хоцорчихсон байна” гэдгээр гадуурхагдах нөхцөл байдал бас үүснэ. Иймд боловсролын тал дээр анхаарч, малчны хүүхдүүдийг аль болох хоцрогдолгүй, дэлхийн боловсролын түвшинд хүргэх талаар бодолцоосой гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийнх нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын малчин В.Оюундэлгэр үг хэлнэ.

Оролцогч В.Оюундэлгэр: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумаас залуу малчин В.Оюундэлгэр оролцож байна. Малчны тухай хуулийн 5 дугаар зүйл дээр хэд хэдэн санал оруулах гэсэн юм. Миний хувьд Малчны тухай хуульд үүрэгжүүлсэн заалт маш олон байгаа харагдаж байна. Харин малчны эрхийг хамгаалах заалтууд нь арай дулимаг юм болов уу гэж бодож байна.

Иймд 5 дугаар зүйлд дараах саналыг оруулахыг хүсэж байна: хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх; малчны хөдөлмөр аюулгүй орчинд ажиллах, амьдрах эрхийг хангах; бэлчээр, ус болон байгалийн нөөцийг аюулгүй,

тогтвортой ашиглах эрхийг хангах; уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрсдэлийг бууруулах; нүүдлийн мал аж ахуй, уламжлалт мэдлэг, соёлын эрхийг хамгаалах; бүс нутгийн онцлог, эмзэг байдлыг харгалзан тэгш боломж олгох; төрөөс малчны амьжиргааны эрсдэлийг хамгаалан дэмжих; уул уурхайн үйл ажиллагаа малчны амьдрах орчин, нийгэм, соёлын тогтвортой байдал, хүний эрхийг дордуулахгүй байх зарчмыг тус тус нэмж тусгах. Манай говийн 5 аймаг уул уурхай ихтэй учраас бэлчээр нутгаа хамгаалсан заалтыг энэ хуульд нэмж оруулах хүсэлтэй байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Саналаа сайхан багцлаад оруулж ирсэн байна. Дараагийнх нь Өмнөговь аймгийн Хүрмэн сумын малчин Ё.Цэдэвсүрэн.

Оролцогч Ё.Цэдэвсүрэн: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би Өмнөговь аймгийн Хүрмэн сумын малчин Ё.Цэдэвсүрэн байна. Г.Тэмүүлэн гишүүний санаачилсан Малчны тухай хуультай танилцлаа. Танилцах явцад хүний хөгжил, мэдээ мэдээллийг анхаарч, хүн төвтэй ажиллах байдал дутмаг юм уу гэж иргэн хүнийхээ хувьд дүгнэж ойлголоо. Малчид бид мэдээ мэдээллээр маш дутмаг байдаг. Төр, иргэн хоёрын харилцаа холбоо бараг байдаггүй. Говь нутагт асуудал нэлээд байдаг бөгөөд хариуцлагагүй уул уурхай маш өндөр хөгжсөн, бизнес тал руугаа хэрэгжүүлж байгаа хууль юм уу гэж дүгнэж байна.

Малчдын эрх, үүрэг яригдаж байгаа боловч үүрэгжүүлсэн заалт нэлээд гарч ирж байх шиг байна. Малчин хүн төвтэй, хүнээ харж хандсан хууль боловсруулсан байгаасай. Малчин хүн ч төрийн албан хаагч, сайд дарга нартай адил хүнийхээ хувьд эрхээ хамгаалуулах эрхтэй байх ёстой гэж бодож байна. Мөн малчдын нэг хүүхдийг сургана гэж ярьж байгаа. Тэгэхээр малчдын хүүхэд өөрийнхөө хүсэл зорилгоор, хүссэн мэргэжлээрээ сурах боломжгүй юм болов уу гэж дүгнэлээ. Иймд малчдын хүүхдийг нэг удаа төрийн тэтгэлгээр дотоодынхоо аль ч их, дээд сургуульд сургана гэсэн заалтыг оруулж өгвөл зүгээр юм уу гэж харж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийнх нь Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 5 дугаар багийн малчин Ц.Ундармаа.

Оролцогч Ц.Ундармаа: Та бүгдэд энэ сайхан өдрийн мэндийг хүргэе. Би Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 5 дугаар багийн малчин. Манай Өмнөговь аймаг бол уул уурхайн бүс нутаг, Монгол Улсын хөгжил, цэцэглэлтийг нуруундаа авч явдаг хамгийн хэцүү аймаг юм. Энд мал, малчин хоёр амьдрахад их бэрх болсон учраас энэ хуулийн гарц, гаргалгаан дээр нэлээд их өөрчлөлт хэрэгтэй байна. Зарим заалт малчдад нийцээгүй байгааг хэлмээр байна. Ганц хоёр жишээ цухас дурдъя.

Энэ хуулийг анх санаачилж гаргахдаа хамгийн их уул уурхайн хөлд нэрвэгдсэн, дээрээс нь хатуу ширүүн уур амьсгалтай Өмнөговь аймгийн онцлогийг харгалзах ёстой байсан. Шороон шуурга, дөрвөн улирлын эрсдэл, малчин нэг ч амралтгүй 360 хоног амьдарч ажилладаг нөхцөлийг харгалзан хуульд тусгасан бол зүйтэй байсан. Жишээ нь, хуулийн 4.2.7-д гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгоно гэж заасан. Гэтэл 4.2.8-д гамшиг, аюулт үзэгдлийн улмаас нийт малын 50 хувиас доошгүйг алдсан байх гэх мэт олон шаардлага тавьсан заалт орсон байна.

Малчин амь насаа алдахад 50 хувь гэж байхад, хүчний байгууллага буюу цагдаагийн болон онцгой байдлын албан хаагч ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдвал тухайн албан хаагчийн орлогыг 2 дахин үнэлж, цалинг нь нэг жилээс хоёр жилээр нугалж олгодог.

Тэгэхээр малчин хүн, төрийн албан хаагч хоёрын ялгаа юу байгаа юм бэ гэдэг асуудал эндээс харагдаж байна. Босго нь нэг талд 50 хувь, нөгөө талд 40 хувь гэх зэргээр өрхийн орлогыг тооцож байна. Дараагийн заалт болох 7.5.2-т малчдаас нөлөө бүхий төлөөллийг сонгож манлайлагчийн сургалтын хөтөлбөрт хамруулна гэжээ. Энэ нь ойлгомжгүй байна. “Нөлөө бүхий төлөөлөл” гэдэг нь тодорхойгүй бөгөөд Засаг дарга, яам, эсхүл танил тал сонгодог бол шалгаруулалт шударга бус мэт харагдана. Хэрэв зорилго нь чадавхжуулах, манлайлах, хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх бол сонгон шалгаруулалт бусдад нээлттэй систем байх ёстой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Цаг дууссан байна. Ц.Ундармаад баярлалаа. Зөв зүйтэй асуудлуудыг гаргаж ирлээ. Дараагийн хүн “Хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл” Төрийн бус байгууллагын гишүүн Г.Алтанхуяг байна.

Оролцогч Г.Алтанхуяг (Хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл ТББ-ын гишүүн):

Баярлалаа. Боловсролын яамнаас хийсэн танилцуулга бол ерөнхий боловсролын талаар ерөнхийд нь дурдаад байх юм. Гэтэл малчны боловсрол гэдэг шал өөр зүйл юм. Хуулийн 6 дугаар зүйл бүхэлдээ академик болон танхимын боловсролоор малчдыг сургахтай холбоотой бөгөөд энэтэй холбоотой дүрэм журмууд гарах ёстой. Харин 7 дугаар зүйл бүхэлдээ танхимын боловсрол биш, сумын Засаг даргын хэмжээний асуудал. Сумын Засаг дарга малчдаа хэрхэн мэдлэгжүүлэх вэ гэдгийг яриад байгаа юм. Иймд энэ хуульд тус бүрийн яам өөрийн хариуцах хэсгийг оруулах ёстой.

Малчдын боловсрол дотор танхимын боловсролоор ямар мэдлэг олгох вэ гэвэл уламжлалт мэдлэг юм. Хэдэн мянган жил байгаль, цаг уурын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицож мал маллах вэ гэдэг уламжлалт мэдлэгийг эзэмшүүлэх хэрэгтэй. Иймд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т уур амьсгал, цаг уурыг шинжих, мал маллах болон амьдралд шаардлагатай тоног хэрэгслийг бэлтгэх уламжлалт арга, өв соёл, туршлагыг эзэмшүүлнэ гэж оруулах хэрэгтэй. Энэ чиглэлээр салбарынх нь яам Боловсролын яамтайгаа хамтран хөтөлбөр боловсруулж гаргавал зохистой. Энд 4 жилийн, 2,5 жилийн мэдлэг хэрэггүй; малчдад нэг жил буюу 1,5 жилийн мэдлэг л хэрэгтэй.

Манай сургалтын төв 2019 оноос хойш энэ чиглэлээр малчдад танхимын боловсрол олгож байна. Тиймээс энэ мэдлэгийг нэг жил буюу 1,5 жилд багтаасан хөтөлбөр, түүнчлэн тусгай зөвшөөрлийг гаргаж, сургалтын төвүүдэд өгөх ёстой.

Ямар мэдлэг олгох вэ гэвэл, жишээлбэл 2023–2024 онд шилжих жилд Эль-Нинёгийн урсгалын хор хохирлыг дэлхий нийтээрээ амссан. Энэ нь зөвхөн Монголд биш, дэлхийд болж байгаа үйл явц бөгөөд Эль-Нинёгийн урсгал 2023–2024 онд Монголыг самарсан. Энэ жил дахин эхлэх гэж байна. Өнгөрсөн намар малчдын тэнгэр шинжгүй яаж зөрснийг харах хэрэгтэй. Тэнгэр, байгаль, цаг уураа шинжиж байгаа хүмүүс маш цөөхөн болсон. Иймд энэ мэдлэгийг урьдчилж мэдэх ёстой,

малчдад олгох ёстой...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Оролцогчдод нэг зүйлийг сануулъя. 3 минутдаа багтаан асуулт, үгээ хэлэхийг хичээгээрэй. Эхний 5 хүнээр тасаллаа. Одоо Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Г.Алтанхуягийн цагийг нэг минут сунгая.

Оролцогч Г.Алтанхуяг: Би сая 10 гаруй сум, 2 аймгийн малчдын зөвлөгөөнд оролцсон. Бэлчээрийг үзэхэд зуны сар эхлээгүй байхад ургамал дөнгөж 5 см-тэй, 20 см хүрэлгүй хөгширчихсэн байсан. Үүнийг байгаль, цаг уур урьдчилан хэлж өгдөг. Энэ мэдлэгийг малчдад олгох хөтөлбөрийг гаргаж, дүрэм журмуудыг гаргаж цаашаа явуулахыг хүсэж байна. Мөн сумын малчдад танхимын бус сургалтыг Засаг дарга нар өгөх хэрэгтэй. Гэвч энэ ажлыг зөвхөн сумын Засаг дарга нарт хариуцуулчихаар тэд өөрсдийн дэмждэг хүмүүсээ авчирч, хөндлөнгийн сургагчдад цагийн хязгаар тавьж, ердөө 5 минут өгдөг. 5 минутад малчдад мэдлэг олгох боломжгүй. Тэгэхээр сургалт нийт малчдад хүртээмжгүй болж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тийм ээ, бид үүнийг ойлгож байгаа. Гэхдээ УИХ-ын гишүүд ард иргэдээ төлөөлж байгаагийн хувьд та бүхнийг хөндлөнгөөс оролцуулж байгаа. Нөгөөтэйгүүр Та бүхний саналыг УИХ-ын гишүүд асууж, төрийн байгууллагынхнаас хариултыг авна. Үүнийг та бүхэн ойлгоорой. Одоо УИХ-ын гишүүдийн нэрсийг авъя.

Ерөнхий хяналтын сонсголд оролцож байгаа УИХ-ын гишүүд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан болон сонсголд оролцогчдоос 30 минутад багтаан асуулт асууж, хариулт авч, үг хэлнэ. Эхэлж Б.Уянга гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Б.Уянга: Өнөөдөр сонсголыг зохион байгуулж байгаа болон оролцож байгаа Та бүхэндээ талархал илэрхийлж, энэ өдрийн мэндийг хүргэе. Сая тавьсан гурван илтгэлтэй холбоотой гурван асуулт асууя.

Эхний асуултыг хууль санаачлан батлуулсан гишүүдээс тодруулъя. Энэ хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан байна. 11 журам гарах ёстой байсан бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгааг О.Энххүслэн судлаач танилцууллаа.

Энэ хуулийг батлуулах болсон тулгамдсан асуудлын нэг буюу сонирхол татаж буй хэсэг нь малын тоо бус ашиг шим, чанарыг эрхэмлэх тогтолцоо бүрдээгүй байна гэдэг үндэслэл болсон байна. Тэгвэл Малчны тухай хууль бүрэн хэрэгжихээр яг ямар заалт, зохицуулалт нь малын тоо бус ашиг шим, чанарыг эрхэмлэх тогтолцоог бүрдүүлэх вэ? Энэ заалт нь хэрэгжиж эхэлсэн үү, үгүй юү гэдэг дээр хууль санаачилсан гишүүд хариулаач.

Мөн 2024 оны 06 дугаар сарын 05-нд батлагдсан хуулийн хэрэгжилтийг Хууль тогтоомжийн тухай хуулиар таван жилийн зайтайгаар дүгнэдэг хэр нь хугацаа болоогүй байхад хэрэгжилтийг нь дүгнэсэн байна. Энэ дүгнэх болсон шалтгааныг тодруулъя.

Хоёрдугаар асуулт, О.Энххүслэн судлаачийн танилцуулсан огт хэрэгжээгүй заалтуудыг дахин дурдъя. Малчны хөгжлийн индекстэй холбоотой асуудал хэрэгжээгүй, малчны хөгжлийн сан огт хэрэгжээгүй, малчны хөгжлийн төв хэрэгжээгүй байна. Тэгвэл яг хэн хариуцлага хүлээх вэ? Малчны хөгжлийн санг харахад бүрдүүлбэр нь уул уурхайтай холбоотой гэж байна. Энэ нь журмаар

зохицуулагдах байх. Хэрэгжилтийг хангах хүрээнд үе шаттай арга хэмжээ авах хэрэгтэй болно. Сонсголын төгсгөлд Засгийн газарт шаардлага хүргүүлэх гэж байна уу? Малчны хөгжлийн санг тулгуурлан О.Энххүслэн судлаач өөрийн хийсэн судалгааг нэмж танилцуулаач.

Гуравдугаар асуулт, Боловсролын яаманд хандсан. Танилцуулгад малчны хүүхдүүдэд зориулсан хувилбарт хөтөлбөрийн талаар дурдлаа. Р.Сэддорж гишүүн болон бусад хэд хэдэн гишүүн малчдын хүүхдийг 6, 7 настайд нь сургуульд оруулахгүй байх боломжийг олгох хуулийн төсөл санаачилж байгаа. Хувилбарт хөтөлбөр гэдэг нь яг юугаараа ялгаатай вэ, хэрэгжилт нь хэр явагдаж байгааг хариулаач. Ийм гурван асуулт байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Б.Уянга гишүүний асуултад хариулъя. Эхлээд хууль санаачлагч Г.Тэмүүлэн гишүүн хариулна.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Б.Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ хууль батлагдаад 2 жил гаруй хугацаа өнгөрч байна. Хууль батлагдсанаар Засгийн газраас 11 журам гарах ёстой. Эдгээр журмаас яг ямар журмууд хүлээлттэй байгаа, тэр дундаа таны асуусан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, чанарыг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал орхигдсон уу гэдгийг хөндөж байна. Энэ хүрээнд мал аж ахуйн салбарын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага байна. Энэ салбарт бүтээмж, тогтвортой хөгжлийг ярихгүй бол болохгүй болсон.

Анх удаа энэ хуульд малчин хүний хөдөлмөрийн бүтээмж гэдэг ойлголтыг бий болгож гаргаж ирсэн. Хуулийн 4 дүгээр бүлэг бүхэлдээ малчны бүтээмжийн асуудлыг тавьж байгаа. Энэ бүтээмж дотор тухайн малчин хүний хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (цаашид “ХХААХҮЯ” гэх) болон Засгийн газар тооцдог болох, нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх асуудал багтсан. Бүтээмж дотор анх удаа малчны боловсролыг хуульчилж оруулсан.

Үндсэн суурь асуудлууд нь: нэгдүгээрт, малчны боловсрол; хоёрдугаарт, малын эрүүл мэнд, үржил, технологийн ажлуудыг технологийн дагуу хийх; гуравдугаарт, малын арчилгаа, маллагаа; дөрөвдүгээрт, тэжээлийн хангамж, хашаа хорооны асуудал; тавдугаарт, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх шинэ техник, технологийг дэмжих зэрэг болно. Эдгээр нь тухайн хүний хөдөлмөрийн үр ашиг болон салбарын үр ашгийг нэмэгдүүлэх асуудлууд бөгөөд үүнтэй холбоотой зохицуулалт, журам, аргачлалуудыг ХХААХҮЯ боловсруулж гаргаж ирнэ.

Мөн таны асуусан түүхий эд, малын чанар буюу мал аж ахуйн салбарын чанар, бүтээмжтэй холбоотой асуудлаар чанарын үнэлэмжээс хамаарсан урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх асуудлыг хуулийн 9.4 болон 9.10-д гаргаж ирсэн. Өнөөдрийг хүртэл мал аж ахуйн салбарт урамшуулал, чанарын асуудлууд бусад хуулиар зохицуулагдаж байгаа. Хууль хоорондын уялдааг хангах асуудал, эдгээр зохицуулалт бүрэн бий болоогүйгээс өнөөдрийн үйл ажиллагаанд тодорхой хүндрэлүүд үүсэж байгааг онцлон хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яамнаас Б.Уянга гишүүний асуултад хариулна уу. Өөрийгөө танилцуулаарай.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Б.Уянга гишүүний асуултад хариулъя. 2023 онд Сургуулийн өмнөх болон ерөнхий

боловсролын тухай хуулийг батлахдаа 4 дүгээр зүйлд 5 настай хүүхдийг заавал цэцэрлэгт хамруулах, хэрэв өдрийн бүлгээр хамрагдаж чадахгүй бол 200 цагийн бэлтгэл хөтөлбөрт заавал хамрагдсан байх зохицуулалтыг оруулсан.

Үүнтэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролд хувилбарт сургалт гэдэг ойлголт гарч ирсэн. Малчин өрхийн 5 настай хүүхдүүдийн дотроос хувилбарт цэцэрлэгт хамрагдаж байгаа 10 мянган хүүхдийг 200 цагийн хувилбарт сургалтаар буюу нүүдлийн, гэр бүлд суурилсан сургалтаар сургаж байгаа асуудлыг тайлан мэдээлэлдээ тусгаж танилцуулсан. Хувилбарт сургалт гэдэг нь ийм учиртай зүйл юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчны хөгжлийн сангийн талаар Хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн гишүүний асуултад хариулна уу.

Монголын хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн: Малчны хөгжлийг дэмжих сан нь хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих зорилгоор сум бүрд Малчны хөгжлийн сан байгуулна гэсэн заалттай холбоотой. Сангийн эх үүсвэр нь нэгдүгээрт, мөнгөн урамшуулал буюу урамшууллаас бүрдэнэ.

Түүнчлэн уул уурхайн салбарын орлогоос баялаг бүтээх салбарт хуваарилах хөрөнгийн орлого, малын тоо толгойн албан татвар, хувь нийлүүлсэн хөрөнгө болон түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үндэсний үйлдвэрлэлийн хувь нийлүүлэх хөрөнгө, олон улсын байгууллагын санхүүгийн буцалтгүй зээл, тусламж, мөн хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Сангийн хөрөнгийн зарцуулалтын хувьд 30 хувийг гамшгийн эрсдэлийн үед, 30 хувийг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд, 30 хувийг ногоон, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд, 10 хувийг малчдыг хөгжүүлэхэд зарцуулахаар зохицуулагдсан байна.

Судалгааны багт байгаа хамгийн сүүлийн мэдээллээр Малчны хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын жишиг дүрэм, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүлж байна гэсэн 2025 оны эхний хагас жилийн тайлангаас авсан мэдээлэл байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Б.Уянга гишүүн тодруулна уу.

УИХ-ын гишүүн Б.Уянга: Малчны хөгжлийн сантай холбоотойгоор журам гарч байгаа юм байна гэж ойлголоо. Энэ нь хэрэгжээд явахыг дэмжиж байна. Мөн хувилбарт сургалт нь зөвхөн цэцэрлэгийн насны буюу 5 настай хүүхдүүдэд хамаатай юм байна гэж ойлголоо. Зарим гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөл дээр малчин өрхийн тухайн онд 6 нас хүрсэн хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд элсүүлэн, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтэд үндэслэн 1, 2 дугаар ангийн сургалтад гэрээр, зайн болон цахим хэлбэрээр буюу хувилбарт сургалтад хамруулж болно гэжээ. Үүнийг ер нь дэмжиж байгаа. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалт орж ирэхэд Боловсролын яам хэрхэн хамтран ажиллах боломжтой, энэ чиглэлээр бэлтгэл хангагдаж байгаа эсэх дээр нэг хариулт хэлээд өгөөч.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Малчин өрхийн 7, 8, 9 настай хүүхдүүдийг эцэг, эх нь өөрөө хүсэлт гаргавал сайн

дурын үндсэн дээр гэрийн сургалтаар сургаж болохоор зохицуулна. Энэ дээр төр гэрийн сургалтын талаар тодорхой журам гаргаж дэмжихээр журмын төсөл боловсруулагдаж байна. Р.Сэддорж гишүүний боловсруулсан хуулийн төсөл дээр бид санал өгч дэмжиж, хамтран ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: УИХ-ын гишүүд төрийн байгууллага, тодорхой албан тушаалтнаас асуулт асуух ёстой. Сая Г.Тэмүүлэн гишүүнээс 11 журам боловсруулах ёстой гэсэн асуулт гарлаа. ХХААХҮЯ-наас хариулна уу? Хэдэн журам боловсруулагдах ёстойгоос хэдэн журам боловсруулагдсан бэ? Микрофоны дугаараа хэлж, өөрийгөө танилцуулаарай.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун:

Малчны тухай хууль болон Газрын тухай хуулийн дагуу нийт 10 захиргааны хэм хэмжээний акт, бусад 2 баримт бичгийг батлуулахаар Малчны тухай хуульд хуульчилсан. Үүнээс 9 захиргааны хэм хэмжээний актыг Засгийн газар, 1 арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар, мөн ХХААХҮСайд болон Засгийн газар, 2 журмыг Засгийн газар бусад гишүүдтэй хамтран, 1 сургалтын хөтөлбөрийг дангаар, 1 аргачлалыг Үндэсний статистикийн хороотой хамтран батлуулахаар тус тус хуульчилсан байгаа.

Эдгээрээс Үндэсний статистикийн хороотой хамтран батлах Малчны хөгжлийн индексийн аргачлал хараахан батлагдаагүй бөгөөд одоо санал солилцож байна. Малчны хөгжлийн сангийн журмын төсөл бас боловсруулагдаж байна.

Нийт 11 журмаас 2 нь батлагдаагүй; бусад нь хуучин батлагдсан журамд хамаарч, хэрэгжилт нь хангагдаж байгаа журмууд байна. Батлагдаагүй 2 журмын нэг нь Малчны хөгжлийн сангийн журам бөгөөд үүнийг Сангийн яамтай хамтран батлахаар боловсруулалтын шатад байна. Нөгөө журам нь малчны нийгмийн даатгалын нөхөн төлбөрийг нэг удаа олгож болно гэсэн журам бөгөөд үүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж, холбогдох яамдаас саналаа авч байна. Энэ нь нийтдээ 30–40 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудал учраас хараахан батлагдаж амжаагүй. 2026 оны 1 дүгээр сарын 1 гарсан тул энэ журам батлагдах хугацаа дууссан байна. Тэгэхээр Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байж эдгээр 2 журам цаашид батлагдах боломжтой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчны тухай хуулийн манаач нь ХХААХҮЯ гэдэг утгаар нь асууж байгаа юм шүү. Дараагийн гишүүн С.Замира гишүүн асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн С.Замира: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Малчдын тухай шинэчилсэн хууль яригдаж явна. Би энэ хуулийн ажлын хэсэгт ажиллаж байгаа. Боловсролын яамнаас нэг хоёр зүйл тодруулмаар байна.

Эхнийх нь залуу малчин бэлдэх анги сум бүрд бий болгоно гэсэн заалт байна. Энэ нь хэр боломжтой вэ? Одоогийн байдлаар аймгуудад мэргэжлийн боловсролын сургалтын төв байдаг. Тэр төвүүдэд залуу малчин бэлтгэх анги нээх боломж байгаа юу? Хоёрдугаарт, 6, 7 настай хүүхдүүд сургуульд хамрагдсанаас болоод ихэнх малчид гэр бүлээрээ хоёр хуваагдан хөдөө газар эзгүйрч байна.

Энэ удаа 6, 7 настай хүүхдийг гэр бүлд нь сургах хуулийн төсөл санаачлагдаж байна. Улсын Их Хурлын гишүүд гэр бүлд нь очиж сургана гэхэд ер нь хэр боломжтой вэ? Боловсролын яам энэ талаар судалгаа хийсэн үү? Гэр бүлд

нь очиж хичээл заах, үүнийг яаж зохион байгуулах гэж байгааг хариулаач.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: С.Замира гишүүний асуултад хариулъя. Бид мэргэжлийн боловсролын сургууль, политехник, коллежоо түшиглэн сүүлийн 2 хичээлийн жилд малчин мэргэжлийн хөтөлбөр нээх энгийн зөвшөөрлийг 10 сургалтын байгууллагад өгсөн. Энэ хичээлийн жилд буюу 2025–2026 оны хичээлийн жилд энэ хөтөлбөрөөр 214 залуу суралцаж байгаагаас 70 орчим нь энэ хавар төгсөж байна. Үүнээс гадна мал зүй, хөдөө аж ахуйн чиглэлийн хөтөлбөрүүдийг мэргэжлийн болон техникийн боловсрол, мөн дээд боловсрол дээрээ индекс батлан нээж байна.

Тэгэхээр энэ чиглэлээр ажлууд хийгдэж байна гэж ойлгож болно. Дээрээс нь насан туршийн суралцахуйн төвүүдээр дамжуулан малчдад зориулсан сургалт, нөлөөллийн ажлуудыг аймгийн хөдөө аж ахуйн газар, боловсролын газартай хамтран хэрэгжүүлж байна. Зүүн бүсийг өнгөрсөн намар зохион байгуулсан бол энэ жил хангай, баруун бүсэд зохион байгуулна.

Зөвхөн мэргэжлийн болон техникийн боловсрол гэхгүй, насан туршийн сургалтын төвөө түшиглэн малчдад зориулсан сургалт, үйл ажиллагаа өргөн хэмжээнд зохион байгуулагдана гэж харж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар хүсэлт гаргавал 7 настай элсүүлэх боломжийг олгосон боловч энэ нь малчдын хувьд хүндрэл бэрхшээлийг бүрэн арилгахгүй байна.

Тийм учраас цаашид 8, 9 нас хүртэл гэрийн сургалтаар сурах боломжуудыг судалж, энэ дээр судалгааны ажлууд хийж, туршлага судалж байна. Гэрийн сургалтаар сурна гэдэг нь зөвхөн хүүхэд сургах асуудал биш, гэр бүлтэй нь хамт сургах олон улсын жишиг сургалтын арга зүйг нэвтрүүлэх асуудал юм. Иймд гэр бүлд суурилсан, гэр бүлтэй нь хамт сургах сургалтын технологиудыг боловсруулж, гэрийн сургалтын журмаа шинэчилж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: С.Замира гишүүн тодруулна уу.

УИХ-ын гишүүн С.Замира: Манай Баян-Өлгий аймагт мэргэжлийн сургалтын төв байдаг. Тэнд үсчин, тогооч, оёдолчин, барилгын мэргэжил зэргийг бэлтгэдэг. Тэр төв дээр залуу малчдыг бэлтгэх анги нээх боломж байгаа юу гэдгийг тодруулъя. Ер нь байгаа юу?

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Сургууль эрэлт хэрэгцээгээ тодорхойлж, багшлах боловсон хүчин, хүний нөөцөө бэлтгэж, хүсэлтээ гаргавал сургалтын хөтөлбөрийг эхлүүлэх, нээх зөвшөөрөл олгох бүрэн боломж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн гишүүн П.Батчимэг гишүүн асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн П.Батчимэг: Хөдөө орон нутгаас зорьж, Малчны тухай хуулийн хэрэгжилтийн сонсголд хүрэлцэн ирсэн малчин түмэн, мөн энэ сонсголд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллагын бүх хүмүүст энэ өдрийн мэндийг хүргэе. Малчны тухай хууль бол малчдын хувьд тулгамдсан, хэрэгцээ шаардлагатай, маш ач холбогдол өндөртэй, чухал хууль юм. Харамсалтай нь хууль батлагдсанаас хойш жил хагасын хугацаанд хэрэгжилтийн мэдээллийг сонсоход маш сул буюу ердөө 20 хэдхэн хувьтай гэж тооцогдохоор хэрэгжилттэй байна.

Үнэхээр харамсалтай байна.

Өнөөдөр Монгол Улс 313 мянган малчинтай, 247,900 малчин өрхтэй мал аж ахуйн орон. Малчдынхаа нийгмийн асуудал, эдийн засаг, амьжиргааны түвшин, ажил орлоготой байх, мэргэжил боловсролтой байх зэрэг бүх асуудал, эдийн засгийн хөшүүрэг, ахуй амьдралыг сайжруулах асуудал нь энэ хууль батлагдсанаар хэрэгжих ёстой. Гэтэл өнөөдөр холбогдох яамд буюу ХХААХҮЯ, Боловсролын яам тодорхой ажил хийгээгүй, Засгийн газраас хуулийг дагасан хууль тогтоомж болон тэдгээрийг хэрэгжүүлэх журмууд батлагдаагүй, 6 журам батлагдаагүй байна. Энэ нь юу гэсэн үг юм бэ гэдгийг ойлгохгүй байна.

Хөдөө орон нутагт уулзалт хийхэд Өвөрхангайн малчид асууж байна. Хуулийн 4.2.7-д заасан өндөр настны тэтгэвэр тогтоогоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх заалт хэрэгжих үү? Журам нь гарсан уу? Энэ заалт хүлээлттэй, журам байхгүй байна. Мөн 4.2.7-д гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгохоор заасан. Энэ журам гарсан уу, заалт хэрэгжиж байна уу?

Малчны тухай хууль өнөөдөр энд ирчихсэн малчид болон хөдөө орон нутагт, мал дээрээ байгаа малчид Төрийн ордноос, Засгийн газраас энэ хуулийн хэрэгжилтийг хүлээж байна. Хууль хэрэгжих цаг нь болсон. Хэдийгээр хууль хэрэгжих 5 жилийн хугацааг хүлээдэг боловч энэ хууль өөрөө амьдрал, нийгэм, малчдын амьдралд нэн чухал, хүлээлттэй учраас хэрэгжилтийг нь өнөөдөр чагнаж сууж байна. Орон даяар хүлээж байна. Тийм учраас Засгийн газар ажлаа хийх ёстой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас П.Батчимэг гишүүний асуултад хариулна уу.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: П.Батчимэг гишүүний асуултад хариулъя. Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д заасан гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгоно гэсэн журмыг 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын 79 дүгээр тогтоолоор баталсан байгаа. Ингээд энэ журам хэрэгжээд эхэлж байгааг танд хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яамнаас П.Батчимэг гишүүний асуултад хариулна уу.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: П.Батчимэг гишүүний асуултад хариулъя. Хуулийн хэрэгжилт сул байна, хэрэгжүүлэлтийг сайжруулах талаар анхаараарай гэсэн асуудлыг тавьж байна гэж ойлголоо. Малчны тухай хуулийн 4.2.5-д малчин өрхийн 10 хүртэлх жил мал малласан малчин өрхийн хүүхэд мал аж ахуй, бэлчээрийн чиглэлээр дээд боловсролын төрийн өмчийн сургалтын байгууллагад суралцвал төлбөрийг төрөөс хариуцах заалт хязгаарлагдмал байна гэж малчин өрхийн гэр бүлүүд ярьж байна.

Энэ дээр цаашид эрс эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн тоог мал аж ахуй,

хөдөө аж ахуй болон бусад чиглэлээр өргөжүүлэх шаардлагатай. Малчин өрхийн хүүхдүүд эрэлттэй, тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцах юм бол заавал Малчны тухай хуулиар гэхгүйгээр зээлийн сан, бусад тэтгэлэг, хөтөлбөрт хамрагдах боломжууд байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн гишүүн П.Батчимэг гишүүн тодруулна уу.

УИХ-ын гишүүн П.Батчимэг: Өнөөдөр малчдын амьдрал төдийлөн сайн биш байна. Ган, зуд, цаг агаарын байдал, нөхцөл байдлаас болж малчид мал сүргээ алдаж байна. Өвс тэжээлийн хомсдолтой, газар тариалангийн бүс нутагт ногоон тэжээл, хадлан авах малчдад үнэхээр хэцүү. Тийм учраас малчны хөдөлмөрийг үнэлэх үнэлэмж, малчдын орлого, амьдралын чанарыг дээшлүүлэхэд ямар эдийн засгийн хөшүүрэг энэ хууль батлагдсанаар үйлчлэх вэ гэдгийг бид маш анхааралтай харах ёстой. Малчид өнөөдөр хөдөлмөрийн хүнд нөхцөлд, ган зуданд мал сүргээ алдаж байна.

Нэг зүйлийг бас сануулмаар байна. Энд сайд нар суух ёстой атал Төрийн нарийн бичгийн даргын дарга нар хариулж байна. Сайдынхаа өмнөөс хар толгойгоороо бүх асуудлыг шийдэж, хариулж чадах уу гэдгийг л би асуумаар байна. Үүнийг цаашид бодож, хариултаа хэлээрэй гэж хүсье. Сайд нар өөрсдөө ирж байх ёстой. УИХ-ын гишүүд хуулийн хяналт тавихын тулд Засгийн газраас, өөрөөр хэлбэл тухайн салбарыг хариуцаж байгаа Засгийн газрын гишүүнээс асуулт асууж, хариулт авах ёстой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн гишүүн Л.Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан: Хуульд 10-аас дээш жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй сургана гэсэн байна. Энэ дээр малчдад үнэхээр эрэлт хэрэгцээтэй мэргэжлийг оруулаагүй байгаа юм. Жишээ нь малын эмч. Энэ журмыг Боловсролын яам гаргадаг уу, эсхүл хөдөө аж ахуйн сургуулиас гаргадаг уу? Энэ асуултад надад хариулж өгөөч.

Уг нь орон нутгийн хөгжилд ирээдүйд шаардагдах, орон нутгийн хөгжилд дэм болохуйц мэргэжлүүд зөндөө байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн инженерчлэл, усны инженер, агрономи, хүнсний технологи, байгаль орчин, бэлчээрийн менежмент гэх мэт. Гэтэл ямар ч амьдралд нийцэлгүйгээр ердөө хоёр чиглэлээр л сургаж байна. Дээрээс нь хувийн хэвшлийн сургуулиудад сургаж болох уу?

Мөн энэ хуулийн хамгийн эрэлттэй заалтуудын нэг болох 4.2.9-д заасан нийгмийн даатгалыг нөхөн төлөх хуулийн заалт байна. Энэ нь 2026 оны 01 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө гэсэн заалт орсон. Энэ хуулийг тухайн үед өргөн барьж батлуулсан гишүүдээс зарим нь одоо сайд болсон байна. Бид ажлын хэсэгт ирүүлсэн мэдээллээр бол Нийгмийн хамгааллын сайд Т.Аубакираас энэ заалтыг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн мэдээлэл ирсэн байгаа.

Энэ яагаад боломжгүй юм бэ? УИХ-аас нэгэнт баталсан хуулийг хэрэгжүүлэх ёстой. УИХ баталсан хуулиа хэрэгжүүлэхийн тулд араас нь ажиллах онцгой бүрэн эрхтэй. Тэгээд яагаад энэ журмыг хийхгүй өнөөдрийг хүртэл энэ хуулийн заалт амилахгүй байгаа вэ? Гурав дахь асуулт нь “Орон сууцын ипотекийн санхүүжилтийн журам”-аар малчин өрхийг орон нутагт энэ ипотекийн

санхүүжилтэд оруулна гэсэн боловч өнөөдрийн байдлаар дөрөвхөн хүн хамрагдсан байгаа. Энд гол тээг садаа нь юу байна вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эхлээд Боловсролын яамны төлөөлөл, дараа нь Хөдөө аж ахуйн их сургуулийн төлөөлөл хариулъя. Бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан бэлдэж байгаарай.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Малчны тухай хуулийн 4.2.5-д суралцах мэргэжил буюу мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлал гээд маш тодорхой заагаад өгчихсөн. Үүнтэй холбоотой Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”-д яг энэ 2 мэргэжлээр нь тусгайлаад тэтгэлэг зээлд хамруулахаар заагаад өгчихсөн. Тийм учраас хуулийн заалт, Засгийн газрын тогтоолын дагуу яг энэ 2 мэргэжлээр бид тэтгэлэг олгоод явж байгаа. Энд 2025 онд 15, 2026 онд 8 суралцагч хамрагдаад, 56,1 сая төгрөгийн тэтгэлэг олгож байгаа. Зөвхөн энэ хуулиас гадна бид ХАА-н чиглэлээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ялангуяа мэргэжлийн болон техникийн боловсролын тэргүүлэх болон эрэлтэй мэргэжлийн жагсаалтад мал аж ахуй, мал зүй, мал амьтны эмнэл зүй, фермерийн аж ахуй эрхлэлт, ноос, эсгий боловсруулалт, арьс үслэг эдлэлийн бүтээгдэхүүн гээд ийм мэргэжлүүдийг бас эрэлттэй тэргүүлэх мэргэжлүүдэд оруулж байгаа.

За дээрээс нь дээд боловсрол дээр энэ чиглэлээр мах, сүү, үйлдвэрлэлийн технологи тэжээл, бичил судлалын хөтөлбөрүүдийн индексүүдийг батлаад ахисан түвшний магистр докторын хөтөлбөрүүдийг батлаад, энэ чиглэлээр одоогийн байдлаар 11 сургууль дээр хөтөлбөрүүд хэрэгжээд явж байна гэсэн ийм тоон судалгаа байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь ХААИС. Өөрийгөө танилцуулаарай, 4 номерын микрофон.

Хөдөө аж ахуйн их сургуулийн проректор А.Буянбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ХААИС-ийн сургалт эрхэлсэн проректор А.Буянбаатар байна. Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. ХААИС дээр хуульд заасны дагуу хэрэгжилтийг хангаад мал аж ахуй, бэлчээр, тэжээл судлал гэсэн хөтөлбөр сурч байгаа шаардлагаа хангасан оюутнууд тэтгэлгээ аваад суралцаж байна. Хуульд энэ 2 хөтөлбөрийг заачихсан учраас тэтгэлэг олгож байна. Цаашдаа таны хэлж байгаачлан хуульд өөрчлөлт оруулаад бусад хөтөлбөрүүдийг заах юм бол суралцуулах боломжтой. Ялангуяа төрөлжсөн чиглэлийн хувьд 081 буюу хөдөө аж ахуй гэдэг дотор 10 мэргэжил байна. Таны саяын дурдсанчлан агрономи, мах, сүү судлал, хөрс судлал, ХАА-н инженер гээд мэргэжлүүдээр хөдөө аж ахуй 081 гэж зааж өгвөл олон хөтөлбөрөөр малчдын хүүхдийг сургах боломжтой байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 15 номер.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Малчны тухай хуулийн 4.2.9-д “хуульд заасан өндөр насны тэтгэвэр даатгал тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх” гэж заасан байгаа. Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2024 оны 11 дүгээр сар, 2025 оны 3 болон 9 дүгээр сард ЗГ-ын гишүүдээс санал авах албан бичгийг явуулж

санал авсан байгаа. Энэ хуулийг хэрэгжүүлж эхэлбэл 38158 малчин хамрагдаад эхний жилдээ 4600 малчин тэтгэвэрт гарахад 29,9 тэрбум төгрөг шаардлагатай, хоёр дахь жилдээ 6800 малчин хамрагдахад 42,8 тэрбум шаардлагатай гэх мэтчилэн явсаар эхний 5 жилд 375 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. 2025 болон 2026 оны төсөв.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Б.Рэнцэнханд: Төсөвт энэ хуулийг хэрэгжүүлэх зардал тусгагдаагүй байна. Нийгмийн даатгалын хуульд малчид харьцангуй давуу эрхтэй оролцдог. Тухайлбал, шимтгэлийн 50%-ийг төрөөс хариуцаж төлдөг байгаа. Үүнд 2025 оны хувьд 57600 малчин хамрагдаад 29 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Мөн 2017 оноос эхлээд хэрэгжиж эхэлсэн хуулиар малчид тэтгэвэрт гарах ердийн наснаас 5 жилийн өмнө тэтгэвэрт гарч байгаа. Ингэснээр эмэгтэй малчин 50, эрэгтэй малчин 55 насандаа тэтгэвэрт гарах ийм давуу эрхтэй байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Маргааш Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулга хийнэ. Тэгэхээр тодруулаад асууя. Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан: Малчин айлын нэг хүүхдийг сургана гэдэг дээр “мал аж ахуй” гээд таслал “тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр” гэж байгаа. Мал аж ахуй дотор малын эмч ордоггүй юу, зоо техник ордоггүй юу? Орохгүй гэж үзэж байгаа бол энийгээ тайлбарлаад өгчих. Тэр нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх дээр 375,5 тэрбум, тэгэхдээ энэ 5 жилийн хугацаанд байгаа. Одоо 25 мянган малчин нөхөн төлөлт хийхээр байгаа. 2024 оны 6 сарын 5-ны өдөр энэ хууль гарсан. УИХ-аас батлан гаргасан хуулийг хэрэгжүүлэхгүй гэж байгаа юм уу? 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл Засгийн газар дагаж мөрдөх журмыг батлаагүй байгаа. Засгийн газар ямар хариуцлага хүлээх вэ, энэ хуулийг хэрэгжүүлж чадахгүй гэж байгаа бол одоо шууд энэ хүмүүсийн нүдэн дээр хэлээд өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Энэ бодлогын шинжтэй асуудал шүү. Төрийн нарийн бичгийн дарга хариулаарай. Энэ алдаа хаанаа байгаад байгаа гэдгийг бас харъя. 17 номерын микрофон.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Мал аж ахуй гээд тусдаа бие даасан индекстэй хөтөлбөр байгаа юм. Тэгэхээр тэр хөтөлбөрөөр бид энэ Засгийн газрын тогтоол, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа гэж ойлгож болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Болно гэсэн үг үү?

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Тийм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За 4 номерын микрофон. Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор хэн билээ, өөрийгөө сайн танилцуулаарай.

Хөдөө аж ахуйн их сургуулийн проректор А.Буянбаатар: Би ХААИС-ийн сургалт эрхэлсэн проректор А.Буянбаатар байна. Л.Мөнхбаясгалан гишүүний

асуултад хариулъя. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн нэр индекс шинэчлэн батлах тухай” А146 дугаар тушаалыг бид барьж ажиллаж байгаа. Энэ тушаалаар “мал аж ахуй” хөтөлбөр “081101”, бэлчээр тэжээл судлал “081103” гэсэн ийм индекстэй. Мал эмнэлэг “084101” гээд заачихсан учраас яг энэ хөтөлбөрөөрөө явж байгаа. Тэгэхээр “мал аж ахуй” дотор “мал эмнэлэг” орохгүй, мал эмнэлэг бол тусдаа хөтөлбөр. Төрөлжсөн чиглэлээр 081 нь ХАА гэж байгаа бол мал эмнэлэг 084 байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За яриа зөрж байна. Сайдынхаа өмнөөс хар толгойгоор хариуцаад энэ хүмүүсийн өмнө хариуцлагатай хариулаарай гээд түрүүнээс хойш хэлээд байгаа. Одоо дахиад хэлнэ үү, сайдынхаа энэ тушаалыг өөрчлөх юм уу эсвэл тэр хүн буруу хэлчхэв үү? Төрийн нарийн бичгийн дарга хариулна.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Сайдын тушаалаар энэ хөтөлбөрийн индексийг заачихсан байдаг учраас яг индексийг л барьж ажиллаж байгаа гэж хариулсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Та сая болно гэсэн шүү дээ. Тэгэхээр яана гэсэн үг вэ?

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Энэ МАА гэдэг яг индексийг сайдын тушаалаар 081101 гээд индексээр заачихсан байгаа. Бэлчээрийн аж ахуйг бас ингээд заачихсан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон сонссон биз болно гэсэн шүү. Та тэгэхээр болгох нь эсвэл сайдын тушаал дээр тодруулга хийх нь. Бид энэний учрыг олох гэж өнөөдөр энд сууж байгаа. Түүнээс нэг удаа хариулт өгчхөөд танхимаас гараад зугтахдаа гол нь биш. Л.Мөнхбаясгалан гишүүн бусад асуудлыг маргааш Т.Аубакир сайдыг ирэхээр танилцуулах уу?

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан: За болсон.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ренчинбямбын Сэддорж гишүүн. Уучлаарай гадаа кофе, цай бэлдсэн байгаа учраас хүмүүс одоо үйлчлүүлэхийг урьж байна.

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Өнөөдөр хүрэлцэн ирсэн нийт малчдадаа энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Бурхан Халдун хайрхны төрийн тахилга болж байгаа сайхан өдөр энэ малчны сонсгол болж байгаа нь бол цаанаасаа Монгол түмний заяа байх. Малчдад чиглэсэн төрөөс хууль гаргаж бодлого боловсруулъя гэсэн. Энэ хууль гарах нь маш зүйтэй байсан. 2024 оны 6 сарын 5-нд гарсан хууль, 2 жилийн дараа энэ хэлэлцүүлэг сонсгол болж байна. Сонсгол яагаад болж байна гэхээр энэ хууль маань хэрэгжихгүй байна, сайн хэрэгжүүлэхгүй байна. Засгийн газар, яамд хэрэгжүүлэхгүй байна. Хууль гарчхаад байхад хэрэгжүүлэхгүй байгаа учраас УИХ хяналт хийж, сонсгол хийж байна.

Өнөөдөр Монгол Улс малчдаас үүссэн парламенттай дэлхийн цор ганц улс. Энэ 126 гишүүний өвөг дээдсийг судалбал малчин хүн байгаа. Энэ бол дэлхийд байгаа ганцхан малчдаас бүрдсэн, малчид угшилтай парламент гэдэгт итгэлтэй байгаа. Ийм учраас бид малчид руу чиглэсэн төрийн бодлогыг маш нарийн авч үзэх

хэрэгтэй. Ганцхан үүнээс болж энэ хууль хэрэгжихгүй байгаа тохиолдол ч байхыг үгүйсгэхгүй. 47 сумаар явахад тэд малчдын нийгмийн даатгалын асуудал яагаад хэрэгжихгүй байна вэ, биднийг үйлдвэрлэгч гэж үзэхгүй байна уу, биднийг улс нийгэмдээ зүтгэсэн гэж үзэхгүй байна уу гэж асууж байсан. Энийг төр хариулах ёстой. Энэ хууль гарчхаад байхад яагаад хэрэгжүүлэхгүй байгаа гэдгийг Сангийн яам хариулна уу.

Хоёрдугаарт нь энэ малчдын боловсролын асуудал дээр юу хийсэн бэ? Боловсролын яам энэ дээр бас тодорхой хариулт хэлнэ үү. Энэ хаврын хувьд малчдын амьдрал арай аятайхан байх шиг байна. Хөдөө газар залуу малчдыг тогтоох юм байхгүй байна гэж ярьж байна. Хэдэн морь малаа уяж л залуучууд тогтож байна, бусдаар төв суурин бараадаад дуусах нь гэж ярьж байна. Тэгэхээр энд төрийн бодлого маш чухал шаардлагатай байна, энэ хуулийн хэрэгжилт маш чухал хэрэгтэй байна. Малчдын хүүхдийн боловсролын асуудал ялангуяа 1, 2 дугаар ангийн 6, 7 настай хүүхдийн боловсролыг хувилбарт сургалтаар малчин хүний сонголтоор сургах нь их чухал байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Р.Сэддорж гишүүний нэг минут сунгах уу?

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Тэгье. За тэгээд хөдөө Монгол Улсынхаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг өв соёлтойгоо авч явж байгаа, Соёлын яамнаас нэг төгрөг ч гаргахгүйгээр өөрсдөө өв соёлоо авч явж байгаа энэ малчин түмнээ анхаарахад 1, 2 дугаар ангийн хүүхдийн боловсролыг хувилбарт сургалтаар сургая гэдэг асуудал онцгой чухал үүрэгтэй гэж бодож байгаа. За ингэснээрээ хуучин 10 жилийн боловсролтой ойролцоо очно.

Малчин хүн сонголтоороо сурна, боломжтой бүл хүчтэй айл байна, бүл хүчгүй ч айл байна. Сумын төвд ойрхон айл байна, хол айл байна. Зөвхөн малчин аав ээж, эмээ өвөө нь зөвшөөрвөл тэр хувилбарт сургалтаар төр очиж хичээлийг нь заая гэж байгаа юм. Үүнд Боловсролын яам анхаарч байгаа байх. Энэ хоёр яамнаас энэ 2 асуултаа асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга хариулна уу. 17 номерын микрофон.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Р.Сэддорж гишүүний асуултад хариулъя. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир байна. Малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих арга хэмжээг зохион байгуулах тухай Боловсролын сайдын 2025 оны 77 дугаар тушаал батлаад 4 жилийн хугацаанд 21 аймгаараа энэ тушаалынхаа хэрэгжилтийг хангахаар төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Энэ хүрээнд 2025 онд бид зүүн бүсийн малчин өрхийн хүүхэд залуучуудын боловсролд хамрагдалтын тандан судалгааг 71,8%-ийг нь хамруулаад хийсэн.

Цаг хугацаа орон зайнаас үл хамаараад боловсрол нөхцөл нөхөн эзэмших хэрэгцээт ур чадвараа нэмэгдүүлэх амьдрах ухааны сургалтуудыг бид орон нутгийн Насан туршийн сургалтын төвүүдтэйгээ хамтран зохион байгуулж байгаа. Энэ хүрээнд бэлчээрийн менежмент МАА-н чиглэлээр чадамжийн гэрчилгээ олгох сургалтад зүүн бүсийн 250 гаруй малчин өрхийн залуучуудыг, бусад уур амьсгалын өөрчлөлт, багаар ажиллах, манлайлах чиглэлийн сургалтуудад 700 гаруй малчин өрхийн хүүхэд залуучуудыг хамруулчихсан байгаа. Энэ сургалтаа бид 2026 онд Багахангайн бүс, хойд бүс, төвийн бүсүүдэд үргэлжлүүлээд зохион байгуулаад явж

байгаа. Тийм учраас малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих чиглэлээр Боловсролын яам, Насан туршийн суралцахуйн төвүүдээрээ дамжуулаад сургалт, үйл ажиллагаа зохион байгуулаад ингээд явж байна. Харин гишүүний санаачилсан хуульд бид 2026 оны 5 сарын 26-ны өдрийн албан бичгээр албан ёсоор хариу өгсөн байгаа гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам Анар 17 за Сэддорж гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар байна. Хуулиар хүлээсэн үүргийн дагуу хуулийн 4.2.1-д энэ МАА тогтвортой хөгжлийн бодлогын асуудлуудыг Засгийн газар төсөвт тусган хэрэгжүүлнэ гэж заасан байгаа. Одоо энэ хэсгийн асуулт хариултын дараа манайхаас хэрэгжүүлсэн арга хэмжээ тус бүрээр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд гаргасан санхүүжилтийн дүнгээр танилцуулга дэлгэрэнгүй хийнэ. Тэнд дэлгэрэнгүй харагдах байх. Ер нь хууль батлагдаад хуулийн дагуу салбарын яамд Засгийн газраас баталсан журмын дагуу тухайн итгэлцүүр тооцох аргачлалын дагуу Сангийн яам бол төсөвт тусгаад явдаг. Энэ хүрээнд зохион байгуулалтын ажлыг хийгээд явж байгаа. Дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн танилцуулгаар танилцуулъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам одоо илтгэл тавьчихаад хариулчихъя гэж байна. Р.Сэддорж гишүүн дахиад тодруулъя

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: За баярлалаа. Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх энэ хуулийн заалт яагаад хэрэгжихгүй байгааг тухай Сангийн яам одоо бүрэн гүйцэд хариулах юм байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-г та бүхэн сайн харж байгаа байх. “6.1.Малчны мэдлэгийг дээшлүүлэх сургалт нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгох, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх үйл явцаас бүрдэнэ.” гэж, энэ бол одоо уламжлалаараа явж байгаа. “6.2.Энэ хуулийн 6.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.” гэж байгаа. Энэ дээр 2 яам хамтдаа ажиллах ёстой байсан, энэ дээр ажилласан уу гэдгийг асууя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Боловсролын яам 17 дугаар микрофон. Дараа нь хөдөө аж ахуй дээр хариулъя.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дээд боловсролын салбарт бид мал аж ахуй, хөдөө аж ахуйн чиглэлийн хөтөлбөрүүдийг эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн жагсаалтад оруулж нээж байгаа. Ялангуяа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 10 байгууллагад яг малчны мэргэжлийн хөтөлбөр нээсэн байгаа. Энд энэ хичээлийн жилд 214 хүүхэд суралцаж байгаа албан ёсны статистик байгаа. Нэн ялангуяа ХААИС-ийн харьяа Заамарын Политехник коллеж, Төв аймаг дахь Политехник коллеж, Завхан аймаг дахь Политехникийн коллежийг энэ хичээлийн жилд ерөнхийдөө 70-80 орчим оюутан малчин хөтөлбөрөөр бэлтгэгдэж төгссөн байгаа.

Үүний зэрэгцээ хөдөө аж ахуй, газар тариалангийн мэргэжлийн чиглэлээр 9

хөтөлбөр, хөдөө аж хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 7 хөтөлбөрт нийтдээ 3000 оюутан мэргэжлийн болон политехник коллежуудад суралцаж байна. Тэгээд гишүүний асуултад хариулахдаа хэлж байсан мал аж ахуй, мал амьтны эмнэл зүй, фермерийн аж ахуй, ноос, эсгий боловсруулалт, арьс үслэг гээд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 11 дугаарын микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Р.Сэддорж гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Чадамжид суурилсан залуу малчдад зориулсан энэ сургалтын хөтөлбөрийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 10 сарын 23-ны өдрийн А/535 тоот тушаалаар баталсан. Энийг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тодорхой хэмжээний санхүүжилттэйгээр хамтарсан сургалтын хөтөлбөрийг батлаад, Малчны тухай хууль хуулийн 6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутаг аймаг сумдад сургалтын хөтөлбөрийг хүргүүлээд байгаа.

Сургалтын хөтөлбөрийг нийтдээ 9 чадамжид суурилсан байгаа. Энд мал маллагааны уламжлалт арга технологи эзэмшүүлэх, малыг шилэн сонгох, үржүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах, тэжээл, үйлдвэрлэлийн технологи эзэмших, малын эрүүл мэндийг хамгаал.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Малын гаралтай түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүн боловсруулах, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, мал аж ахуйн бизнес маркетингийг хөгжүүлэх, мал аж ахуйн салбарт хоршиж ажиллах гэсэн ийм 9 чадамжаас суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулаад хэрэгжилтийг хангаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Р.Сэддорж гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан маань агуулгыг сайн ойлгож хариулаарай. Энэ Боловсролын яамаар л хариулуулаад байгаа болохоос танай яам чинь одоо гол яам шүү дээ. Хуулийн 6.5 дээр “Сургалт зохион байгуулсан байгууллага сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчдөд үнэмлэх, тэмдэг олгож, энэ талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.” гэсэн байна. Энэ маш чухал заалт шүү дээ. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтарч эдгээр мэргэжлүүдийг ингэж сургаад малчдадаа мэргэжлийн үнэмлэх, зэрэг дэв олгоно. Энэ бол маш чухал ба энийг яагаад хэрэгжүүлэхгүй байна вэ гэдэг дээр тайлбар авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариулъя. 11 дүгээр микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Сайдын тушаалд энэ заалт орсон байгаа. Тухайлбал “.. сургалтын хөтөлбөрөөр бүрэн суралцсан, үнэлгээний шаардлага хангасан төгсөгчдөд үнэмлэх тэмдэг олгож, энэ талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр тайлагнаж ажиллахыг сургалт зохион байгуулагч байгууллагад даалгасугай.” гэсэн

ийм заалтыг оруулсан. Энэ тушаал 2025 оны 10 дугаар сарын 23-нд батлагдсан учраас цаг хугацааны хувьд одоо тайлангууд бүрэн ирж амжаагүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн тухай шинэ хуулиараа наад боловсролын байгууллагууд чинь ирж байгаа. Одоо хямгадаад аваад явах юм байна. За дараагийн гишүүн Очирбатын Амгаланбаатар гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Г.Тэмүүлэн тэргүүтэй гишүүд Малчны тухай хууль гаргаад, хэрэгжихгүй байна гээд хөөцөлдөж байгаа нь сайшаалтай байна. Г.Тэмүүлэн гишүүнээс 2024 онд хэрэгжсэн “Шинэ хоршоо” зөв байсан уу, зөв хэрэгжүүлсэн үү гэдэг дээр асуумаар байна, энэ хуулийг санаачилсан хүний хувьд хариулт өгмөөр байна. Энд 6, 7 аймгаас малчид ирсэн энд бөөндөө сууж байгаа та хэдээс нэг зүйлийг асууя. Та хэд маань дараа нь бөөндөө ярьж байгаад хариулаадхаарай. Яг малчдын өмнө тулгамдсан асуудлуудыг бүгд сайхан ярьдаг. Ялангуяа их хурлын гишүүд дотроос та нарын зовлон жаргалыг мэддэг хүмүүс маш цөөхөн байдаг.

Тэгэхээр та хэд сум сумаараа, аймаг аймгаараа ярьж байгаад ийм ийм тулгамдсан асуудлууд, хамгийн хүнд асуудлууд байна гээд гурав, гурван зүйлийг хэлээдхээрэй. Хамгийн нэн шаардлагатай 3 асуудлаа хэлээрэй. Тэгэхгүй бол сая О.Энххүслэн зүгээр нэг цаас нийлүүлээд юм оромдчихож. Тэр Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль бүгдээрээ ирээд хариулсан болоод далд орёё гэсэн бодолтой хүмүүс байна. Та нарын зовлонг ойлгоод, та нарын өмнөөс ярьж байгаа хүн бол хэдэн цөөхөн хөдөөгөөс сонгогдсон хэдэн гишүүд байдаг юм. Сая тэр Г.Алтанхуяг гээд урд сууж байгаа одоо 2 номер дээр сууж байгаа залуу бол их зөв зүйл ярьж байна. Боловсролын яамны танилцуулга шал далий юм явж байна.

Та нар энэ малчдын залуу халааг бэлдэх талын юм ярих ёстой байтал хийдэг ажлаа л ярьж байна. Одоо бүгдэд хүртээлтэй ийм зүйл ярьж байна гээд их зөв зүйл хөндөж байна. Тэгэхээр та хэд яг өөрсдөө тулгамдсан хэдэн зүйлийг яриадхаарай. Монголын нийт 230-аад мянган малчны төлөөлөл учраас бүгдээрээ хоорондоо зөвлөлдөөд хэлээрэй. Дараа нь би үг хэлэхдээ дэлгэрүүлээд та хэдийнхээ тулгамдсан асуудлын шийдэл гарцыг ярина. За тэгээд малчид болон Г.Тэмүүлэн гишүүнээс асууж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Малчны тухай хууль дээр бид бүхний хувьд хөдөө орон нутгийн онцлогтой холбоотой, үндсэндээ малчдын эдийн засгийн баталгаатай холбоотой, амьжиргаа орлоготой холбоотой асуудлуудыг онцгойлж анхаарч бүлэг болгож тодорхой зүйл заалтуудаар онцгойлж оруулж өгсөн. Таны асуусан “Шинэ хоршоо”-той холбоотой ч гэдэг юм уу, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахтай холбоотой малчдад үүсэж байгаа эдийн засаг болоод санхүүгийн хүндрэл бэрхшээлийн асуудлыг бид бүхэн хэрхэн шийдэх ёстой вэ, санхүүгийн үйлчилгээний хүртээмж болоод зээл санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдэх ёстой вэ гэдэг агуулгаар таныг асууж байна гэж харж байна.

Хууль дээр оруулж өгсөн асуудал маань үндсэндээ Малчны хөгжлийн сан гэдэг асуудлыг гаргаж ирж тавь, хөнгөлөлттэй болоод нэн хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээг нэвтрүүл, мал аж ахуйн хөгжилд чиглүүлэх энэ хөрөнгө оруулалтуудыг идэвхжүүлж өгөөч гэдэг асуудал байгаа. Яагаад гэвэл энэ чинь өөрөө Монгол

Улсын эдийн засгийн болоод үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон салбар юм.

Өнөөдөр малчдад хамгийн эрсдэлтэй салбар учраас малчдад банкнаас олгож байгаа зээл болоод санхүүжилтийн асуудал хамгийн хүнд байна гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Нийт малчдын 40 хувь нь 400 орчим тэрбум төгрөгийн зээлтэй гэсэн хоёр жилийн өмнө гаргасан судалгаа байгаа. Энэ дүн өнөөдөр хэд болсныг бид мэдэхгүй байна. Та бүхэн 2023, 2024 оны зудын асуудлыг мэдэж байгаа. Тэрнээс болоод олон гамшигт өртсөн малчид малгүй болсон, хөдөөгөөс хот руу шилжсэн, дээрээс нь зээлтэй болсон.

Өнөөдөр дийлэнх малчдын амьжиргаа орлого хүнд байгаагийн нэг бодит илэрхийлэл нь нийт малчдын 6-7% нь дөнгөж мянгаас дээш малтай байгаад байгаа. Тэгэхээр бид нарын хувьд энэ санхүүжилтийн бүтцийг нь зөв болгох, эрүүл болгох, тодорхой хэмжээнд төрөөс бодлогоор дэмжих, хөнгөлөлттэй болоод нэн хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгээд энэ хүрээнд саяын тэр хөнгөлөлттэй зээлийг бид мал аж ахуй үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах буюу суурь дэд бүтцүүд дээр гаргаж өгсөн.

Тэрийгээ хэрэгжүүлээд цаашаа хөнгөлөлттэй зээлийн асуудлыг Малчны тухай хууль дээр дараагийн шатлалын үйлдвэрлэлийг нэмэлт хэрэгцээг нь бий болгоход нь шаардлагатай тухайн тэр худаг ус гаргах, анхан шатны боловсруулалт хийх, тоног төхөөрөмжийн асуудлуудыг гаргаж өгсөн байгаа юм. Өнөөдөр арилжааны банкнууд 22-25%-ийн зээлийн хүүг банканд олгоод байна гэхээр энэ салбар чинь онцгой, байгалийн шууд нөлөөлөл дотор байдаг, эрсдэлтэй салбар гэж үзээд байгаа юм. Гэтэл энийг малчдыг, энэ онцгой чухал стратегийн салбарыг дэмжих зээлийн тодорхой дэмжлэгийг үзүүлэх асуудлуудыг санхүүжилтийн зөрөөг нь шийдэх асуудлуудыг төрөөс хийхээс гарц байхгүй.

Өөр улс оронд Америк ч байна уу, Япон ч байна уу, Европ ч байна уу угаасаа ДНБ эдийн засгийнхаа төсвийнхөө тодорхой хувиудыг гаргаж ирдэг салбар юм. Бид энэ чиглэлээр анхаарах ёстой. Харин саяын магадгүй Шинэ хоршоотой холбоотой асуудлыг та хөндлөө. Тухайн үедээ магадгүй тэр зудын үед үүргээ гүйцэтгэсэн, бид энийг одоо шинэ шатанд гаргаж банк санхүүгийн шинэ үйлчилгээг энэ хуульд заасан мал аж ахуйн Малчны хөгжлийн санг байгуулж, энэ зээлийг олгох асуудлыг шийдэх зайлшгүй шаардлага.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Малчдаас оролцогчдоос 3 номерын микрофонд өөрийгөө танилцуулаарай.

Оролцогч Ц.Бийбат: Булган аймгийн малчин Ц.Бийбат байна. Энэ бол хамгийн чухал асуудлыг өнөөдөр анх удаа Монголын төр хөндөж байгаа. Тэгэхээр хүн болгон хариуцлагатай байх ёстой малчин хүний үг бол өнөөдөр энд орших уу эс орших уу гэдгийг шийдүүлэх гэж байгаа тийм торгон мөч. Олдсон минутдаа ярья, сунгаж өгдөг юм уу. Зовлон бэрхшээл их байгаа. Малчин байх уу эс байх уу гэдэг ийм хэмжээнд хүрчихсэн. Энэ юунаас үүдэлтэй гэхээр уул уурхайг төр давуу байдлаар дэмждэг. Малчид хөдөө аж ахуй дээр ялгавартай байдал бий болсон. Яагаад гэхээр газар тариалангийн бүс нутгуудаар отор хийх боломжтой юу гэдгийг Монгол орныхоо 10 аймгийг судалж 100 гаран гишүүн хувийнхаа зардлаар тойрч судалж үзсэн. Тэгэхэд газрын мэргэжилтэн, Засаг дарга нар голдуу улсууд зуу зуу, мянга мянган га хэмжээтэйгээр нь хэдхэн хүн газрыг нь авчихсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Микрофоны цагийг нь

нэмээд өгье.

Оролцогч Ц.Бийбат: Жил болгон нөгөөхөө томруулна. Тэгэхээр малчид хөлсөө гоожуулаад л хөвөнтэй дээлтэй нөгөө төрөөс хашаажуулсан хашааг нь тойроод малаа туугаад явдаг. Бодлогын яам нь энэ дээр ерөөсөө ажиллаж өгдөггүй. Сая О.Амгаланбаатар гишүүний хэлдэг бол ёстой яг зөв шүү. Тэгээд энэ хоршооны санхүүжилтийг байхгүй болгоход энэ М.Мандхай гишүүн маш зөв юм ярьсан. Одоо сошиал бүх юм нээлттэй байгаа. Малчид дандаа боловсролгүй хүмүүс биш. Их дээд сургууль төгссөн, гадаадын оронд яваад ирсэн, сэтгэлтэй улсууд 10 жил хүлээгээд гацчихсан эрх зүйн орчин байхгүй. Яагаад эрх зүйн орчин байхгүй гэвэл малчин өнөөдөр мянган га-г нэг хүнд, ганц тракторгүй хүнд энэ Хөдөө аж ахуйн газрын дарга нар, сумын Засаг дарга нар, газрын даамлууд байдаг шүү. Энэ дээр шалгалт явуулж өгөөрэй. Малчин бол өвөлжөө хаваржааны дэрсэн дунд, маш гоё бутан дунд, маш гоё бэлчээр дунд байж байхад малчин өвөлжөөнийхөө энүүхэн хавийг ингээд хашаад төл малаа юм уу ингээд оруулчих орчин, нөхцөл нь байхгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За баярлалаа, гол зүйл ер нь сонсчихлоо. Нэг минут сунгачихъя.

Оролцогч Ц.Бийбат: Нийгмийн даатгалыг төлүүлэх мөнгө чинь алдагдахгүй байхгүй юу. Бид нийгмийн даатгалынхаа мөнгийг 450 тэрбум Ундармаа тэргүүтэй хүмүүст алдчихсан шүү дээ. Тэгээд малчид эргүүлээд төлөхөд тухайн цаг үед нь хуулийн ойлголтгүй учраас хугацааг нь давуулчихсан байгаа. Эргүүлээд зуун хувь төлдгөөрөө төлье гэж байгаа, энэ хэрэгжих боломжтой, төлчих боломжтой ийм байгаа. Хоёрт нь өвөлжөө, хаваржааны газрын асуудал. Өнөөдөр чинь ямар нийгэмд амьдарч байгаа билээ. Бусдынхаа өвөлжөөний газрыг хэн дуртай нэг нь идчихээд явдаг, бусдынхаа боломжийг байхгүй болгочхоод байна.

Өвөлжөөгүй мянган мянган малчид байна. Энэ малчин энэ тэр шалгаруулахдаа хөдөө аж ахуйн салбартаа амжилтад хүрч байгаа, оршин нутагтаа юм хийснээр нь харгалзахгүй бол тооны хойноос хөөцөлдөхөөр чинь портороор гэрээ хийчхээд, газрын плиткээр гал тогоогоо хийчхээд хэний газар нутаг сайхан байна гээд л ингээд бусдыгаа хохироогоод яваад байна. Ийм байж болохгүй шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Дараагийн оролцогч 4 номерын микрофон.

Оролцогч Т.Адилбек: Сайн байна уу. Би Дорноговийн Эрдэнэ сумаас ирсэн, энэ өдрийн мэндийг хүргэе. Малчид бид цаг наргүй ажиллаж байгаа шүү, ер нь зовж байгаа шүү дээ. Одоо зун цагт өглөө 4 цагт босно, орой 9 гэж унтана, хэдхэн цагт. Засаг төр энэ хөдөлмөрийг үнэлэхгүй байна. Хөдөө аж ахуйн салбарыг малчид, газар тариалан 2 л авч явж байна. Махгүй гурилгүй бол цаашаа явах боломж хэзээ ч байхгүй шүү дээ. Энэ нөхөн даатгалыг нэг удаа нөхөн төлүүлэхэд яадаг юм. Бид өөрсдөө мөнгөө гаргаад төлчихнө, үнэхээр зовж байгаа, малчдын эрүүл мэнд хохирч байна. Сайд хэлж л байна. Малчид өвдөж байна, ягтаа тултал явж байгаа. Эмнэлэгт үзүүлэхэд болохоо байчихсан байдаг. Тэгтэл нь тултал явж байгаа. Амралтын цаг байхгүй, төрийн албан хаагчид хагас, бүтэн сайн, уртын амралт гээд 2 сар шахуу амарчхаж байна. Бид нарт тийм юм байхгүй. Нөгөө боломжоо хаях ямар ч боломж байхгүй. Энэ улс эх орон, хөдөө аж ахуйн салбарын чинь малчид.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За дараагийн оролцогч, 5 номерын микрофон. Саналаа товч тодорхой хэлээрэй.

Оролцогч Д.Гомбо-Очир: Сайн байцгаана уу. Эрхэм сонсгол даргалагч болон УИХ-ын гишүүд, сонсголд оролцож байгаа нийт малчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе. Малчны тухай хууль батлагдсанаар малчдын хувьд түүхэн шийдвэр болсон. Хоёр жилийн өмнө 2024 оны 6 сарын 5-ны өдөр буюу одоогоос 2 жил 18 хоногийн өмнө энэ энэ хууль батлагдсан. Зарим нэг асуудлууд нь хэрэгжихгүй гацчихсан. Хууль батлагдсанаар яг бүрэн асуудлууд шийдэгдэхгүй, заавал хэрэгжиж байж үр дүн нь гарах учраас хуулиа хэрэгжүүлээд өгөөч. Хууль хэрэгжиж байж малчдын хувьд тулгараад байгаа асуудлуудыг шийднэ. Би Архангайн Жаргалант сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн. Энд ирсэн гол зорилго маань малчдын нийгмийн даатгалыг нөхөн тооцох хуулийг хэзээнээс хэрэгжүүлэх вэ гэдэг хугацаа, улсын төсөвт хэзээ суулгах вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За дараагийн оролцогч 4 номер.

Оролцогч Ц.Баянмөнх: Би говийн бүсийн Айраг сумын уурхайтай газрын малчин. Манай говийн бүсийг уул уурхайн бүс нутаг болгочихсон. Уул уурхай Монголыг тэжээдэг гэж ярьдаг ч биднийг үнэлэхгүй үнэлэмжийг нь алдагдуулсан. Энэ уурхай нэгдүгээрт усыг, бэлчээрийг байхгүй болгож байна, газрыг нь байхгүй болгож байна. Бид яаж оршин тогтнох вэ гэдэг шууд энэ асуудал дээр тулж байна. Говийн бүсийн малчид бид тогтвортой хөгжих нөхцөл алга байна. Одоо энд хууль яриад л эрхээ хамгаалуулах гээд бусад газрын малчид сайхан байгаа. Тэгэхэд бид яаж оршин тогтнох вэ гэдгээрээ байгаа байхгүй юу. Энийг харж үзэхгүйгээр, уул уурхайн асуудлыг оролцуулахгүйгээр энэ хуулийг батлаад явж байгаа нь говийн бүсийн уурхайтай нөхцөлийн энэ малчдаа орхигдуулж, хуулийн гадуур болгочхож байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дахиад нэг минут гүйцэд хариу явуулъя.

Оролцогч Ц.Баянмөнх: Оруулахдаа яагаад малчдад нь мэдэгддэггүй юм, оролцоог нь яагаад хангадаггүй юм бэ? Тэгээд одоо энийгээ явуулах гээд тулган шаардаад байгаа юм уу? Энэ чинь нэг талдаа ингээд дэмжлэг хамгаалалт юм шиг харагдаж байгаа ч хөрсөн дээрээ бол буугаагүй байгаа. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлэх боломж нь хаана байгаа вэ гэж асуумаар байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За О.Амгаланбаатар гишүүн хариулъя.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Та хэд маань сайн хариулсангүй. Малчдын өмнө тулгамдсан тэр олон асуудлаа яриач. Малын гаралтай түүхий эд үнэгүй байна, залуу малчдын гэр бүлийн асуудал, малчдын залуу халааны асуудал, бэлчээрийн талхлахтай асуудал, худаг усны асуудал байна гэх зэргээр нийт Монголын бүх малчдыг төлөөлөөд асуугаад яриад энэ гишүүдэд ойлгуулаадах гэхээр ийм ойр зуурын юм ярьсаар байгаад таарлаа. Говийн малчдын хувьд Айраг сумын малчны хувьд бол ойлгож байгаа. Малчны тухай хууль батлагдаад 2 жил болчихсон, хэрэгжүүлэхгүй байна. Тэгээд араас нь энэ Г.Тэмүүлэн гишүүн нэхэл дагал болоод, энийг хэрэгжүүлээд та нарын эрх ашгийг хамгаалаач гээд явж байгаа. Тэгэхээр саяын хэлдэг энэ Малчны хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрийн 7.3-д “Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр

давхцуулан газар ашиглах эзэмшүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно.” гээд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: О.Амгаланбаатар гишүүний микрофоныг сунгая.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Би дахиад уншаад өгье. Энэ Малчны тухай хуулийнхаа 7 дугаар зүйлийн 7.3-г та нар бүгдээрээ үзээрэй. “Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно.” гээд та нарын тэр өвөлжөө хаваржаан дээр чинь лиценз олгож болохгүй гээд энд хүртэл оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ маань яаж хэрэгжиж байна вэ гэдэг дээр, хэрэгжихгүй байгаа учраас энийгээ хэрэгжүүл гээд энэ төрийнхнийг дуудаж ирээд та нарыг зовлон жаргалаа ярь гэж хэлээд энд цуглачихсан байгаа. Өнөөдрийн сонсгол та нарын эрх ашгийг хамгаалах ийм сонсгол учраас тэр зовлон жаргалаа сайн ярь гэж хэлдэг нь тэр. Өнгөрсөн жил мах үнэтэй байгаад нэг хонь 500 мянга хүрээд нуруу тэнийж байсан чинь Хөдөө аж ахуйн яам уу хаанах юм зохион байгуулалттайгаар шүлхий гаргаад ингээд мал нь үнэгүй болоод эхэлж байна. Энэ дээр бүгдийг нь хөөцөлдөх ёстой. Шүлхийг зохион байгуулалттай тараасан гэж үзэхээр байгаа шүү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тэгж хамаагүй ярьж болохгүй байх, гишүүн ээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Манай хүний яриад байгаа үнэн. Бид энд төрийн байгууллагаас энэ яагаад хэрэгжихгүй байна гэдэг асуултыг асуух гэж, амыг нь асуух гэж энд хүрэлцэн ирсэн. Энэ хуулийг хэн манаж байгаа юм - Засгийн газар, тодорхой сайд нар, тодорхой салбарынхан. Тэгээд тэр өнцгөөсөө хариултуудаа бид авах гээд байгаа. Нэг үг авчихъя. 3 номер түрүүнээс хойш гараа өргөөд байгаа юм тодорхой товчхон хэлчихье.

Оролцогч Н.Баярсайхан: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Би Дорноговь аймгийн Айраг сумын малчин байна. Хамгийн тулгамдаад байгаа асуудал нь ус, бэлчээр газар шороо. Түрүүний гишүүний хэлдгээр манай газар дээр маань уул уурхай давхардуулаад 2 өвөлжөө хаваржааг маань хоёуланг нь ингээд давхардуулаад өгчихсөн. Энэ нөхцөл байдлыг хаана шийдэх вэ? Энэ 7.3-д заасан энэ 52.7-д зааснаар эхлээд газар эзэмшигч иргэн нь байх ёстой байтал өвөлжөө хаваржааг маань давхцуулаад олгочихсон байгаа. Энэ тэгээд хариуцах эзэн байдаггүй. Усны асуудал бол гүн усны асуудал болохоороо нөгөө уул уурхайгаас болоод бүх говь усгүй болох гээд байна. Гүний усыг маань уул уурхай бүр замбараагүй шоо метрээр хэрэглээд байна. Бүр ямар ч хариуцлагагүй, хариуцлагагүй уул уурхайгаас болоод бид одоо малаа маллах бэлчээргүй болоод байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Саналаа хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Малчны тухай хууль бол чухал. Малчин өөрөө хуультай болж хуулиар зохицуулагдаж, хамгаалагдах ийм учиртай хууль гэж харж байгаа. Тэгсэн хэдий ч Малчны тухай хуулиар маш олон өргөн цар хүрээтэй асуудлуудыг угаасаа тусгасан байгаад байгаа. Эрүүл мэндийн асуудал, нийгмийн даатгал, хөгжил боловсрол, үйлдвэрлэл түүхий эдийг эргэлтэд оруулах гээд маш өргөн цар хүрээтэй. Тэгсэн мөртөө санхүүгийн ямар эх үүсвэрээр, ямар бүтцээр зохион байгуулах вэ гэдэг нь өөрөө

хуульдаа тодорхойгүй тусгаад өгчихсөн. Тийм учраас эзэн би олдохгүй, хаанаас ямар санхүүгийн эх үүсвэрээр тооцох гээд байгаа, баахан журам гаргах хэрэгтэй болчихсон. Яг үнэн хэлэхэд Засгийн газрыг төлөөллөөс өнөөдөр энд сууж байгаа гишүүдийг буруутгахгүй байх гээд байгаа юм. Хууль өөрөө тодорхой байхгүй бол маш олон хуультай, бодит байдал дээр хэрэгжихгүй байна гэдгийг сая орон нутгаар явахад малчид бүр хэлж байна. Хэрэгждэггүй, баахан хуультай, тодорхойгүй, журам нь хэзээ ч гардаггүй ийм хууль. Одоо үйлдвэрлэлийг бид больё гэдэг асуудлыг хэлж байгаа. Тэгэхээр би хууль санаачлагчаас нэгдүгээрт энэ бүтцийг, санхүүгийн эх үүсвэр зардлын тооцоог юу гэж тусгасан юм бэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт эрүүл мэндтэй холбоотой нийгмийн даатгалаас гадна эрүүл мэнд нийгмийн даатгалын хэрэгжилттэй холбоотой тайлангаа тавиац. Эрүүл мэндийн үзлэгт малчдыг жил бүр үнэгүй хамруулна гээд оруулчихсан. Энэ тэгээд ямар асуудал болсон бэ гэдгийг мэдмээр байгаа юм. Нийгмийн даатгал дээр бол 5 жилийн хугацаанд нийлээд 375 тэрбум төгрөг төсөвт шаардлагатай байгаа учраас ингээд санхүүгийн үүсвэр нь шийдэгдэхгүй болохоор ингээд бид төлж чадахгүй байна гэдэг хариултыг авлаа гэж ойлголоо. Зөв үү?

Гуравдугаарт энэ урамшуулал санхүүгийн дэмжлэг байгаа, энэ хөдөө аж ахуйн үндэсний одоо энэ санхүүгийн дэмжлэг дээр танилцуулга үндсэндээ Шинэ хоршоон дээр 894,8 тэрбум, Хүнсний хангамж аюулгүй байдал 1,2 их наяд, Цагаан алт 520 тэрбум гээд сүү, ноос, арьс шир гээд бусад төрлийн урамшууллууд байгаа. Тэгээд би энэ малчдаас асууя гэж бодож байна. Ганцхан говь биш Булганаас ирсэн байна, бусад аймгуудаас ирсэн байна. Энэ бодитой хүнсний хангамж, аюулгүй байдал, Цагаан алт хөтөлбөр, Шинэ хоршоо, тэр сүү, ноос, арьс ширний урамшууллыг яг бодитой авч чадсан уу? Энэ их хөдөлгөөнүүд малчдад бодитой хүрсэн үү? Авсан бол хэдэн төгрөгийн зээл авсан юм бэ гэдгийг энд байгаа малчдаас асуумаар байгаа юм. Тэгж байж бид дараагийн тодруулах асуулт руугаа орно. Залуу малчдыг бэлтгэх, залуу малчид, мал бүхий иргэдийн дунд Малчны хөгжлийн санг байгуулах асуудлыг хуулийн 7.5.3-д заасан байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За хариулья. Г.Тэмүүлэн гишүүнээс эхэлье.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Би өнөөдөр маргааш энэ 2 хоногийн хугацаанд энэ хуулийн ерөнхийдөө үндсэн гол сэдвүүдийн асуудлуудаар ярилцана. Бид нарт 9 үндсэн сэдэв байгаа. Тэгэхээр танаас би асуусан санхүүгийн үйлчилгээ, бусад тэр эрүүл мэнд зэрэг асуудлуудыг тухайн сайдууд нь орж ирээд тайлангуудаа тавих байлгүй дээ. Энэ хуулийн сонсгол хийж байгаа асуудал бол өнөөдөр хууль засаглаж байгаа юм уу эсвэл хүн засаглаад байгаа юм уу эсвэл сайд нар үзэмжээрээ асуудлыг шийдээд байгаа юм уу эсвэл хууль дүрэм журмынх нь дагуу ажиллаад байгаа юм уу гэдэг асуудлыг л бид нар өнөөдөр энд хийх гээд байгаа юм. Өнөөдөр Үндсэн хуулийн зөрчил үүсчихсэн учраас УИХ-ын өмнө үүрэг хүлээсэн Засгийн газар нь хууль хэрэгжүүлэхгүй, журмыг нь гаргахгүй байгаа учраас бид өнөөдрийн сонсголыг хийж байгаа юм. Энэ хэлэлцэж байгаа сэдвийн асуудал бол үндсэндээ малчны хөгжил, залгамж халаа залуучуудтай холбоотой асуудал.

Өнөөдөр хөдөө орон нутаг чинь эзгүйрлээ, залуучуудын хорьхон хувь нь энэ малчдыг бүрдүүлж байна. Энэ дээр төр засаг нь ямар бодлого гаргаж байгаа вэ, хүн хүн ам зүйн бодлого чинь алдагдсан байна. Мянган мэргэжлийн эзэн гэж бид бүхэн ярьдаг энэ том мэргэжлийг бид нар цаашид өв уламжлал болгож залуучуудаа үлдээхэд юун дээр анхаарч байгаа юм гэдэг асуудлуудыг уг нь хөндөж

ярих ёстой болчихоод яриад байгаа юм. Энэ дотроос би тодорхой бүр хэрэгжихгүй байгаа асуудлуудыг уг нь хэлмээр байгаа юм. Насан туршийн боловсрол олгох асуудал чинь энэ 6 дугаар бүлэг буюу үндсэндээ энэ малчныг хөгжүүлэх тусгай хөтөлбөрийг гарга гэдэг асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд дээрээс нь Боловсролын яам дээр гаргаж өгсөн. Сургагч малчин хөтөлбөрийг нэвтрүүл гэдэг асуудлуудыг аймаг орон нутгуудад үүрэг даалгавар болгож өгсөн. Дээрээс нь малчин мэргэжлийн зэрэгтэй үнэмлэх олгох асуудлыг гаргаж ирж тавьсан. Бид ахмадуудын маань ярьдаг мянган мэргэжлийн эзнээ бид нар өнөөдөр илүү мэргэжил болгож өгсөн, болгож хөгжүүлэх залуу үе хойчид үлдээх энэ асуудлуудыг гаргаж ирж тавьж байгаа юм.

Аймгийн төв болгоноор дамжуулж бид энэ насан туршийн боловсрол олгох сургалтын системийг нь хөгжүүлээч, сум багт хүрч ажиллаач, сургалтын төвүүдийг аймгийн төвийн МСҮТ-ээр дамжуулж хөгжүүлээч гэдэг асуудлуудыг хуульчилж оруулж өгсөн нь байгаад байгаа юм. Тэгэхээр энэ салбар, салбар яам болгон чинь энэ амьдралаас урган гарсан асуудлуудыг шийдэх хуулийнх нь зохицуулалтууд нь нэг бүрчлэн бодлогынх нь түвшиндээ хараад хийчихсэн байгаа. Адаглаад хөгжиж байна, цахим сургалтыг хийх асуудал байгаа. Сэтгэл байвал уг нь ажил болдог асуудал. Тэгэхээр энэ хүрээндээ тодорхой чиглэлээр бид явах ёстой. Саяын газартай холбоотой асуудлыг асууж байна. Энэ өвөлжөө хаваржааны газар дээр давхцуулсан асуудлыг бид хориглож өгсөн.

Дээрээс нь өвөлжөө хаваржааныхаа газар дээр тэжээл тариалах эрхийг нь хуулиар оруулж өгсөн. Өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт ямар хэмжээнд хангалттай байна вэ гэдэг асуудлыг бид ярих ёстой. Хэрэв тэнд зөрчил үүсэж байвал та таныг төлөөлсөн төлөөлөлдөө эсвэл УИХ-д бид нарт энэ хүсэлтийг гаргаж өгөх ёстой байгаа. Бид магадгүй холбогдох журмынх нь дагуу араас нь өргөдөл хүсэлтийг нь тавиад шийдвэрлэхээр ажиллах ёстой. Яагаад гэвэл энэ дээр бас.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүч нэмэхэд ард иргэд та УИХ-д тооцоо бодох ёстой. Улсын Их Хурал Засгийн газартайгаа тооцоо бодох ёстой. Энэ том улсын хэмжээнд гүйцэтгэх засаглал хэрхэн ажиллаж байгаа, салбар болгон дээр яаж ажиллаж байгаа тэр тусмаа хөдөө аж ахуйн салбар дээр хэрхэн ажиллаж байгаа, ямар хариуцлагатай ажиллаж байгаа гэдгийг бид УИХ өөрсдөө хариуцлага тооцохгүй бол өөр хэн ч хариуцлага тооцохгүй. Тийм болохоор өнөөдрийн энэ ач холбогдлыг бид тодруулж хэлээд байгаа шүү. Энд байгаа төрийн албан хаагчдаас хэдүүлээ асуултыг нь асууя. Яагаад энэ хууль хэрэгжихгүй байна, яагаад ийм проблемууд гараад байна, энийг хэрхэн засах юм гэдэг л хамгийн гол асуулт энд байгаа. Тийм болохоор өнөөдөр төрийн байгууллагынхны хүлээлгээд сууж байгаа. За хариултаа цааш нь явуулъя. Малчдаас асуусан нэг хүн хариулъя. Хэдэн номер вэ, 2 дугаарын номер 2.

Оролцогч О.Отгонцэрэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би О.Отгонцэрэн. Архангай аймгийн Хашаат сум. Энэ залуу малчин, залгамж халаа гээд Малчны тухай хуулийн 4.1 дүгээр зүйл заалттай. Одоо энэ залуу малчин залгамж халаа үнэхээр байхгүй болж байгаа. Энэ нь эрүүл мэндийн баталгаатай холбоотой. Дээрээс өнөөдөр амьдрах орчин бүрдэхгүй байгаа. Амьдрах орчин гэдэг та бүхэн бүгд мэднэ. Монголд 60 сая малтай. Энэ 60 сая малаа эргэлтэд оруулдаг, эдийн засгаа нэмэгдүүлдэг аж үйлдвэрүүд байж байгаа. Тэр хөдөө орон нутагт ажиллаж амьдрах орчин бүрдэх гээд байна. Хуулийн 4.4 дээр заасан байна. Нөгөө жендерийн байдал алдагдсан. Гэр бүлийн төлөвлөлтийн асуудал гээд олон асуудал энэ амьдрах орчин нь бүтэхгүй байгаа учраас ийм асуудал үүсээд байгаа юм. Тийм учраас өнөөдөр жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгч магадгүй нөгөө

хоршоо гээд л ийм асуултууд байна.

Тэгээд энэ маань амьдрал дээр яг бодитоор хэрэгжихгүй байгаа юм. Нэг талаасаа малчид өрхийн хэмжээнд жижиг дунд бизнес эрхлээд байдаг борлуулалтаар нь дэмждэггүй. Магадгүй энэ сум орон нутаг, сургууль, эмнэлэг, цэцэрлэг гээд 3 байгууллага байна. Энд малчин хүн өнөөдөр өөрийнхөө хийсэн бүтээгдэхүүнээ өгье гэхээр тендерт орчихсон байх, аж ахуй нэгж байх босго тавьчихсан, нөгөө босгоо давдаггүй. Тэгээд давахгүй болохоор тухайн орон нутгийн төрийн албан хаагчийн хамаарал бүхий аж ахуй нэгж компани эсвэл хаа нэг газрын аж ахуй нэгж компани ирээд нөгөө үйлдвэрлэлээ өөрөө өрхийн хэмжээндээ хийж байгаа бичил бизнес эрхэлж байгаа хүмүүсийнх нь бүтээгдэхүүнийг аваад, орон нутагтаа импортын бараагаар хүртэл ингээд явчихдаг. Өнөөдөр орон нутгийнхаа залуу малчдыг дэмжих гэж байгаа бол, залуу малчдаа хөдөө байлгая гэж байгаа бол хийж байгаа бүтээгдэхүүнээр нь дэмжээч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий санаа гарчихлаа. Татаас урамшуулалтай холбоотой асуудал дээр малчдаас асууж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газартай холбоотой асуудал дараа дахиж орж ирэх тэр үед асууя. М.Мандхай гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Би тодорхой хэдэн асуултыг асуусан юм. Нэгдүгээрт хуулийн 7.5.3. Ер нь энэ сумын Засаг дарга өөрөө ийм чиг үүрэг хэрэгжүүлэх үүрэгтэй байгаад байгаа юм. Өнөөдөр энэ дээр хэн хариулах ёстой вэ? Энэ 7.5.3 дээр залуу малчид, мал бүхий иргэдийн залгамж халааг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр авах арга хэмжээ, олон сургалт зөвлөгөөнүүдийг хийх ёстой. Яг ийм чадавхжуулах сургалтууд, залуу малчдыг бэлтгэж байгаа бодитой ажил сумын Засаг дарга чинь хийж байгаа юм уу гэдгийг асуумаар байна. Хоёрдугаарт урамшуулалтай холбоотой асуудал. Цагаан алт, Хүнсний хувьсгал гэдэг том том хэдэн их наядаар гарсан хөтөлбөрүүд байгаа. Яг бодитой малчин авсан, хэдэн зээл авсан, ямар үйл ажиллагаа явуулж байгаа, танай аймаг сумд хүрсэн үү гэдгийг тодруулж асуумаар байна. Ерөөсөө ингээд бодитой хэрэгждэггүй гэж түрүүн нэг малчин хэлж байсан. Төрөөс үзүүлсэн баахан дэмжлэг байгаад байдаг эргээд энэ нь бид нарт хүрдэггүй учраас ингээд энэ хөдөлгөөн чинь.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Энэ сонсголоос бид тодорхой хэмжээний шийдвэр гарч Засгийн газарт өгөх ёстой. Тийм болохоор та бүхэн маань тодорхой шийдвэрүүдээ хэлээрэй. 12 номерын микрофонд боломж олгоё.

Оролцогч Ш.Ариунаа: Асуулт асуусан М.Мандхай гишүүнд баярлалаа. Би Монгол Улсын иргэн Шагдарсүрэнгийн Ариунаа гэж хүн байна. Энэ сонсголд орохын тулд Өвөрхангай аймгийн Уянга сум, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур, Хэнтий аймгийн сумуудынхаа хамтарч ажилладаг хүмүүсээс нэлээн лавлаж тодруулсан. Надаар ямар үг дамжуулсан гэхээр Засаг дарга нар таны асууж байгаа энэ 7 дугаар зүйл заалт дээр бид чадахгүй, энэ төрлийн сургалт хаанаас хийх, яаж хийх асуудал, бид нарт энэ хуулийг хэрэгжүүлэх ямар ч боломж алга энийг асууж, хэлж өгөөч гэсэн. Би багийн даргатай ч уулзаж үзсэн. Өвөрхангай аймгийн Уянга сумын Шуранга багийн даргатай уулзсан. Засаг дарга нар энийг яагаад хийж чадахгүй гэж хэлж байна гэхээр “Бид хуулиа ч сайн ойлгоогүй байна. Дээрээс нь бид нарыг өөрсдийнхөө мөнгөөр энэ сургалтын төсөл хөтөлбөрийг гарга гэх юм.” гэж.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сая Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг миний бие ахлаад батлуулсан. Энэ хууль дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан мэдэж байгаа. Босоо тогтолцоо болгоё гээд байсан, хүлээж аваагүй больсон. Яагаад ингэж босоо тогтолцоо хүсээд байгаа гэхээр сумын дарга, аймгийн дарга нар чинь та нарын гаргасан бодлогыг хэрэгжүүлэхгүй байна. Энэ хүмүүс чинь хэлээд байна.

Энэ Боловсролын яамны сайдаас гаргасан асуудлуудыг тэр доор очиж чадахгүй байна. Тэгэхээр босоо тогтолцоо байгаад энэ завсрын үед энэ тогтолцоогоо сайжруулах үед өөрчлөлтийнх нь үед босоо байж байж тэр Засаг дарга, тэр суман дээр байж байгаа хүмүүс чинь энэ сайд нарын гаргасан бодлогыг хэрэгжүүлдэг ийм тогтолцоо байх хэрэгтэй болчихоод байгаа. Тийм болохоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан хариулаарай. Яагаад тэр Засаг дарга нар та нарын бодлогыг хэрэгжүүлэхгүй, бид мэдэхгүй, бид ийм сургалт явуулж чадахгүй, бид энэ бодлого гаргаж чадахгүй гээд суугаад байгаа юм бэ, энийг хэдүүлээ яаж засах вэ? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 11 дүгээр микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Малчны энэ журмуудыг орон нутагт хэрэгжүүлэхэд зөвхөн нэг байгууллагын, нэг талын оролцоо биш, олон талын оролцоо хамгийн чухал байгаа. Мэдээж хууль хэрэгжүүлэх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, холбогдох журмуудыг батлах үүрэг нь бидэнд байна. Энийг хэрэгжүүлэх нь тодорхой хэмжээнд орон нутагт аймгийн түвшинд, сумын түвшинд хэрэгжилтийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага байна. Бид баталсан хууль журмуудыг тодорхой хэмжээнд орон нутагт хүргүүлж хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах вэ гэдэг дээр заавар зөвлөмж өгч ажиллаж байгаа. Мэдээж тогтолцооны бас асуудал байгаа. Орон нутагт тогтолцоогоо дагаад л хэрэгжүүлэх асуудлыг нь шат шатдаа биелүүлэх нь тухайн шатын байгууллагуудын үүрэг оролцоо гэж үзэж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хангалтгүй л байна даа. Татаас урамшуулалтай холбоотой асуудал дээр хэлэх хүн байна уу? Татаас урамшуулал авсан хүн байна уу? 4 номерын микрофон. Хуульд заасан татаас урамшуулал авсан уу?

Оролцогч В.Оюундэлгэр: Говьсүмбэр аймаг. Ноос ноолуурын урамшууллыг сүүлийн 3 жил олгоогүй. Цагаан алт хөтөлбөрийг болохоор яагаад вэ гэхээр аймаг дээр зарлагдаж байна гээд л тэрхэн шатандаа, тэгээд хэрэгжиж байгаа юм байхгүй. Говьсүмбэр аймгийн хэмжээнд Цагаан алтыг аваад тэгсэн ингэсэн гэсэн тийм юм бол одоогоор мэдээгүй байгаад байгаа юм. Ноосны урамшуулал сүүлийн хэдэн жил бол бүгд олгогдоогүй авагдаагүй байгаа шүү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Мандхай гишүүн.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Харин ийм байгаа юм. Би сая Сүхбаатар аймгийн 9 сумаар явлаа. Энэ Хүнсний хувьсал, Цагаан алт, Шинэ хоршоо гэдэг хөдөлгөөнүүд ноос ноолуурын урамшуулал, сүүний урамшууллуудыг бүгдийг нь асуулаа. Авсан нэг ч сум алга, авсан нэг ч малчин алга. Тэгэхээр энэ хөтөлбөрүүд чинь ерөөсөө бодитой үр дүн гаргахгүй байгаа юм. Асуудал нь хоёрдугаарт энэ нийгмийн даатгалтай холбоотой асуудал. Бид холбогдох яамд нь анхаармаар байгаа юм. Яг үнэнээ хэлэхэд энэ малчид мал аж ахуйн уламжлалт амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангаж байгаа. Зэвсэгт хүчний тусгай албан хаагчдыг

үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг хангаж байгаа гээд нийгмийн даатгалын шимтгэл төлүүлдэггүй, тусгай хуулиар зохицуулдаг. Тэгэхээр энэ малчид чинь эдийн засгийн эмзэг бүлгийг хамгаалахаас гадна хүнсний аюулгүй байдлыг хангаж байгаа чухал бүлэг юм. Тэгэхээр энэтэй адилхан тэр тусгай.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 11 дугаарын микрофон Ц.Болорчулуун хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Энэ хөтөлбөрүүдийн санхүүжилттэй холбоотой асуудал дээр тодорхой тайлбарыг өгье. Хөтөлбөр болгон өөрсдийн тодорхой дэвшүүлсэн зорилго, зорилттой байгаа. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний зорилт бол гол 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодыг хангаж, улмаар экспортлох, экспортын бүтээгдэхүүнийг дэмжинэ гэсэн ийм зорилттой.

Энэ хүрээндээ үндсэндээ нийт гаргаж байгаа зээлийн санхүүжилт нь хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд 60% нь газар тариалангийн үйлдвэрлэлд 28% нь үлдэж байгаа. 22%-ийн 8% нь мал аж ахуйн салбарт олгогдсон байх жишээтэй. Цагаан алт хөтөлбөр бол ноос ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн боловсруулалтын түвшнийг 2 дахин нэмэгдүүлнэ гэсэн ийм зорилттой. Энэ хүрээндээ боловсруулах үйлдвэрүүдэд олгогдож.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Өнөөдөр тойрогт ажиллаад хөдөө сумд ард иргэдтэй уулзаад явахад олон асуудлыг ярьдаг. Тэр тусмаа малчны тухай асуудал. Монгол Улсын нийт өрхийн ¼ нь малчин өрх байдаг. Монгол Улсын эдийн засагт бол маш том үүрэг гүйцэтгэх салбар бол мал аж ахуй. Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т мал сүрэг бол үндэсний баялаг мөн төрийн хамгаалалтад байна гээд ингээд заачихсан. Тэгээд тусгайлан хууль гарсан. Одоо малчдын нийгмийн асуудал, эрүүл мэндийн асуудал, мөн дээрээс нь эдийн засагтай холбоотой асуудал гээд энэ хуулиар багцалж гаргахыг оролдсон байгаа. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилт маш муу, иргэдээс энэнтэй холбоотой маш их санал гомдлуудыг гаргаж байна. Тэрний нэг бол малчдын нийгмийн даатгалыг нэг удаа нөхөн төлүүлэх хууль байгаа юм. Үүнтэй холбоотой яам нь боломжгүй гэдэг хариугаа ирүүлчихсэн. Энийг одоо нууж хаагаад байх юм ерөөсөө байхгүй.

Миний бие Төсвийн байнгын хороонд ажилладаг. Яамнаас нэг тодорхой байр суурийг бол илэрхийлдэг. Боломжтой юу, боломжгүй юу гэдэг дээр эхлээд хуулийг санаачлаад хууль батлагдах үед яамдаас санал авдаг. Их хурал баталсан учраас хэрэгжих нь бол зөв өө. Өнөөдрийн сонсголын гол ярьж байгаа асуудал энэ байгаа юм. Нийтдээ эхний тооцооллоор бол 38158 иргэн байгаа юм. Нийтдээ 400-аад тэрбум төгрөг 5 жилд ингээд нөхөн төлөгдөөд л явахаар тэгээд төсөв дээр ачаалал үүслээ гэж үзээд байгаа юм. Энд иргэдээс өөрсдөөс нь төлөх мөнгөн дүн нь хэд бэ, энэ журам боловсруулах явцад гарч байгаа тоо судалгаа байна уу гэж нэг дэх асуулт нь.

Хоёрт нь малчин хүний асуудал ярихаар ойлгомжтой цаана нь мал аж ахуй, тэгээд Монгол Улсын эдийн засгийг авч явж байгаа энэ салбарын асуудлыг заавал ярих шаардлагатай. Малчдын, малын өвчлөлтэй холбоотой асуудлыг энэ хуулиар

нэг их сайн оруулж өгөөгүй байгаа юм. Өвчлөл маш их гарч байна л даа. Зүүн аймгууд шүлхий гэдэг өвчин байдаг гэж ойлгодог байсан бол одоо баруун аймгууд тэр чигээрээ боллоо. Энийг хамгаалах дээр ямар ажил хийж байгаа талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас асуумаар байна.

Дараагийн асуудал малын индексжүүлсэн даатгал гээд байгаа. Тэгээд баахан малчдаас мөнгө авдаг. Эргээд иргэд маань гоц халдвар, байгалийн гамшиг зэрэгт малаа алдчихдаг, нөхөн төлүүлэх асуудлыг яаж даатгалаас олгодог бэ? Миний ойлгож байгаагаар сум, аймаг, бүс нутаг болгон аваад явчхаж байгаа юм. Тэгтэл жирийн иргэн машинаа мөргөлдүүлэхэд шууд л газар дээр нь даатгалын компани ирээд төлчхөж байгаа. Тэгэхэд бид малчдынхаа малыг даатгуулах асуудал дээр яагаад өөрчлөлт гаргахгүй байгаа юм бэ гэдгийг салбарын яам, хуультай холбоотой Г.Тэмүүлэн гишүүн бас энэ хуульд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За хариулъя. Шууд нэг минутаар сунгая. Д.Жаргалсайхан гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудал дээр бас Тэмүүлэн гишүүд ямар санал бодолтой байдаг вэ гэдгийг хэлж өгөөч. Дараагийн асуудал бол хуулийн 7.5.1 дээр байгаа сургалтууд байгаа. Энэ сургалтуудыг явуулах боломжтой байдаг. Одоо жишээ нь би Баянхонгор аймгийн Засаг даргаар 2012-2016 онд ажиллаж байсан, тэгэхэд малчдыг сургах ажлыг хийж байсан. Хүүхдүүд амраад явчихад аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиуд, мэргэжил сургалт, үйлдвэрийн төвүүд гээд бүгдээрээ хоосон болдог. Дотуур байранд нь малчдаа байршуулаад 4000 малчныг сургалтад хамруулж байсан.

Тэгээд ийм ажиллагаануудыг аймгийн, орон нутгийн, төсөвт байгууллагын болон бусад материаллаг баазыг ашиглаад явуулах бүрэн боломж байдаг. Жишээ нь би ингэж явуулж байсан юм. Тийм учраас аймгийн дарга нар бусад төрийн байгууллагууд ийм байдлаар малчдын сургалтыг заавал явуулж байх ёстой. Ийм асуултуудад та бүхэн хариулж өгнө үү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Түрүүн өвчин албаар тараадаг гээд О.Амгаланбаатар гишүүн хэлсэн. Тэрэнд Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл хариулт өгнө шүү. Та бүхэн Тагнуулын газар болон бусад байгууллагатай хамтраад шалгасан байх ёстой. Тэрнийхээ хариуг хэлээрэй, буруу мэдээлэл гаргах гээд байна. Г.Тэмүүлэн гишүүн.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагчийн хувиар би хариулж байгаа. Энэ хүрээнд үндсэндээ энэ хуулийн хөгжлийн зээл дэмжлэг, санхүүгийн үйлчилгээ, даатгалын үйлчилгээтэй холбоотой, санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлыг энэ хуулийн 12 дугаар бүлэг дээр оруулж өгсөн. Бид нарын хувьд яаж байна гэхээр малчдад зориулсан мал аж ахуй руу чиглэсэн хөгжлийн зээл, дэмжлэг, татаас, урамшууллууд байгаа онохгүй байна, иргэн хүндээ хүрэхгүй байна, мал аж ахуйн хөгжил дэмжлэг болохгүй байна гэсэн үүднээс шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлээч гэдэг асуудлыг тавьж байгаа юм. Малыг индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудлыг бид нөхцөлийг илүү боловсронгуй болгох зайлшгүй, хамрагдалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Малчин хүний тэр эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг бид зайлшгүй хийх ёстой байгаа. Нөхөн төлбөр, олголтын босго, хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

Энэ дотроо бид хувийн даатгалын зах зээлийн оролцоог идэвхжүүлэх хэрэгтэй байгаа юм. Илүү эрсдэлийн үнэлгээ болоод нөхөн төлбөрийн механизмын ил тод байдлыг сайжруулах зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр энийг ерөнхийдөө шинээр энэ бүтээгдэхүүнүүдийг бий болго гэдэг энэ харилцааг энэ хууль дээр нэг талдаа ингээд оруулж өгсөн байгаа юм. Даатгалынхаас гадна хөрөнгийн үнэлгээг бий болго гэдэг асуудлыг тавьсан. Өнөөдөр та бүхэн бодож байгаа байх магадгүй банканд аваачаад машинаа барьцаанд тавья гэхээр таны машиныг үнэлнэ шүү дээ. Мотор нь цохих гэж байна уу, муудсан байна уу, ийм үнэлгээтэй байна, танд тэдэн төгрөгийн зээл олгоё гэдэг. Гэтэл мал аж ахуйн салбар дээр бид 60 сая малтай гээд байгаа боловч энэ салбарынхаа хөрөнгийн үнэлгээг ерөөсөө хийж чадахгүй байгаа юм. Хөрөнгийн үнэлгээчдийг бий болгохгүй байгаа юм.

Энэ хөрөнгийн үнэлгээний чиглэлээр шинэ бүтээгдэхүүн бий болгохгүй байгаа юм. Тэгэхээр үндсэндээ банканд дээр очдог магадгүй тэр банк таны хонь бог уу, бод уу, тэдэн төгрөг, хаа байсан тэр Дундговийн Адаацаг нь байна уу, Архангай аймгийн Жаргалант сум байна уу, Дорнодын Матад байна уу бүгд адилхан үнэлгээтэй байгаа асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ чинь мал аж ахуйд чиглэсэн, төрөлжсөн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ байхгүй байгаагийн бодит илэрхийлэл байгаа юм.

Түрүүн М.Мандхай гишүүн ч ярьсан, таны бас ярьсан. Үндсэндээ бид орон нутагт саяын чадавхжуулах сургалт, малчид руугаа чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа гэдэг асуудлыг ярьж байна. Сая одоо манай Ариунаа гээд оролцогч асуудаг нь суман дээр, баг дээр энийг хэрэгжүүлэх боломжгүй байна гээд яриад байгаа юм. Тийм биш. Энэ хууль дээр бид нар саяын тэр 7.4 буюу сум орон нутагт хүлээлгэсэн үүргийг буцаагаад 13 дугаар зүйлтэйгээ холбож өгч байгаа юм. Энэ дотроо малчны хөгжлийн санг байгуул, сан нь хориглогдоогүй бүхий л санхүүжилтийн дэмжлэг эх үүсвэрээр ав гэж байгаа юм. Улсын төсөв ч байж болно, дээрээс олгож байгаа хоршооны зээлтэй холбоотой санхүүжилтийн асуудал ч бэлдэнэ.

Энэ дотроо саяын 13.4.3 дээр малчдыг хөгжүүлэх чадавхжуулахад 10%-ийг нь зарцуул, малчны хөгжлийн сангаасаа дээрээс нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх 30%-ийг зарцууллаа гээд заачихсан байгаа. Үүний сайн жишээ манай Өвөрхангай аймгийн Тарагт суманд энэ сангаа байгуулчихсан. Харин Сангийн яам нь 13.6 дахь журмаа гаргахгүй бас гацаагаад байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь Сангийн яамнаас асуусан уу?

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: Тэр тооцоог хийсэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулсан нь зөв байх.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, В.Рэнцэнханд 15 дугаарын микрофон.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд: Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд байна. Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг удаа нөхөн төлүүлэх журмыг боловсруулаад 3 удаа яамдаас санал авсан байгаа. Энэ журмын хүрээнд тооцоход

5 хүртэл жилээр нөхөн төлүүлэхэд 38,2 мянган малчин хамрагдана гэж тооцсон. Үүнийг нөхөн даатгалын орлогоор 194,4 тэрбум төгрөг малчдаас шимтгэл нөхөн төлүүлээд орж ирэх орлого гэж тооцоолсон байгаа.

Тэгээд энэ хуулийн хүрээнд 4,7 мянган малчин эхний ээлжид тэтгэвэрт гарахад эхний жилдээ 29,9 тэрбум төгрөг шаардлагатай. Тэгээд жил болгон энэ тоо нэмэгдэж яваад 2030 он гэхэд 14,8 мянган малчин тэтгэвэрт гарахад 136 тэрбум шаардлагатай. Тэгээд эхний 5 жилийнхээ нөхцөл байдлаар 375 тэрбум төгрөгийн зардалтай гэсэн ийм тооцоо байна. Ер нь бол нөхөн даатгалын хуулийг бол Монголд.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд: Нөхөн даатгалын хуулийг 2 удаа хэрэгжүүлсэн байдаг. Тухайлбал, 2012 онд ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг хэрэгжүүлээд 607 мянган хүн энэ даатгалд хамрагдаад 37,9 тэрбум төгрөг бол зарцуулсан байдаг. Одоогийн байдлаар 325 мянган хүн тэтгэвэрт гараад эдгээр иргэдийн тэтгэвэрт 1,9 их наяд төгрөг зарцуулаад байна. Мөн малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажилласан жил нөхөн даатгалд бас ийм хуулийг 2017 онд баталсан. Тэгээд 2020, 2021 онд сунгаад хэрэгжүүлсэн байдаг. Үүнд 34,4 мянган хүн хамрагдаад 76 тэрбум төгрөг шимтгэлд төлсөн, эргээд 20,6 мянган хүн тэтгэвэрт гараад одоогийн байдлаар 205,7 тэрбум төгрөгийг эдгээр иргэдийн тэтгэвэрт зарцуулсан ийм байдалтай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 9 номерын микрофон, өөрийгөө танилцуулаарай.

Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Мал эмнэлэг ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Алтангэрэл. Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө мал амьтны эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн зохицуулалт 2018 оны Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулиар иж бүрэн зохицуулагддаг. Өнөөдрийн байдлаар малын эрүүл мэндийг хамгаалах хүрээндээ хуулийн 11-д заасны дагуу улсын төсөв, орон нутгийн төсөв, малчдын санхүүжилтээр гэсэн энэ 3 эх үүсвэрээс ерөнхийдөө эрүүл мэндийг хамгаалах зардал зарцуулагддаг. 2026 оны батлагдсан төсвийн хувьд 50,1 тэрбум төгрөг, нийтдээ 20 нэрийн халдварт өвчин, 4 нэрийн гоц халдварт олон улсын хорио цээрт өвчний хүрээнд дархлаажуулалт, лабораторийн оношилгоо, шинжилгээ, тандалтуудын ажлыг бол технологид.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл: Өмнөх хэвшлийн хувьд О хэвшил ихэвчлэн гарч байсан. Шүлхий өвчин дотроо 7 төрлийн хэвшилтэй. 7 хэвшлийн нэг САТ хэвшил бол ерөнхийдөө БНХАУ-ын Шинжаан Уйгар, ОХУ-ын Алтай хязгаар, ялангуяа энэ САТ1-ийн хэвшил бол 2026 оны түвшинд Турк, Казахстан зэрэг улсууд бас нэлээн өргөн тархаж байгаа. Энэ өвчин маань өөрөө шууд болон шууд бус хавьтлаар халдварладаг ийм өвчин. Энд яах аргагүй хөл хорио, хатуу хорио цээртэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хамгийн зөв оновчтой дэлхийн түвшний арга аргачлал байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тэр албаар тараагаад

байгаа гэдэг дээр нэг хариулт өгнө үү. Х.Алтангэрэл 9 номерын микрофон.

Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл: Одоогоор судлагдаад албаар тараасан гэсэн нотлох баримт тагнуулын байгууллага болон бусад хүчний байгууллагын түвшинд нотолсон юм бол байхгүй. Ер нь Хятадын хил залгаа улсуудад бас энэ өвчин гарч байгаа. Энэ маань үндсэндээ шууд болон шууд бус хавьтал, ялангуяа энэ голомтод малтай илүү ажилласан, хавьтсан хүмүүсийг хүмүүс болон машин тэрэг ийм юмаар бол бас дамжих эрсдэл өндөр байдаг. Тийм учраас энэ дээр нотлох баримт байхгүй, албаар тараасан гэж үзэх боломжгүй гэж үзэж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхдээ Х.Алтангэрэл бүс нутгуудад гарсан тул манайд одоо гарах нь зүйтэй бараг л болно гэсэн утгаар ярих гээд байна шүү. Д.Жаргалсайхан гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Мал аж ахуйн салбар Монгол Улсын хувьд бол маш чухал салбар. Яагаад гэхээр нийт хүн амынх нь $\frac{1}{4}$, өрхийн, асуудал. Нэг жилд 8 орчим их наядын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, Монгол Улсын ДНБ-ий 7 орчим хувь, энэ жилийн Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлтийн 33%-ийг мал аж ахуйн салбар эзэлж байгаа. Тэгэхээр Монгол Улсыг авч явдаг ийм том салбар. Харамсалтай нь өнөөдөр сайдууд нь байхгүй байгаа юм.

Тэгээд энэ салбарт нийт өрхийнх нь $\frac{1}{4}$ гэхээр чинь энэ хүмүүсийн нийгмийн асуудал, эдийн засгийн асуудал, хүүхдийнх нь гээд бүх асуудал яригдаж байхад өнөөдөр энд байхгүй байх жишээний. Малчны тухай хууль бол бас олон зүйлийг нээж өгсөн. Жишээ нь ипотекийн зээлд малчин хүн хамрагддаг болсон. Одоо хэрэгжилтийг хэдүүлээ асууя, хэдэн малчин авсан. Та хэд сонсоорой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн ээ, ипотеكتэй холбоотой асуудал маргааш яригдчихна Тэрэнд дээр хэдүүлээ бүр тодорхой асууя. Х.Баасанжаргал гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Сайд нараа яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сайд нарынхаа өмнөөс хар толгойгоороо хариуцна гэж байгаа бол хариултдаа дуугараарай одоо орохгүй бол сайдаа дуудаарай гээд би харин хэлээд байгаа юм. Мал эмнэлэгтэй холбоотой асуудал дээр та бүхнээс хүсээд байгаа, мал малынхаа өвчинтэй дайн зарлаад өгөөч гээд байгаа шүү дээ. Ипотек маргааш бас тайлан тавина. Тэрэнд дээр нь хэдүүлээ сайн асууя. За Х.Баасанжаргал гишүүн.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Хуралдаан даргалагчаас болоод оролцож байгаа хүмүүсээс нэг хүсэлт, горимын санал байна. Хэдүүлээ яг сэдвийнхээ дагуу сэдвээ маш нарийвчлаад асуугаад ингээд ярилцаад явах юм бол бид нарын энэ цаг аягүй үр дүнтэй байна. Тэгэхээр хэдүүлээ ийм ерөнхий зүйл яриад сэдвээсээ халиад, сэдэв болгоныг самраад явахгүй байвал зүгээр болов уу гэж бодож байна. Миний ойлгосноор бол бид малчны хүүхдийн боловсролын асуудал, залуу малчдын залгамж халааны асуудал энэ бодлоготой холбоотой асуултаа асууж байна гэж ойлгоод би өөрийнхөө асуултыг асууя.

Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын малчдаас нэг хүсэлт ирсэн. Би өөрөө амралтын өдрүүдээр эдгээр 3 сумдад очоод ажиллахад энэ

цахимаар малчдын хүүхдүүдийг сургана гээд байгаа асуудлаа болиоч ээ, малчдын хүүхдүүд үнэхээр сургууль завсардана, боловсролоос хоцрогдоно, битгий ийм одоо бодлого гаргаач.

Энэ Р.Сэддорж гишүүний санаачилсан хууль болоод мөн сайдын ярьж байгаа энэ цахим сургалтыг бид үнэхээр хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн байгаа. Ялангуяа ковидын үеэр хүүхдүүд маань ямар их завсардсан билээ. Энэ сургамжийг бид нар мартаагүй байгаа. Тийм учраас энийгээ бас эргэж хараарай гэсэн ийм хүсэлтийг илгээсэн гэдгийг зориуд хэлэх нь зөв байна.

Яг энэ сэдвийн хүрээнд миний хоёр дахь асуулт бол малчид залуу малчид байхгүй байна, залуу малчдын залгамж халаа алдагдаад байна гэж байгаагийн цаад том шалтгаан нь энэ боловсролын тогтолцоотой холбоотой гэж хараад байгаа. Ялангуяа бүсгүйчүүд эмэгтэй хүүхдүүдээ боловсролтой болгох, хүүхдүүдээ дагаж аймаг, сумын төв орох, дотуур байранд байршуулахаас илүү өөрсдөө хүүхдээ харж хандах энэ нөхцөл байдал нь одоогийн энэ үүсээд байгаа том асуудлын нэг том суурь шалтгаан болов уу гэж харж байгаа.

Тийм учраас Боловсролын яам энэ дотуур байрны асуудал дээр цаашид бодлогын ямар өөрчлөлт хийе гэж харж байгаа вэ? Малчид, малчин бүсгүйчүүд хүүхдээ дотуур байранд санаа амар өгөөд ахуйгаа эрхлээд явах энэ боломжийг нь олгох нь илүү чухал юм болов уу гэж би хувьдаа хараад байх юм. Тэгэхээр энэ дотуур байрны асуудал хаана ч яригдахгүй дандаа ингээд орхигдоод байдаг сэдэв. Шинэчлэгддэггүй хөрөнгө оруулалт нь дандаа хаягддаг. Ингээд түүний цаана хамгийн гол нь энэ дотуур байрны хүүхдийн хамгааллын асуудал хүүхдийн асран хамгааллын асуудал гээд бид нарынхаар бол асрамж хамгааллын асуудал аягүй чухал байдаг.

Боловсролын байгууллага уг нь биш байгаад байдаг дотуур байр. Энэ цэвэр асран хамгааллын байгууллага байгаад байдаг, бүгд боловсролын байгууллага гээд ингээд хаяад байдаг нэг ийм асуудал байна. Энийг Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хоёулаа ямар байр суурьтай гэдэг дээр хариулт өгнө үү. Хоёрдугаарт энэ залуу малчидтай холбоотой энэ залгамж халааны сургалтын талаарх мэдээллүүд ирүүлсэн байна. Энэ хууль батлагдсанаар гарсан ахиц дэвшил өөрчлөлт нь юу вэ? Бид ерөөсөө харахгүй байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яам хариульъя 17 дугаарын микрофон.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариульъя. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир. 2023 онд Боловсролын багц хуулиудыг шинэчлэн баталсан. Энэ хуульд бид сургалтын хэлбэрүүдийг нэлээн уян хатан болгож, танхим цахим зайн сургалтуудыг тодорхойлж, хамгийн гол орсон зохицуулалт бол гэрийн сургалтын зохицуулалт орж, энэ гэрийн сургалтын журмыг Боловсролын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар оруулсан юм.

2023 оноос хойш бид 7 настай хүүхдийг элсүүлэх боломжийг олгоод ингээд явахаар 6, 7 настай малчин өрхийн хувьд хүүхэд хэт балчирдаад байгаа учраас цаашдаа энэ гэрийн сургалтын журмаа бид илүү боловсронгуй болгож, ялангуяа энэ хуульд туссан олон хувилбарт зүйлүүдийг ашиглаж, илүү малчдад ойр сургалтын арга хувилбаруудыг гаргаж ирэх гэдэг дээр нэлээн туршлага судалж, судалгаа тооцооллуудыг хийж байгаа. Өөрөөр хэлбэл малчин өрхийн хүүхэд

болгоныг зайнаас цахимаар сургах асуудал энэний цаана яригдахгүй гэж ингэж харж байгаа. Өөрөөр хэлбэл сайн дурын үндсэн дээр эцэг, эх, асран хамгаалагч хүсвэл хүүхдийг гэрийн сургалтад хамруулж болно.

Гэхдээ гэрийн сургалт гэдэг нь зөвхөн хүүхдэд чиглэсэн сургалт биш, гэр бүлд нь чиглэсэн сургалтын арга зүй хэлбэр явах юм. Энийг нь тодорхой цаг хугацаа, давтамжтай, өөрийн арга аргачлалтайгаар зохион байгуулаад явах юм бол хүүхэд 7, 8 настай жишээлбэл 8 настай 3 дугаар ангид орж ирэхэд нь бид шууд 3 дугаар ангид нь дүйцүүлээд сургах шаардлагатай. Түвшнийг нь тогтоогоод, хоцрогдлыг нь ганцаарчилсан сургалтаар нөхөөд явах энэ боломжуудыг хууль эрх зүйн хувьд нээлттэй болгоод өгье гэдэг ийм зүйлийг ярьж байгаа юм.

Тэгэхгүй бол 7 настай ороод ирэхээр шууд 6 настай хүүхдүүдтэйгээ нэг ангид суудаг ч юм уу, 8 настай ороод ирэхээрээ 1 дүгээр ангийн хүүхдүүдтэйгээ нэг дор суудаг ч юм уу энэ зохицуулалтыг бид энэ гэрийн сургалтын журмаараа яг тухайн насанд нь дүйцүүлж, хоцрогдолд нь нөхөх, дасан зохицох, энэ арга хэлбэрүүдийг нь нээлттэй болгож өгөх ийм байдлаар арга аргачлалаа харъя гэж ийм байдлаар гэрийн сургалтын журмын сайжруулах ийм ажлууд хийгдэж байгаа гэдгийг бас онцолж хэлье.

Тэгээд өнөөдөр малчдын боловсрол ярьж байхад сургуулийн өмнөх ерөнхий боловсролын түвшний юмнууд ярилаа гэж бас тодорхой шүүмж хэллээ, хүлээж авлаа. Гэхдээ малчны хөгжил гэдэг бол хүүхдийн сурч боловсрох эрхтэйгээ хамт яригдах учраас бид нар малчдын хүүхдийг яаж сургуульд бэлтгэх вэ, малчдын хүүхдийг яаж сургуулийн гадна үлдээхгүй боловсролд хамруулж байгаа вэ, энэ нь малчдын хөгжих хэрэгцээтэй яаж холбогдож байгаа вэ гэдэг байдлаар илтгэл мэдээллүүдээ бэлтгэж орж ирснийг та бүхэн маань хүлээж авах болов уу гэж бодож байна. Хамгийн гол зүйл бол дотуур байрны асуудал байгаа.

Дотуур байрны асуудал дээр бид нар дотуур байр бол яг гэр бүлийн хоёр дахь орчин байх, өөрөөр хэлбэл дотуур байранд ажиллаж байгаа үйлчлэгч жижүүрээсээ эхлээд эерэг сургалтын арга зүйд суралцсан, яг хүүхдийн хоёр дахь асран хамгаалагч байх чиглэлээр дотуур байрны багш, ажилчдын сургалтын хөтөлбөр дээрээс нь сургалтын орчин нь өөрөө ийм байх ийм концепцуудыг бол хийж байгаа. Энэ дээр бол НҮБ-ын Хүүхдийн сан болон холбогдох байгууллагуудтай ажиллаад явж байгаа. Хамгийн гол нь барилга байгууламжийг үе шаттай шинэчлэх ажил дээр анхаарал хандуулах ёстой гэж харж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. За Х.Баасанжаргал гишүүн.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам холбогдох хүнээ дараагийн хурал дээр оруулж ирээрэй. Би заавал асуултад хариулт авна. Яагаад гэвэл дотуур байрны асуудлыг бид бүгдээрээ дандаа боловсролын салбарын асуудал гээд зөвхөн дотуур байрны багшид бид нар энэ олон хүүхдүүдийг найдаж яваад байгаа. Та нар өөрсдийнхөө хүүхдүүдийг дотуур байранд дунджаар нэг суманд 90 хүүхэд байна. 90 хүүхдийг та нар хоёрхон багшид найдаад байгаа шүү дээ. Бид нар өөрсдийнхөө хүүхдийг тэгж найдаж чадахгүй шүү дээ, яг үнэн хэрэгтээ бол.

Гэтэл тэнд боловсролоос гадна тэнд чинь бүхэл бүтэн асран хамгаалах үйлчилгээ гэдэг юм байх ёстой. Тэр хүүхдүүд чинь өдөр нь хичээлдээ явна, орой нь тоглоно наадна, өвдөнө, эм уух хэрэгцээ шаардлага гарна, шөнө нь халуурна,

шээс нь хүрнэ, гарч бие засах хэрэгцээ гарна гээд ингээд та хэд маань өөрсдийнхөө хүүхэд дээр бодоод яг хөдөөгийн орчинд байгаа дотуур байрны хүүхдүүдийн амьдарч байгаа тэр орчныг яаж сайжруулах вэ гэдэг маань өөрөө.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэг минут нэмье.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Залуу малчдыг энэ хөдөөгөө тогтвор суурьшилтай цаашаага залгамж халаа болоод явах хамгийн гол зүйл чинь энэ хүүхдийн эрүүл, аюулгүй орчин болчихоод байна. Энийг яамд олж хараад өгөөч. Энэ ганцхан Боловсролын яамны асуудал биш гэдгийг хэлэх гээд байна. Хоёрдугаарт миний түрүүний нэг асуулт байгаа. Яг хууль батлагдсанаар гарсан өөрчлөлт юу вэ, өнгөрсөн 2 жилийн хугацаанд ахиц дэвшил яаж гарсныг хармаар байна. Жишээ нь энэ залгамж халаа бэлтгэх гээд ингээд нэг жил 10 хүн, дараа нь 13 хүн хөдөө аж ахуйн чиглэлээр малчдын хүүхэд сурсан юм байна. Яг ингээд жилд арав арваар явах уу, тэгэх бол хэзээ өөрчлөлт гарах вэ? Яг ийм зүйлийг бид өөрчлөлт гэх юм бол үндсэндээ төрийн бодлого гэхэд их л хэцүү харагдаад байна. Тэгэхээр яг энэ залгамж халаа бэлтгэх бодлого дээр өнгөрсөн 2 жилд ахиц дэвшил гарав уу? Ахиц дэвшил гарахад хамгийн том саадтай бэрхшээлтэй байгаа зүйл юу байгаад байна вэ, малчид мэдээлэлгүй байна уу, яагаад аравхан хүүхэд сураад байна вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Боловсролын яам дараа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариулаарай.

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир: Түрүүн 081 гэдэг хөдөө аж ахуйн салбарын том индекс тэгээд цаашаа яг хуульд заасан индексийг харахаар 081101, тэр нь зөвхөн мал аж ахуй бэлчээр тэжээлийн чиглэлийн ийм индекс болчихоод. Тийм учраас хоёрхон мэргэжлээр малчин өрхийн хүүхдүүд төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах боломж нь олдож байгаа учраас нөгөө сонголт нь хоёрхон болж байгаагаас шалтгаалаад ийм асуудал үүсээд байгааг түрүүн ярьсан. 2025 онд бид насан туршийн боловсрол, суралцахуйн төвүүд, мэргэжлийн боловсролын сургууль, Политехникийн коллеж дээр түшиглээд яг энэ малчин өрхийн малчин гэр бүлд суурилсан гишүүний боловсрол сургалтыг дэмжих хөтөлбөрөө гаргаад, түрүүн хэлсэн чадамжийн гэрчилгээг 250 гаруй малчин өрхийн залуучуудад олгоод явчихсан ийм байдлаар бол сургалтууд явж байгаа. Сургалтын үр дүнгүүд бид 2025 оны намраас зүүн бүсээс эхлээд хойд баруун бүсээр ингээд явна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хууль хэрэгжсэнээс ямар үр дүн гарсан талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хариултыг сонсьё. 11 номерын микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Х.Баасанжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун. Хууль батлагдсанаас хойш хэрэгжилтийн нэг жил гаруй хугацаа өнгөрч байгаа. Мэдээж энд олон институтүүдийн холбоо, холбогдож ажиллах ийм зайлшгүй шаардлага байна. Тодорхой хэмжээнд үр дүнгүүд гараад, хөрөнгө мөнгөтэйгөөс бусад энэ журмуудаа батлаад хэрэгжилтүүдээ хангаад явж байгаа. Түрүүн бас яригдсан төсөвтэй холбоотойгоор зарим журмууд ингээд саатаж байгаа. Бусдаар журмуудаа хэрэгжүүлэх гээд тодорхой хэмжээний ахиц дэвшлүүд бол гарч байгаа гэдгийг бас хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нийгмийн

хамгаалалттай холбоотой асуудлуудыг дараа нь асуучих. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хууль батлагдсанаар гарсан үр дүнгийн талаар олигтойхон хариулаад өгөөч. 11 дүгээр номерын микрофон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Жил жилээр тоо баримтуудыг бас хэлж болно. Тэгэхдээ ямар ч байсан төсөвтэй холбоотой учраас яг хэчнээн малчдад нөхөн олговор олгох энэ тэр гэдэг тоо баримтаар бол гарах боломжгүй.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Залгамж халаа бэлдэнэ гээд байгаа дээр чинь үр дүн гарсан юм уу?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Чиглэл чиглэлээр нь бүгдийг нь хариулж байна шүү дээ. 2 жилийн хугацаа залгамж халаа бэлдэнэ гэдэг дээр бид сургалтынхаа хөтөлбөрийг сайдын тушаалаар батлаад чиглэлээ тодорхойлоод ингээд энийгээ орон нутагт хүргүүлээд тодорхой хэмжээний сургалтуудыг эхлүүлээд явж байна. Энэ дээр тоон мэдээллийг нарийн нягтлаад танд гаргаад өгье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж дууслаа. Малчны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд авсан арга хэмжээний тал талаарх танилцуулгыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар танилцуулаад тэгээд завсарлая. Б.Анарыг урьж байна.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар. Малчны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэр дотроо Сангийн яамтай холбоотой хийгдсэн ажлуудыг та бүхэнд товч танилцуулъя. Засгийн газрын авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хуулийн заалтууд дотор яг санхүүгийн эх үүсвэр, санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой нийтдээ 10 заалт туссан байгаа. Энэ дотроо заалт тус бүрээр ямар хэрэгжилттэй байгаа гэдгийг та бүхэнд товчхон танилцуулъя гэж бодож байна.

Эхнийх нь бол энэ мал аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх гэсэн заалт бол байгаа. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад энэ мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт зардлыг бол жил болгон төлөвлөөд явж байгаа. Энийг бас хойшоогоо дэлгэрэнгүй ярина. Тухайлаад хэлэх юм бол түүхий эдийн урамшуулал, сүү ноос арьс ширний урамшууллыг сайдын багц дотроо суугаад санхүүжүүлээд явж байна.

Хоёрдугаарт энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, дэмжлэг, санхүүгийн үйлчилгээнд хамруулах гээд ийм заалт байна. Энэ хүрээнд малчдад зориулсан зээлийн хүүгийн дэмжлэг батлагдаад явж байна. Тодруулаад хэлэх юм бол түрүүн яригдсан Шинэ хоршоо, Цагаан алт, Хүнсний хувьсгал гэх мэт хөдөлгөөнүүдийн хүрээнд тодорхой хэсгүүд нь бол малчид руу зориулсан зээл болоод явж байгаа. За үүнээс гадна 2023 оны зудтай холбоотойгоор 2024, 2025 онд нийтдээ 142 тэрбум төгрөгийн 6%-аас дээш хүүтэй малчдын зээлийг хойшлуулах арга хэмжээнд нийтдээ 2024, 2025 онд нийтдээ 142 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан байна. Мал эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр малын дархлаажуулалт, тарилгын үйлчилгээний хөлстэй холбоотой зардлуудыг жил болгон холбогдох хариуцсан салбарын сайдын багцад нь тусгаад бас явж байна.

Малчдын амьдрах орчныг сайжруулах, ипотекийн зээлд хамруулах, хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой журам батлах ёстой яг хуулийн заалт бол. Гэхдээ яг орон сууцын ипотекийн зээл олгох тусгайлсан журам бол батлагдаагүй. Харин орон нутагт 3%-ийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох бол санхүүжилтийн эх үүсвэрүүдийг шийдвэрлээд бол явж байна. Мөн эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулахтай холбоотой заалт бол энэ ЭМД-аас шимтгэл төлсөн малчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээ хийгдээд явж байна. Энэ нь өөрөө эрүүл мэндийн шимтгэлийг сайн дурын үндсэн дээр төлсөн малчид энд хамрагдаад явна.

Гамшигт үзэгдлийн улмаас нас барсан малчны ар гэрт нэг удаагийн тусламж үзүүлэх журмыг түрүүн хэлж байсан. Засгийн газар 2026 онд Малчны гамшигт үзэгдлийн улмаас мал сүргээ алдсан өрхийг малжуулах арга хэмжээ авах гээд баталсан байгаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Засгийн газрын энэ тогтоолоор бол тухай бүрд нь санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлээд явдаг. Засгийн газрын нөөц сангаас гадна тухайн шатны аймгийн Засаг даргын нөөц хөрөнгүүдээс бас тодорхой хэмжээний эх үүсвэрүүдийг бол аймаг орон нутаг нь бас нэмээд шийдээд явдаг гэдгийг хэлье.

За түрүүн бас нэлээн яригдсан энэ малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэхтэй холбоотой журам одоогоор батлагдаагүй. Мэдээж энэний хойд талд санхүүжилтийн эх үүсвэр, дараа дараагийн жилүүдэд улсын төсөв дээр ирж байгаа санхүүжилтийн хүндрэлийн асуудлууд, дээрээс нь нарийн ярих юм бол нийгмийн даатгалын тогтолцооны шударга ёсны байдалтай холбоотой ийм асуудал хөндөгддөг. Гэхдээ энийг дэлгэрэнгүй байдлаар маргаашийн цаг дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас танилцуулаад явах байх. Арваас доошгүй жил ажилласан малчны хүүхдийг их дээд сургуульд үнэгүй сургахтай холбоотой журам батлагдсан байна.

Боловсролын яамны төлөөллийн танилцуулга дээр түрүүн дэлгэрэнгүй танилцуулагдсан. Үүнээс гадна Малчны хөгжлийн сан байгуулахтай холбоотой заалт, энэ журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Сангийн яам хамтран батална гэсэн заалт хууль дээр байгаа. Энэ журам одоогоор батлагдаагүй. Гэхдээ асуудлаа хариуцсан салбарын яамны зүгээс энэ санг яаж хэрхэн байгуулах, яаж зөв үр ашигтай удирдах чиглэлээр тодорхой судалгаануудыг хийгээд явж байгаа гэж ойлгож байгаа.

Ингээд товчхон түрүүнийхээ ярьж байгаа энэ 10 үйл ажиллагаа тус бүрээр тоон мэдээллийг та бүхэнд хүргэе гэж бодож байна. Нийтдээ хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үндэсний хөтөлбөрийн хүрээнд урамшуулал болон санхүүгийн дэмжлэг гээд 2 хэсэгт хуваагаад үзчихэд болно. Хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийтдээ 3 хөтөлбөр хэрэгжиж байгаа.

Эхнийх нь бол Шинэ хоршоо чинээлэг малчин хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас нийтдээ зээлийн хүүгийн 12%-ийг татаас хэлбэрээр олгодог. Нийт зээлийн хүү 18, яг малчдад очиж байгаа зээлийн хүү нь бол 6% байхаар тооцож энэ хөтөлбөрийг анх боловсруулсан. Хугацаа бол 1-5 жилийн хүртэлх хугацаатай. Одоогийн байдлаар нийт олгосон зээлийн хэмжээ бол 894,8 тэрбум төгрөгийг олгосон. Нийт хамрагдсан зээлдэгч бол 26437 малчин өрх зээлдэгч ААН-үүд хамрагдсан байна. Энэ зээлтэй холбоотойгоор 2025, 2026 онд нийтдээ 177,2 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн татаасанд олгохоор төлөвлөгдөөд гүйцэтгэлээр нийтдээ 114,4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Хоёрт нь Цагаан алт хөтөлбөр байна. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас хариуцаж байгаа хүүгийн хөнгөлөлт 10%, тэгэхээр зээлдэгч дээр 7%-ийн хүүтэй зээл очиж байгаа гэсэн үг. Хугацааны хувьд 2 болон 4 жилийн хугацаатай олгогдож байгаа, нийтдээ 520,7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Энэ онд олгох зээлийн хэмжээ 450 орчим тэрбум төгрөг гээд тооцсон. Энэ онд болон өнгөрсөн онд нийт төлөвлөгдөөд гарч байгаа гүйцэтгэлээр 44,3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн татаас олгогдсон явж байна.

Дараагийн хөтөлбөр бол Хүнсний хангамж аюулгүй байдал гээд хөтөлбөр байгаа. Засгийн газраас бол нийтдээ хүүгийн хөнгөлөлтийн олгож байгаа хүүгийн хөнгөлөлтийн зөрөө түвшин 13%-ийн хувийн хүүтэй, зээлийн өөрийнх нь иргэд, ААН-д очиж байгаа зээлийн хүү 5-6%-ийн хүүтэй байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд бол нийтдээ 1,2 их наяд орчим төгрөгийн санхүүжилтийг одоогийн байдлаар олгосон. Нийт 3154 зээлдэгч хамрагдсан байна. Үүнээс гадна түрүүн зарим малчдаас хэлж байсан энэ тодорхой хэмжээний урамшууллууд одоо яг ирэхгүй байгаа энэ урамшуулалд хамрагдаагүй гэж ярьсан.

Эдгээр хөнгөлөлттэй зээл болон урамшууллын зохицуулалтыг нь салбарын яам хийдэг, хяналтыг салбарын яам тавьдаг. Сангийн яамны хувьд батлагдсан эх үүсвэрийн дагуу санхүүжүүлэх үүргийг хүлээдэг байгаа гэдгийг хэлье. Сүүлийн 3 жилийн хугацаанд 2024, 2025, 2026 онд нийтдээ ноосны урамшуулалд 46,9 тэрбум төгрөг, сүүний урамшуулалд 44,3 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 13,6 тэрбум төгрөг гээд нийтдээ өмнөх 2 жил энэ жилийн оруулаад нийтдээ 104 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан олгогдсон байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Түрүүн ярьсан орон сууцын ипотекийн зээлийн талаар бас дэлгэрэнгүй ярьж гэж бодож байна. Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын хүрээнд орон нутгийн 3%-ийн хөнгөлөлттэй ипотекийн зээлийг олгож эхэлсэн. Энэ хүрээндээ эхний 3 жилдээ 3%, 4 дэх жилээс нь 6%-ийн хүүтэй болох ийм нөхцөлтэй орон нутгийн зээлийг олгож эхэлсэн. Ипотекийн зээл нь өөрөө нэг онцлогтой байдаг. Одоо ямар нэг сегмент рүү чиглээд малчдад гэдэг юм уу, тариаланчдад гэдэг юм уу эсвэл одоо төрийн албан хаагчдад зориулсан зээл гээд ингээд явахаараа тухайн хөтөлбөр нь ингээд гажуудчих гээд байдаг ийм эрсдэлтэй байдаг.

Тэгэхээр Сангийн яамны зүгээс Монголбанк, бусад хөтөлбөрт оролцож байгаа банкнуудтай ярилцаж байгаад ямар тохиролцоонд хүрсэн гэхээр ерөөсөө энэ зээлийг орон нутаг болон нийслэлд гэдэг байдлаар хуваарилъя гээд. Нийт олгож байгаа зээлийн 50 хүртэлх орчим хувийг орон нутаг руу хуваарилах ийм зохицуулалтыг хийгээд явсан гэдгийг хэлье. 2023, 2024, 2025 онд ингээд нийтдээ 5173 өрхөд 536,6 тэрбум төгрөгийн нийт үнийн дүнтэй 3%-ийн зээлийг бол олгосон байна. Аймгаар нь та бүхэнд харуулж байгаа учраас аль аймгаас ямар хэмжээний иргэд хамрагдсан гэдгийг эндээс харах боломжтой.

Энэ хөтөлбөрийн хүрээнд 3%-ийн хүүтэй зээлийн хүүгийн татаас буюу хүүгийн зөрөөг улсын төсвөөс хариуцаад явж байгаа. Нийтдээ сүүлийн 4 жилийн хугацаанд 115,1 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээрээ 52,8 тэрбум төгрөгийг олгоод явсан байна. Нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэхтэй холбоотой журмыг бас яриад байгаа. Энэ дээр бас нэмээд одоогийн байгаа нийгмийн даатгалын тухай хуульд ямар зохицуулалт байгаа вэ гэдгийг та бүхэнд бас танилцуулъя гэж бодож байна. Энэ нийгмийн даатгалын 2024 оны хуулийн өөрчлөлтөөр бол энэ малчин болон туслах малчинтай холбоотой ийм заалт одоогоор мөрдөгдөж байгаа.

Энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ноогдох тэтгэврийн даатгалын шимтгэл 50%-аар гээд шимтгэлийг хэрвээ малчин болон туслах малчинд бол улсын төсвөөс 50%-аар даах, өөрөө тухайн малчин болон туслах малчин нь 50%-аа санхүүжүүлээд явахаар ингээд заачихсан байдаг. Улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн хугацаа 5 жилээс ихгүй хугацаанд байна гэсэн ийм хуулийн заалт одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ хүрээндээ 2024 онд нийтдээ 55,1 мянга малчин, 2025 онд 57,9 мянган малчинд, ингээд нийтдээ 63,8 тэрбум төгрөгийн шимтгэлийн зардлыг энэ 50% төрөөс хариуцах гэдэг зардал одоо төрөөс хариуцаад явж байна. Энд нийтдээ 55-58 мянган малчин иргэд давхардсан тоогоор хамрагдсан байна гэсэн мэдээллийг бас өгье. За түрүүн бас дурдсан төрөөс энэ мал аж ахуй, малын дархлаажуулалттай холбоотой зардлыг тухайн салбарын сайдын багцад нь тавиад хариуцаад аваад явдаг.

Энэ хүрээндээ энд харагдаж байгаа малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малыг архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх, малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ, мал эмнэлгийн ариутгал халдваргүйжилтэй холбоотой зардлуудыг ингээд тусгаад явдаг. Энийг ингээд багцлаад аваад үзэх юм бол 2024, 2025, 2026 онд ингээд вакцин дархлаажуулалтын зардалд 2024 онд ингээд 27 орчим тэрбум, 2025 онд 19,5, 2026 онд 27,4 тэрбум төгрөг санхүүжүүлээд явж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Ингээд оны дүнгээрээ аваад үзэх юм бол 2024 онд нийтдээ 65, 2025 онд 62 орчим тэрбум, 2026 онд 55 тэрбум төгрөг батлагдаад гүйцэтгэлээрээ санхүүжилт гараад явдаг гэдгийг та бүхэнд хэлье. Яг түрүүн илтгэлийн эхэнд хэлж байсан нийтдээ 10 асуудлаас 3 асуудал нь ингээд хэрэгжилт бол дутуу яваад байна гээд. Энэ дээр бол яг энэ малчдыг орон сууцын зээлд хамруулах асуудлаар Монголбанкт цаашдаа Засгийн газрын зүгээс ингээд хамтарсан судалгаа хийгээд явна. Гэхдээ түрүүн хэлсэн зорилтот нэг бүлэг рүү малчинд гэдэг юм уу, тариаланчид гэдэг юм уу зээлийг чиглүүлнэ гэдэг нь өөрөө жоохон хэрэгжилт дээр хүндрэл учруулдаг ийм асуудал байдаг гэдгийг бас хэлье.

Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг одоо салбарын яамтай цаашдаа хамтраад хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдгийг хуулийн хэрэгжилтийг хангуулах тал дээр анхаарах шаардлага бол байгаа. Гэхдээ мэдээж түрүүн хэлсэн, энэ төсөв санхүүгийн асуудал, цаашид шударга нийгмийн даатгалын тогтолцооны асуудал яригддаг гэдгийг бас дахин хэлэх нь зүйтэй байх. Өмнө нь хөдөө аж ахуйн салбарт Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих дундын сан гээд олон сангууд байсан.

Өнгөрсөн хугацаанд энэ сангуудын үйл ажиллагаа, ил тод байдал, зарцуулалттай холбоотой олон асуудлууд гарч байсан. Тэгэхээр Мал хамгаалах сан, малчны дундын санг ямар нэгэн ийм санхүүгийн хэрэгжилт дээр доголдол үүсэхгүй, алдаа дутагдал гаргахгүй байх үүднээс эхлээд маш сайн судалж байж орлогын зөв бүтэцтэйгээр эхнээс нь байгуулах ёстой. Хэрвээ тэгж чадахгүй зөвхөн улсын төсвөөс санхүүжилт аваад явдаг санхүүжилтээрээ ингээд хуваагаад өгдөг байвал энэ төсвийн харилцаанаас бараг ялгаагүй болчихно.

Тэгэхээр энэ сан маань өөрөө хэрхэн ямар орлогоор бүрдэх вэ, өөрөө өөрийгөө хэрхэн цаашдаа яаж аваад явах боломжтой байх вэ гэдэг энэ орлогын механизмыг нь эхэлж зөв тодорхойлж байж энэ сангаа байгуулах ёстой. За мэдээж энэ процессыг одоо салбарын яамтай манай яамны зүгээс хамтраад хэрэгжүүлээд явах ийм бүрэн боломж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Товчхондоо ийм байна, баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Сонсголын хуралдааныг 13 цаг 30 минут хүртэл завсарлуулж байна. Үдийн хоол гадаа байгаа. Надад үг хэлэх оролцогчдын нэр ирсэн байгаа. Би Д.Шагдарсүрэн гуайгаас Малчны тухай хуулийн хэрэгжилтийн цаг агаарын нөхцөл байдал ер нь ямар байгаа талаар үг сонсмоор байгаа гэдгийг танд уламжилъя, баярлалаа.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран: Энэ үйлчилгээний хүртээмж нэлээд өндөр өссөн байна. Хоёр дахь чиг үүрэгт мэдээлэл авах, солилцох, нэг цонхны цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахаар заасан. Үүнтэй холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 2023 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг байгуулсан. Тус газар иргэдэд төрийн үйлчилгээг нэг цонхоор хүргэхээр төлөвлөсөн.

Нэг цонхны үйлчилгээ гэдэг нь нэг дээвэр дор олон байгууллага төвлөрч, төрийн үйлчилгээг нэг дор хүргэхийг хэлдэг. Өөрөөр хэлбэл, иргэн нэг төрийн албан хаагч дээр нэг цонхоор хандаж, нийгмийн даатгал, татвар, улсын бүртгэл болон холбогдох үйлчилгээг шууд авах боломжийг бүрдүүлэх зорилгоор уг байгууллагыг байгуулсан юм. Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сумыг хамарсан нэг цэгийн үйлчилгээг бий болгож, өнөөгийн байдлаар нийт 356 нэгж цэгийг байгуулсан байна.

2023 оноос хойш өнөөдрийн байдлаар 1 сая 579 мянган иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн статистик мэдээ байна. Мөн хүртээмжийг сайжруулах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, өвчтэй хүмүүст зориулсан явуулын төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Орон нутгийн нээлттэй мэдээлэл, ажлын байрны нэгдсэн санг нэгтгэх зорилгоор Хөдөө.мн цахим хуудсыг хот, хөдөөгийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдуулан E-Mongolia академи дээр хөгжүүлж нэвтрүүлсэн. Тус санд бүртгэлтэй ажлын байрны зар 24 мянга гаруй байгаа судалгаа бий. Банк, санхүү, татвар, худалдааны цахим үйлчилгээг сайжруулах чиглэлээр төрийн холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна. 2026 оны 2 дугаар сараас ноос, ноолуур, түүхий эдийн малчдад зориулсан урамшууллын мэдээллийг E-Mongolia платформд оруулсан.

Ингэснээр малчид ноосны урамшууллын мэдээллийг E-Mongolia платформоос шууд авах боломжтой болсон. Малын тоо толгойн татварыг Сангийн яамны харьяа Санхүүгийн мэдээллийн технологийн төвийн E-Mongolia платформоор дамжуулан иргэд бүх төрлийн хэрэгслээр төлөх боломжийг бүрдүүлсэн. Сүүлийн үед банк, санхүүтэй холбоотой кибер хамгаалалтын чиглэлээр түлхүү ажиллаж байна. Энэ нь зөвхөн кибер халдлагаас сэргийлэхээс илүү бүх нийтийн цахим ур чадварыг сайжруулахад чиглэж байгаа юм. Учир нь цахим орчинд үйлдэгдэж буй залилангийн хэрэг сүүлийн үед эрс нэмэгдэж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж буй хэргийн 70–80 хувь нь иргэд цахим орчинд ямар нэг байдлаар залилан, луйварт өртсөнтэй холбоотой байна. Үүнд ялангуяа орон нутгийн иргэд, ахмад настан өртөж байна. Иймд иргэдэд өөрийн эмзэг мэдээллээ хэрхэн хамгаалах талаар Кибер аюулгүй байдлын зөрчилтэй тэмцэх нийтийн төвөөрөө дамжуулан мэдээлэл, сургалт хүргэж, постер тараах зэрэг арга хэмжээг тогтмол авч байна. Цагдаагийн ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын газартай хамтран, залилан болсон тохиолдолд цаг алдалгүй хандах нэг цонх, нэг утасны үйлчилгээний төв ажиллаж байна. Үүгээр дамжуулан иргэн

эрсдэлд өртсөн тохиолдолд шилжүүлсэн мөнгийг холбогдох банкинд царцаах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.

Дараагийн зорилт бол төр болон хувийн хэвшлийн үйлчилгээний цахим системийн хүртээмжийг сайжруулах явдал бөгөөд энэ чиглэлээр тогтмол холбогдох ХХААХҮЯ-тай хамтран ажиллаж байна. Иргэдэд олгосон тоон гарын үсэг давхардсан тоогоор 2,2 саяд хүрсэн боловч хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Учир нь токен төхөөрөмжийн тал орчим нь иргэний үнэмлэх дээр байгаа тул хэрэглээ бага байна. Үүнийг сайжруулах талаар ажиллаж байна.

Иргэдэд цаг агаар болон бусад үйлчилгээ авсантай холбоотой мэдэгдлийг E-Mongolia платформ болон хуулийн этгээдэд зориулсан E-Business платформоор дамжуулан хүргэж байна. Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас болох GO.mn-ийг хөгжүүлж нэвтрүүлсэн. Ингэснээр иргэд холбогдох байгууллага тус бүрийн цахим хуудсыг хайхгүйгээр нэг хуудсаар хандаж мэдээлэл авах боломжийг бүрдүүлээд байна. E-Mongolia платформд малчинтай холбоотой үйлчилгээг төвлөрүүлсэн бөгөөд малчны тодорхойлолтыг цахимаар шууд авах боломж бүрдүүлсэн. Энэ үйлчилгээ нэвтэрснээс хойш малчид 156 мянга гаруй лавлагааг малчид авсан байна. Мөн мал тооллогын лавлагааг 85 мянга, малчин бүхий өрхийн тодорхойлолтыг 13 мянга, малчны А дансны лавлагааг 3,400 иргэн авсан. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн лавлагаа 4 болон малчин өрхийн тамга авах хүсэлтийг гуравхан иргэн авсан байна.

Төрийн бүх үйлчилгээг цахимжуулж, хүртээмжийг сайжруулах чиглэлээр холбогдох судалгаа хийсэн. Судалгаагаар төрийн 5,786 байгууллага байгаа нь тооллого хийгдсэн. Эдгээрийн үзүүлж буй давхардсан тоогоор 18,613 үйлчилгээний давхардсаныг шүүгээд үзэхээр 3,843 үйлчилгээний 79 хувь нь ямар нэгэн байдлаар цахимжсан байна. Мөн E-Mongolia платформд малчны үнэмлэхийг оруулсан тул малчид үнэмлэхээ үзүүлээд E-Mongolia цахимаар ашиглах боломжтой болсон. Жишээ нь, тээврийн хэрэгсэл жолоодохдоо иргэний үнэмлэх болон тээврийн хэрэгслийн гэрчилгээгээ E-Mongolia платформоос үзүүлэх боломжтой болсон. Малын бүртгэлийн системийг Хүнс, хөдөө аж ахуйн яам эрхэлж байгаа бөгөөд хуулийн 8.2-т малчин болон тэдгээрийн үйл ажиллагааны бүртгэлийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталгаажуулалтаар бүртгэхээр заасан. Үүнтэй холбогдуулан ХХААХҮЯ малын генетик нөөцийн бүртгэлийг хийсэн.

Үүнээс гадна хэд хэдэн тусдаа платформ, системийг хөгжүүлж, таван төрөлжсөн бүртгэлийн санг хөтөлж байна. Үүнд мал, амьтны халдваргүй өвчний анхдагч мэдээллийн сан, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээллийн сан зэрэг багтаж байна. Эдгээр бүртгэлийн санг түшиглэн холбогдох байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох боломж бүрдэж байна. Мөн хуулиар газрын бүртгэл, кадастрын зураглал, бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээний үйлчилгээг сайжруулах чиг үүрэг өгсөн.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай хамтран холбогдох үйлчилгээг цахимжуулсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар суурь мэдээллийн сангийн нэг нь газар байх бөгөөд газрын цахимжилт эртнээс хийгдсэн. E-Mongolia болон E-Business платформд орсон, газартай холбоотой хамгийн эрэлттэй үйлчилгээний статистикийг танилцуулгад оруулсан. Жишээ нь, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас үзүүлдэг газар эзэмших эрхийн лавлагаа 2021 онд нэвтэрсэн бөгөөд түүнээс хойш 154 мянган иргэн уг лавлагааг авч ашигласан байна. Энэ статистик тоон мэдээ дараа нь хүрэх тул

алгасаад явъя.

Дараагийн томоохон ажил бол технологийн сүлжээгээр дамжуулан малчдад мэдлэг түгээх, бусад цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах явдал юм. Бид нарын хийж байгаа том ажил нь төрийн үйлчилгээг цахимжуулж, дэд бүтцийг сайжруулдаг ч иргэдийн хувьд хэрэглээ хангалтгүй байгаа асуудал тулгарч байна. Үүнтэй холбоотой бүх нийтийн цахим ур чадварыг сайжруулах чиглэлээр 2023 оноос хэд хэдэн үндэсний хөдөлгөөн, аяныг эхлүүлсэн.

Ингэснээр иргэд төрийн үйлчилгээг хялбар авахаас гадна өөрийн цахим технологи үйлчилгээтэй холбоотой өөрийнхөө аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, хэрэглээгээ хэрхэн зөв ашиглах талаар мэдээлэл авах боломжтой болсон. Өнгөрсөн хугацаанд бүх аймаг, 115 сумыг хамарсан аяныг зохион байгуулсан. Энэ жил “Цахимаар нэн тэргүүнд” буюу дижитал фёрст аяныг холбогдох төрийн байгууллагууд, олон улсын болон донор байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Бусад системүүдийн хувьд түрүүн дурьдсан ХХААХҮЯ-аас тус тусдаа системүүдийг хөгжүүлсэн байдаг. Бид нарын хувьд бусад системүүдийг нэгтгэх 1 цонхоор иргэн хялбар болох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Зөвшөөрөлтэй холбогдуулан E-Business платформд бүх төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг холбож байна. Энэ жил зөвшөөрлийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан зөвшөөрөл, мэдэгдлийн системийг холбож байна. Ингэснээр иргэд зөвшөөрлийг хүсэлтээ цахимаар гаргахаас гадна шийдвэрлэлтийн явцыг мэдэгдэл хүргэх системээр иргэн хүлээн авах боломжийг гаргахаар ажиллаж байна. Ийнхүү ЦХИХХЯ-аас хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлаа товч танилцууллаа. Асуултад хариулахад бэлэн байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Одоо оролцогчдоос ирүүлсэн нэрсийн дагуу эхнээс нь дуудаж үг хэлүүлье. Оролцогчид нэрсийн дарааллаар санал, мэдээллээ 3 минутад багтаан хэлнэ та бүхэнд үүнийг сануулъя. Ш.Арвин, солигдоод суугаарай. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Сангийн яамны ТНБД болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД нар энэ илтгэлтэй холбогдуулан асуултаа асууя.

Оролцогч Ш.Ариунаа: За Баярлалаа. Би Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо ТББ-ын тэргүүн Жендэрийн үндэсний шинжээч Ш.Ариунаа гэж хүн байна. Энэ асуулт асууж, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байгаа талуудад баярлалаа. Малчны тухай хууль батлагдсан нь нэлээд томоохон ач холбогдолтой.

Гэхдээ энэ удаад би 7 дугаар зүйл болон 6 дугаар зүйл дээр саналаа хэлье. Энэ хууль бодлогоо тодорхойлсон боловч 4 дүгээр зүйлээс эхлэн малчдад ийм дэмжлэг үзүүлнэ гэж алим үзүүлээд 7 дугаар зүйл дээр тодорхой хэмжээний дэмжлэг өгнө гэж хэлээд, хойшоогоо санхүүгийн дэмжлэг нь бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон гэдэг өөрийн бодлоо хэлье. Нийтийн сонсголын тухай хуулийн 8.1-д заасны дагуу энэхүү ерөнхий сонсгол нь хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий үйл ажиллагаанд хяналт, дүгнэлт, үнэлгээ өгөх ёстой юм байна.

Үүнтэй холбогдуулан миний эхний асуулт хамгийн эхний судалгаа хийж байсан хүмүүсээс асуугаад орхиё. Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхээр хүлээсэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нарт ямар хүндрэл гарч байсныг хариулаасай. Дараагийн 4 дүгээр зүйл дээр малчдыг их дэмжиж байгаа мэт

заалтууд орсон. Ялангуяа 4.2 дээр орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулж, зээлийн хөнгөлөлт үзүүлэхээр заасан. Энэ нь эдгээр зээлүүд нь үндсэндээ малчдыг дэмжиж байгаа бус, арилжааны банкуудын зээлийн хөнгөлөлтийг улсын төсвийн мөнгөөр арилжааны банкуудыг угжиж байгаа гэж хэлнэ. Миний ард байгаа малчид боломжтой бол танай нутаг оронд эдгээр олон төрлийн зээлийг 20 сая төгрөгөөр автоматаар тараасан байсан.

Энэ мөнгийг авсан зарим малчид зээлээ хуульд заасан чиглэлээр бус, хүүхдийнхээ сургалтын төлбөр, машинд зарцуулж, улмаар арилжааны банкны барьцаанд орсон тохиолдол байгаа. Тийм тохиолдол байсан бол гараа өргөнө үү? Одоо хариулах боломж байхгүй байж магадгүй ч, би энэ чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд ингэж хэлж байна. Түрүүн хэлсэнчлэн 7 дугаар зүйл дээр малчдыг дэмжинэ гэж хэлээд байгаа. Дүгнэлтийн хувьд би ХХААХҮЯ-д маш муу үнэлгээ өгөх гэж байна. Тус яам хуулиа ойлгоогүй байна. 7 дугаар зүйлийн 7.2 дахь хөтөлбөрийг ХХААХҮЯ ганцаараа гаргах боломжгүй. Иймд энэ хууль дээр өөрчлөлт хийгээсэй. Дараагийнх нь Сангийн яамнаас асуултууд байна. Сая таны танилцуулсан үр дүнгүүдээс нь харлаа. Одоо боломжтой бол нэг асуултанд хариулт авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 3 минутад саналаа хэлээд явъя. Төрийн байгуулага сая хэлсэн асуултад уялдуулаад ер нь гишүүдийнхээ хариулт дотор үүнийг бас давхар хамруулаад явах нь зүйтэй байх гэж бодож байна. Дараагийн оролцогч О.Отгонцэрэн, 4 дүгээр микрофон.

Оролцогч О.Отгонцэрэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би Архангай аймгийн Хашаат сумын малчин Осорын Отгонцэрэн байна. Би хүүхдийн боловсролтой холбоотой асуудлаар саналаа өгсөн. 6 настай хүүхдийн хичээлийн сургалт, боловсролын талаар түрүүн саналаа өгсөн байсан. Тэгэхээр би боломжоо ашиглаад ярьж гэж бодож байна. Мэдээж мэдлэг, боловсрол чухал. Гэхдээ 6 настай хүүхэд сургуульд элсэн орж байгаатай холбоотойгоор хөдөөгийн залуу малчдад нэлээд асуудал үүсэж байна.

Урьд нь хүүхэд 7 настайдаа сургуульд ордог байхад хөдөөгийн хүүхдүүд багаасаа биеэ даадаг тул залуу малчид хүүхдээ дагаж сум суурин барааддаггүй байсан. Хүүхдүүд 7–8 насандаа сургуульд ороод дотуур байранд, эсвэл ах эгч, хамаатан садандаа байдаг байв.

Харин одоо 6 настай хүүхэд элсэн ордог болсноор тэр хүүхэд эх эцгийнхээ өврөөс гарч амжаагүй байхад сургуульд орох болж байна. Ингэснээр 20 хэдтэй залуу малчид хүүхдээ дагаж сум суур барааддаг. Залуу малчин өвөл, хаврын хүнд цаг үеийг даван туулахад асуудал үүсч байна. Улмаар залуу малчид малаа орхиж, сум суурин барааддаг болсон. Эсвэл өнөөдөр залуу малчин гэр бүлийн янз бүрийн асуудал ч үүсч байна. Тийм учраас 6 настай хүүхэд малын зүсээ ч мэдэхгүй байж байтал эхийнхээ өврөөс ч гараагүй, малынхаа зүсийг ялгаж ч мэдэхгүй байхад сургуульд явахад хүрч байна.

Энэ нь хаврын амралт байхгүйтэй ч холбоотой болж байна. Хаврын амралт хамгийн багадаа нэг сар болмоор байна. Тэгж байж хүүхэд багаасаа хотжихсон хөдөөгийн амьдрал, ахуй, соёл, уламжлалаа багаасаа алдаж байгаа учраас хаврын амралт дор хаяж сар байх. Хавар бол малчдын хувьд хамгийн ачаалалтай, хүн бүл цөөтэй үе тул хүүхдийн амралт чухал ач холбогдолтой. Хотын хүүхдүүд өвлийн утаа униараас ангижрах, хөдөөгийн хүүхдүүд хаврын ачаалалтай үед гэртээ туслах боломжтой болох үүднээс хаврын амралтыг анхаарч өгөөч гэдэг саналыг би түрүүнд тавьсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Г.Баярбямба үг хэлнэ.

Оролцогч Г.Баярбямба: Би Сангийн яамнаас асууя. Энэ хуулийн Малчны хөгжлийн сан, Малчны хөгжлийн төв, хөнгөлөлттэй зээлийн журмуудыг гаргахад Сангийн яамтай холбоотой боловсруулагдах юм байна гэж ойлголоо. Хууль хэрэгжихэд батлагдах ёстой 11 журмаас зөвхөн 2 журам нь 2 жилийн хугацаанд батлагдаж, амьдрал дээр хэрэгжиж эхэлсэн. Үлдсэн журмууд нь хэдэн жилийн дараа батлагдах вэ? Энэ нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт нь нийгмийн даатгалтай холбоотой. Нөхөн тооцох төсвийг нэг жилд 30 хэдэн тэрбум төгрөгөөр шийдэх боломжтой мөнгө. Олон жил хүч хөдөлмөрөө зарцуулсан мал аж ахуйн салбарыг аваад байгаа ахмад малчид нийгмийн даатгалаа төлж байж нийгмийн баталгаа нь сайжрах ёстой атал төсвийн асуудлаас болж энэ хуулийг хэрэгжүүлэхгүй гацаагаад 2 жилийн нүүр үзлээ. Энэ төсвийг хэдэн жилийн хугацаанд шийдвэрлэх вэ гэдэг дээр хариулт авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийнх нь оролцогч Ц.Бийбат байхгүй байна. Н.Баярсайхан, “Хил хязгааргүй алхам” ТББ 4 дүгээр микрофон.

Оролцогч Н.Баярсайхан: За баярлалаа. Би “Хил хязгааргүй алхам” байгууллагын төлөөлөл бөгөөд малчдын эрхийн асуудлаар ажилладаг. Ялангуяа уул уурхай, зам тээвэр, хилийн боомтын нөлөөллийн бүсэд амьдарч буй малчдын эрхийн асуудлаар ажилладаг. Хугацаандаа багтахгүй бол тодорхой саналаа бичгээр өгнө. Юуны өмнө би зарчмын байр суурьтай байгаа. Өнөөдөр хэлэлцэж байгаа хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь маш чухал. Үүний төлөө УИХ-ын дэд дарга болон Байнгын хороонд талархал илэрхийлье.

Гэхдээ энэ хууль халамжийн хууль уу, эсвэл малчны эрхийг баталгаажуулах хууль уу гэдэг эргэлзээ цаг ямагт байдаг. 2024 оны 06 дугаар сарын 04-нд хуулийг батлахад бид малчидтайгаа хамт уг процессыг ажиглаж байсан. Хуульд малчны эрх зүйн байдлыг тодорхойлно гэж заасан атал эрх зүйн байдлыг нь тодорхойлохгүйгээр шууд мал аж ахуйн бүтээмжийг тодорхойлоод явсан байна.

Тийм учраас энэ хуулийн амин сүнс болох, малчин хүнээ тойрсон малчны эрх зүйн байдлыг баталгаажуулсан томъёолол ороогүй байна. Иймд энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй. Мөн хууль хоорондын уялдаа хангалтгүй байна. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль болон Малчны тухай хуулийг зайлшгүй уялдуулах шаардлагатай. Энэ хуульд уул уурхайн нөлөөлөлд өртсөн бүсэд малчид амьдардаг гэдгийг тооцоогүй байна. Малчид өвөлжөө, хаваржааныхаа газрыг авъя гэхээр уул уурхайн лицензтэй давхцаж байгаа тул газрын гэрчилгээ олгохгүй байна.

Гэтэл уул уурхайн лицензийг олгохдоо хэд хэдэн малчны газартай давхцуулан олгодог. Улаанбаатар хотод нэгэнт эзэмшиж, ашиглаж байгаа хүний газар дээр давхцуулан газар олгодоггүй атал хот, хөдөөд нэг эрхийг ялгаатай хэрэглэж байна. Иймд энэ хуулийн салбар дундын уялдааг хангах шаардлагатай. Энэ хуулийг “Малчны эрх зүйн байдлын тухай хууль” болгон, дахин харж боловсруулах хэрэгтэй гэсэн саналтай байна. Энэ хууль техникийн шаардлага хангахгүй байна гэж үзэж байна. Хуулийн хамрах хүрээ хэн болох нь тодорхойлогдоогүй, төрөөс малчны талаар баримтлах зарчим хуульд бичигдээгүй

байна. Иймээс энэ хууль хэрэгжихгүй байгаагийн үндсэн шалтгаан нь хууль өөрөө юм. Зарчим тодорхойлогдоогүй учраас ихэнх заалт нь захиргааны шийдвэрээр хэрэгжих болно. Тэгвэл захиргааны байгууллагуудаас гарах шийдвэр өөрчлөгдөх тусам хуулийн хэрэгжилт тогтвортой байж чадахгүй эрсдэлтэй. Тийм учраас Байнгын хороо болон хууль санаачлагч энэ дээр анхаараасай. Газрын эрхийг баталгаажуулна гэж хоёр заалтад заасан байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ч.Саранмандах, 3 минутад багтаан үг хэлнэ үү. Дараа нь М.Бямбаахүү бэлдэж байгаарай.

Оролцогч Ч.Саранмандах: Сайн байцаана уу. Би Ч.Саранмандах байна. Ундармаа, Бямбаахүүгийн оронд үг хэлж байна. Нэгдүгээрт, нэг санал тавимаар байна. Энэ хуулийн төслийг батлах үйл явц яг одоо энэ танхимд байгаа дүр зурагтай адил болсон. Хуулийн хэрэгжилтийг шууд утгаараа биеэрээ мэдрэх, амьдралд нь нөлөөлөх хүмүүс яг одоо хойно сууж байна.

Маргаашийн болон өнөөдөр үдээс хойшийн сонсгол дээр эдгээр хүмүүсийг урагш суулгамаар байна. Эдгээр хүмүүс концертод оролцох гэж ирээгүй. Тэдэнд цаас, бал өгч, өөрсдөө тэмдэглэж аваад, бодол, үзэл бодолтойгоо гарах ёстой гэж би үзэж байна. Иймд эдгээр хүмүүсийг хоосон байгаа суудлуудад суулгаасай. Энэ миний нэгдүгээр санал.

Хоёрдугаарт, хуулийн 9.8-д малчны сонсох өдөр гэж оруулсан байгаа. Гэтэл зүгээр сонсоод өнгөрөх биш, сонссоноо хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг механизм маш чухал. Үзэл бодол илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөө байгаа атал тэрхүү саналыг сонсож, хэрэгжүүлэх механизм нь чухал.

Иймд хуулийн 9.8-д заасан “малчны сонсох өдөр” гэснийг Г.Тэмүүлэн гишүүнээ “Төр, Малчин хоёрын зөвлөлдөх өдөр” гэж өөрчлөөсэй гэсэн саналтай байна. Хоёрдугаарт бас нэг чухал зүйл бол малчны тодорхойлолт юм.

Малчны тухай хууль бол тодорхой субъектийг тодорхойлсон хууль. Гэтэл малчин гэдэг тодорхойлолтыг хуульдаа оруулалгүйгээр хөдөлмөр эрхлэлтийн хуулиар зохицуулахаар заасан. Малчин гэдэг хүн зүгээр л мал аж ахуй эрхлээд орлого олдог иргэн төдий биш, соёлын өвийг тээгч юм. Мал аж ахуй бол багш, цагдаа, төрийн албан хаагч шиг цагийн ажил биш. Малчин 8 цагийн ажил хийдэггүй, тэгэхээр 24 цаг, 365 өдрийн ажил хийдэг. Иймд Г.Тэмүүлэн гишүүнд хандаж хэлэхэд малчны тодорхойлолтыг заавал энэ хуульд оруулах хэрэгтэй. Энэ нь хөдөлмөр эрхлэгчдээс тэс өөр асуудал. Үүнийг 3.1.3-т тусгамаар байна. Мөн түрүүн Сангийн яамнаас хэлсэн зүйлтэй холбогдуулан хуулийн төслийг анх боловсруулсан асуудлаар хэлэх гэсэн юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ч.Саранмандах аа, уучлаарай. Энэ нь учиртай зүйл. Энэ бол хэлэлцүүлэг биш. Тухайн хуулиар хэлэлцүүлэг хийж байгаа бол Та бүхнийг бүгдийг урьж, бүтэн суулгаж, хэлэлцүүлэг хийж, саналыг авдаг. Харин энэ бол ерөнхий хяналтын сонсгол. Ерөнхий хяналтын сонсгол гэдэг бол УИХ Хяналт шалгалтын тухай хуульдаа өөрчлөлт оруулж том алхам хийгээд тухайн хуулиар УИХ-ын гишүүд төрийн байгууллагууд буюу Засгийн газрын бүтцэд байгаа байгууллагуудаа сонсож, тэдэнтэй хариуцлага тооцож, асуудлаар ярилцдаг ийм хяналтын сонсгол. Харин ч Та бүхнийг урьж авчирч, ярих боломж олгож байгаа. Энэ дэгийг уншвал та бүхнээс санал авч яриулах дэг байхгүй, УИХ-ын гишүүд хэлэх ёстой.

Өнөөдөр УИХ-ын гишүүд ард иргэдээ төлөөлж байгаа учир та бүхнээр хэлүүлж, тодорхой саналыг тань тусган асуулт асууж саналыг хэлүүж байгаа. Шаардлагатай гэвэл дараа нь зөвхөн иргэд болон олон нийтийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийж болно. Үүнийг та бүхэн ойлгоорой. Ард иргэд ч энэ сонсголын учрыг ойлгож, тунгааж байгаа байх.

УИХ-аас хяналт шалгалтын тухай хуульдаа том өөрчлөлт оруулж, тодорхой асуудлуудыг нээлттэй, олон нийтэд мэдээлэл өгдөг дэг, журам бий болгосон гэдгийг та бүхэнд тайлбарлая. Одоо УИХ-ын гишүүд үлдсэн хоёр илтгэлтэй холбогдуулан асуулт асууна. Нэрсээ өгнө үү. Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Очирбатын Амгаланбаатар гишүүн асуултаа асууя.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Малчдын талаар төрөөс баримтлах бодлого буюу 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйл дээр малчны МАА-н үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх суурь нөхцөл байгалийн нөөц, бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулах гэдэг дээр 4.1.3-т хөдөөд хүйсийн зохистой харьцааг хангах бодлогыг хэрэгжүүлэх гэж заасан дээр яг ямар үйл ажиллагаа хийгдсэн бэ?

4.1.5-д малчдын залгамж халааг бэлтгэх гэснийг хэрэгжүүлэхээр Засгийн газар болон холбогдох яамдаас яг ямар үйл ажиллагаа хийж, ямар санхүү мөнгө зарцуулсан бэ? Мөн 4.1.7-д мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшнийг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх, цахим шилжилтийг нэвтрүүлэх зэрэг хуульд заасан заалтуудын хүрээнд яг ямар санхүү мөнгө зарцуулж, ямар бодлого хэрэгжүүлсэн бэ гэдэг асуулт байна. Хариулсны дараа эргэж тодруулга хэлнэ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгууллагуудаас хариулт авъя. ХХААХҮЯ болон Сангийн яамнаас хариулт авъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: О.Амгаланбаатар гишүүний асуултад хариулт өгье. Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшнийг ахиулах цогц бодлогын талаар хариулъя. Малын гаралтай түүхий эдийн үнэ цэн муу, борлуулалт тааруу, хаягдал ихтэй байна. Үүнтэй холбогдуулан баруун бүсэд Ховдын шинэ үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийн асуудлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэж, энэ жил ажил нь дуусаж байна. Төвийн бүсэд Эмээлтийн эко аж үйлдвэрийн парк дээр хөрөнгө оруулалт хийж дэд бүтцийг шийдсэн. Ингэснээр Улаанбаатар хотод байгаа 13 арьс ширний үйлдвэр Эмээлт рүү шилжиж, нэгдсэн байдлаар төвлөрч ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Мөн малын гаралтай хаягдал, ялангуяа ясаар бордоо хийдэг хэд хэдэн аж ахуйн нэгжид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж байна. Гарч байгаа түүхий эд буюу анхан шатны үйлдвэрлэлийн 3 үйлдвэрийн бордоог энэ жил газар тариалангийн бүс нутагт туршиж байна. Ингэснээр үндэсний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ААН-үүдэд газар тариалан, мал аж ахуйг хослон хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой алхам хийж байна. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх томоохон зорилт дэвшүүлсэн.

Ингэснээр үндэсний үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй болон хөрөнгө оруулалтын зээл олгож, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ. Хуучин түүхий эдийг зөвхөн

ноос, ноолуурыг угаадаг байсан бол одоо самнах, ээрэх, сүлжих технологийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал нэмэгдэхээр анхан шатны түүхий эд бэлтгэлийн тогтолцоо ч дагаж хөгжих нөхцөл бүрдэж байна.

Түүнчлэн ХХААХҮЯ-аас санаачлан “Арьс шир баялаг” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Зүүн 3 аймгаас эхлэн зуны улиралд хаягдаж байгаа арьс ширийг анхан шатны тордолт хийж, давсалж хураан үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлэх тогтолцоог бий болгох төслийг өнгөрсөн 7 хоноогоос эхлэн хэрэгжүүлж байна. Энэ ажилд үндэсний үйлдвэрүүд, ХАА-н бирж, малчдын төлөөлөл оролцож, анхан шатны тордолт буюу давслах процесс дээр тодорхой хэмжээний үндэсний үйлдвэрүүдээ дэмжлэг үзүүлж, зуны улиралд хаягддаг арьс ширэн дээр хөрөнгө оруулалт хийж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам хариулъя.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: О.Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Түүнд ХХААХҮЯ-аас хэлсэн нэмүү өртөг шингээх, бий болгох, боловсруулах үйлдвэрлэлийн түвшнийг ахиулах чиглэлээр шинэ хоршоо, Цагаан алт хөтөлбөр, хүнсний хангамж, аюулгүй байдлын хөтөлбөрийн хүрээнд нийтдээ тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон.

Үүнээс гадна хүйсийн тэнцвэрт байдалтай холбоотой асуулт асуусан гэж ойлгосон. Энэ дээр манай яам шууд хариуцахгүй ч, орон нутагт ажиллаж амьдарч байгаа иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах, орон нутагт амьдрахад таатай орчныг бүрдүүлэх үүднээс улсын төсвөөс болон гадаадын зээл тусламж, орон нутгийн хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Тоогоор дурдвал 2024–2025 онд улсын төсвөөс 1,731 төсөлд 5,2 их наяд төгрөг, гадаадын зээл тусламжийн төслөөс 102 төсөл дээр нийтдээ 4,2 их наяд төгрөг, орон нутгийн төсвөөс 6,1 их наяд орчим төгрөг буюу нийтдээ 16 орчим их наяд төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалт хэлбэрээр орон нутагт олгосон байна.

Энэ дотор яг ямар ажил хийгдсэн бэ гэвэл, цахилгаан, дулаан, инженерийн дэд бүтэцтэй холбоотой 77 төсөл 19 аймагт, зам, гүүрийн 166 төсөл 21 аймагт хэрэгжсэн байна. Мөн 21 аймгийн хүрээнд 173 сургуулийн барилгыг эхлүүлж, 18 аймагт 82 эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөл, засвар үйлчилгээ, 154 цэцэрлэг, 21 аймагт 149 соёл, спортын цогцолбор байгуулах ажлыг улсын төсөв болон гадаадын зээл тусламж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн байна. Мөн ипотекийн зээлтэй холбоотой асуудлыг дэлгэрүүлээд товчхон мэдээлэл өгье. Ипотекийн зээл бол зорилтот хөтөлбөрийн 6 хувийн хүүтэй зээл бөгөөд орон даяар хэрэгжиж байна.

Үүн дээрээ орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж, амьдарч байгаа аж ахуйн нэгж, иргэдэд 3 хувийн хүүтэй болгож өгч байна. Нэг ёсондоо 6 хувийн хүүтэй зээлээс нэмж 3 хувийн хөнгөлөлтийг орон нутагт зээл авч, аж төрж, худалдан авалт хийж байгаа хүмүүст олгож байна. Энэ зээл нь арилжааны банкны эх үүсвэрээр биш, Засгийн газар болон Монголбанкны эх үүсвэрээр тухайн орон нутагт ажиллаж, амьдарч байгаа иргэдэд олгогддог. Хүүг нь Засгийн газар болон Монголбанк хариуцаж байгаа учир хөнгөлөлттэй нөхцөлөөр явдаг. Арилжааны банк зөвхөн зээлийг дамжуулан зээлдүүлэх үүрэг хүлээдэг гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам байна уу? Үдээс өмнө байсан, дуудаарай. Хэдэн номер бэ? Асуулт нь холбоотой биш байна гэж байна. Дахиад О.Амгаланбаатар гишүүн.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Хөдөөд хүйсийн зохистой харьцааг хангах бодлогыг хэрэгжүүлэх гэж байна. Тэгвэл ямар бодлого хэрэгжүүлсэн бэ, ямар зардал санхүү гаргасан бэ гэж асуусан. Мөн малчдын залгамж халааг бэлтгэхэд ямар бодлого байна вэ гэж асуусан. Гэтэл энэ дээр хариулсангүй.

ХХААХҮЯ нэг өдрийг аргацаасан хариулт өгч байна. МАА-н салбарын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх тогтолцооны хувьд та нар юу ч хийгээгүй байна. Та нарт би зөвлөө. 1921 оны дараа хамтрал гэж байсан, дараа нь нэгдэл гэж байсан, худалдаа бэлтгэлийн анги гэж байсан. Худалдаа бэлтгэлийн анги нь босоо тогтолцоотой, нэгдэл нь хэвтээ тогтолцоотой байсан. Өнөөдөр түүнийгээ орчин үеийн болгож сэргээхээс өөр замгүй байна. Тэгэхээр би үүнийг та нараас асууж байгаа болохоос, өнөөдөр ясны үйлдвэр энд ярих асуудал биш.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя, дараа нь ХХААХҮЯ хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг: Маргааш 15 цаг 10 минутаас манай яамнаас мэдээлэл өгөхөөр байгаа. Тэр мэдээллийн цагтаа нэмэлт мэдээлэл өгье. Би яг хариуцсан газрынх нь биш болохоор одоо тодорхой хэлж чадахгүй байна. Мэдээллээ бэлдээд маргааш өгье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Маргааш тэгвэл хариулт авъя. ХХААХҮЯ ч маргааш сайдынхан танилцуулахдаа бүтэн дэлгэрэнгүй мэдээлэл өгье. О.Амгаланбаатар гишүүн, маргааш үргэлжлүүлье. Дараагийнх нь Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн : Сангийн яам болон ЦХИХХЯ-аас, хэлэлцэж байгаа хоёр асуудлаар асуулт асууя. Үндсэндээ онцолж хэлэх гэж байгаа нь, ХАА, МАА-н салбарын бодлого нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан стратегийн асуудал.

Тэгэхээр энэ дээр онцгойлон анхаарах ёстой асуудал байна. Сангийн яам аа, та бүхэн хариуцлагагүй ажиллаж байна. Магадгүй Монгол Улсын Ерөнхий сайд шиг өөрийн үзэмжээр бодлого, хуулийн заалтыг ялгаварлан хэрэгжүүлснээс болоод хууль хэрэгжилт хангалтгүй байна. Бид нар хугацаа өнгөрөөд, “хэсэг борооны дараа цув нөмрөв” гэдэг шиг асуудал болгохгүйн тулд хэрэгжилтийн явц дээр энэ асуудлыг ярьж байгаа юм. Хугацаатай зарим заалт хэрэгжээгүйгээс болоод Үндсэн хуулийн зөрчил рүү орж байгаа асуудал байна. Тэгэхээр нэг яам дангаараа хариуцлага хүлээх үү?

Өнөөдөр ХХААХҮЯ, ГХНХЯ та бүхний хариуцлагагүйгээс болоод, та бүхэн зөвшөөрөл өгөөгүй учраас Засгийн газарт орж чадаагүй гэдэг асуудлыг нэгдүгээрт ярьж байгаа. Хоёрдугаарт, та бүхний ажил үүрэгтэй холбоотой, нягтлан бодох бүртгэл болон Аудитын газартай хамааралтай асуудлыг асууя. Энэ хууль дээр малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, барьцаа хөрөнгө болгох, хөрөнгийн үнэлгээжүүлэх гэсэн заалт орж ирсэн байгаа. Энэ бол цэвэр Сангийн яам журмыг нь гаргах асуудал. Малыг хөрөнгө гэж үзэхгүйгээр, хөрөнгийн үнэлгээний

стандартыг баримтлахгүй явж байгаа байдлыг хэзээ өөрчлөх вэ?

Энэ нь Малын генетик нөөцийн тухай хуульд ерөнхий үзэл санаагаараа байгаа. Малчны тухай хууль дээр хөрөнгийн үнэлгээг та бүхэн бий болгоосой. Энэ нь өөрөө биологийн хөрөнгийн бүртгэл бөгөөд олон улсын стандартын дагуу тухайн бодит үнэ цэнийг нь тодорхойлдог байх асуудал юм. Малыг барьцаанд тавьдаг, даатгуулдаг, компанийн үндсэн хөрөнгөөр бүртгэдэг бол хөндлөнгийн үнэлгээ хийх шаардлагатай болдог. Гэтэл энэ санхүүгийн үйлчилгээ мал аж ахуйн салбарт байхгүй байна. Та бүхэн үүнийг гаргаж ирэхгүй, хуульд заасан журмыг хийхгүй байна.

Санхүүгийн зах зээл дээр малчин оролцох, эрхийг нь хангах, хөрөнгийг нь бодитоор, зөв үнэлэх, үнэлэмжийг нь зөв тогтоох асуудлыг гаргаж ирэх нь нэгдүгээрт шаардлагатай байна. Урамшуулалтай холбоотой асуудлыг харахад, энд сууж байгаа малчид магадгүй 2 жилийн өмнө ноосолсон хониныхоо ноосны урамшууллыг авч чадаагүй байна. Магадгүй 2 жилийн өмнө хөөвөрлөсөн сарлагийнхаа хөөврийн урамшууллыг ч авч чадахгүй байна. Үндэсний үйлдвэрийг дэмжих үйлдвэрүүдэд түүхий эдээ өгсөн бол түүнийгээ 2 жил хүлээдэг.

Магадгүй ялгаварлан гадуурхаж, төсөвт суусан мөнгийг хуваарилдаггүйгээс болоод 2 жил хүлээдэг асуудлыг хэзээ цэгцлэх вэ? Хоёрдугаарт, ЦХИХХЯ-д хандъя. Та нар ажлаа боломжийн хийж байна уу гэж харлаа. E-Mongolia дээр мянган үйлчилгээ явж байгаа гэсэн. Тэгвэл малчинтай холбоотой олон системийг E-Mongolia дээр нэгтгээд, малын эрүүл мэндийн үйлчилгээ, малын индексжүүлсэн даатгал, дансны лавлагаа зэргийг нэг булан болгон гаргаасай.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: Малыг хөдлөх хөрөнгө гэж үзэж хөрөнгийн үнэлгээ хийх шинэ үйлчилгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар оруулсан байгаа. Г.Тэмүүлэн гишүүний хэлж байгаа үнэн. Яг журам нь эцэслэн батлагдаагүй байна. ХХААХҮЯ-аас манай яам руу энэ журмыг баталъя гэсэн санал ирсэн. Бид энэ дээр ажиллаж байгаа. Тун удахгүй энэ журмыг хамтран батлах ажлыг зохион байгуулна. Анхааран ажиллая.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ЦХИХХЯ. Урамшууллын талаар Сангийн яам хариулъя.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: 2 жил түүхий эдийн урамшуулал олгоогүй гэж байгаа. Одоо байгаа сүү, ноос, арьс ширний урамшуулал тухайн жилийнхээ төсөв дээр тавигдаад явж байгаа. Гэхдээ нэг ийм бодлогын асуудал байна. Энэ урамшууллыг эхлүүлэхдээ, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт хамгийн их урамшуулал явдаг хэдий ч, урамшуулал хэзээ эхэлж, хэзээ дуусах нь тодорхойгүй байна. Нэг эхэлчихээд хэзээ ч дуусдаггүй, 10 жил явж байгаа урамшуулал ч байна. Тэгэхээр урамшууллыг ямар үед эхлүүлж, ямар зорилтод хүрсний дараа дуусгах вэ гэдгийг тодорхой зааж өгөхгүй бол одоо явж байгаа урамшууллууд дуусахгүй мэт үргэлжилдэг. Энэ нь эргээд бүтээмжийг нэмэгдүүлэх, инновацлаг байдлыг хязгаарласан зохицуулалт болж байна. Тэгэхээр цаашид ХХААХҮЯ-тай хамтран, Сангийн яамны зүгээс энэ урамшууллыг ямар хүнд, ямар зорилтот байдлаар олгох ёстой, урамшууллын тогтолцоо ямар түвшинд хүрсэн үедээ дуусдаг болох вэ гэдэг аргачлал, журмыг илүү тодорхой болгох ёстой гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тодорхой болгоод оруулж ирээрэй. ЦХИХХЯ хариулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран: Гишүүний саналыг хүлээж авлаа. Тэгж хөгжүүлэх боломжтой. Бид яг үүнтэй адил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан буланг хөгжүүлсэн. Мөн оюутанд зориулж оюутны буланг хөтөлж, дотор нь оюутантай холбоотой үйлчилгээг нэгтгэж оруулсан. Тэгэхээр таны саналыг хүлээж авлаа. Малчны буланг оруулъя. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл E-Mongolia-д малчны булан гаргах нь байна. Г.Тэмүүлэн гишүүн тодруулна уу.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн: Нэг минутад нэмж тодруулъя. Сангийн яам, би яагаад урамшууллын асуудлыг асууж байна вэ гэвэл, Малчны тухай хуулийн 9.10, 9.4 дээр түүхий эдийнхээ нэр төрөл, чанарын үнэлэмжээс хамаарсан урамшуулал, үнийн үнэлгээг тогтоох гэдэг асуудлыг тавьж өгсөн байгаа. Тэгэхээр та бүхэн өнөөг хүртэл урамшууллаа чанартай нь уяж чадахгүй байна.

Энэ журмаа гаргах асуудлыг тавьж байгаа юм. Урамшуулал гэдэг зүйлийг халамжийн бодлого шиг бодож байна. Энэ нь тийм биш. Энэ бол төрөөс үзүүлж байгаа нөхцөлт дэмжлэг юм. Үйлдвэрүүдийг бид түүхий эдээр хангаж байна. Харин эсрэгээрээ, бид үүнийг чанартай нь уялдуулж, үйлдвэрт хэрэгтэй түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх асуудал байна. Тэгэхээр энэ журмаа хийгээгүй байж урамшууллыг халамжийн бодлого шиг, дуртай үедээ өгдөг өгдөггүй асуудал болгож болохгүй. Зах зээлтэйгээ холбох хэрэгтэй.

Энэ автоматаар тооцдог болох хэрэгтэй. Дээрээс нь малчин өөрөө хянадаг тэр тогтолцоог E-Mongolia дээрээ урамшуулалтайгаа холбож өгөх хэрэгтэй байна. Тэгвэл малчин нэхэж шаардах ил тод, цахим урамшуулалтай болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Жишээ нь сүүтэй холбоотой асуудлыг авч үзвэл, Монгол Улс жилийн 3 улиралд нь хуурай сүү ууж байна. Мал аж ахуйтай орон хуурай сүү ууж байна. Тэгэхээр малчдыг сүүгээ авчирч өгөөч гэх технологийн болон зах зээлийн хөшүүрэг байх ёстой. Энэ нь малчдыг дэмжиж байгаа явдал биш, харин хотынхны хангамжийг сайжруулах эдийн засгийн хөшүүрэг юм. Саяын асуулттай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуултаа асууя.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Сангийн яамны танилцуулга дээр 2026 оны улсын төсөвт малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах чиглэлд 55 тэрбум төгрөг суусан байна. Энэ нь яг ямар шатандаа явж байна вэ? Төсвийн зарцуулалт хэрхэн явж байна, хэдэн төгрөгийн гүйцэтгэл гарсан бэ гэдэг нэг асуулт.

Хоёрдугаарт, ЦХИХХЯ-аас асууя. Аймгуудад хөдөөгийн малчид хоорондоо харилцаа холбоо тогтоох асуудал маш чухал байна. Жишээ нь малаа эрэх, сурах, нэгнээсээ мэдлэг, мэдээлэл олж авах, олон улсын нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл авах зэрэг хэрэгцээ интернэт орчноос хангагдаж болж байна. Гэтэл малчид яг бүрэн хамрагдаж чадахгүй байна. Жишээ нь Баянхонгор аймгийн 5 сум дээр үүрэн холбооны сүлжээний тендер зарлагдаж, компани нь сонгон шалгаруулалтад шалгарсан.

Гэтэл ажлаа гүйцэтгэхгүй, чадна гэж ажил аваад хийхгүй, төсөв мөнгөө нэмүүлэх гэж хойш урагшаа гүйж, нэмэгдэхгүй бол “би чадахгүй” гэж хаяж байна.

Энэний цаана малчид хохирч байна. Хөдөө очихоор нөгөө ярьдаг юмаа яриад, очиж нэг худал ярьдаг болоод ирж байна. Ингээд бид нарт малчид уурладаг болж байна. Яг өнөөдрийн хэлэлцүүлэг ийм л явж байна. Яамныхан нэг хариулттай, бид нар уураа гаргаж, малчид буюу иргэддээ загнуулдаг, тэдний урдаас юм хэлж чадахгүй, худал хулгайч мэт харагдаж байна. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч. Та нар яаж шийдэх вэ? 2 жил болсон, бүр сүүлдээ ор үндэс ч үгүй, сураг ч үгүй боллоо. Ийм хариуцлагагүй байдлыг яаж засаж залруулах вэ? Энэний цаана малчдын, олон хүмүүсийн асуудал ингэж хаягдаж, хохирч байна. Үндсэндээ мал алга болоход, эсвэл малаа ойр хавийнхаа улсуудаас утсаар асуудаг байсан байхгүй юу “манай ийм мал алга, тэдэн тооны мал хаана явна, нааш нь эргүүлээрэй” гэх мэтээр. Ийм асуудал байна. Дараагийн асуудал. Цахим мөрийтэй тоглоом, цахим залилан маш их болсон.

Тэр тусмаа малчин иргэд маш их хохирч байна. Одоо бүр “та сугалаанд хожлоо, хэдэн зуун сая төгрөг хожлоо, та 5 сая, 6 сая төгрөг шилжүүлчих” гэж дээрээс нь нэмж мөнгийг нь авч, нөгөө хожлын хэдэн зуун сая төгрөг нь алга болж байна. Ийм цахим залилан, гэмт хэрэг малчид дээр маш их гарч байна. Ноос, ноолуурынхаа мөнгийг алдсанаас болоод амьдрал ахуй нь хүрэхээ байж, улмаар гэр бүл салах хүртэл асуудал болж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ЦХИХХЯ хариулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран: Гишүүний асуултад хариулъя. 2024 онд 144 багийг холбохоор тендер зарласан байдаг. Тухайн үед ЦХИХХЯ хэсэгчлэн дэд бүтэц, дараа нь байр, байшин, сүлжээ гэсэн байдлаар зарласан. Зарим байрны хувьд орон нутгаасаа газрын зөвшөөрөл аваагүй зэргээс болоод тухайн цэг дээр сүлжээний дэд бүтэц байгуулах боломжгүй болсон тохиолдол гарсан.

Тийм болсон учраас бид дараа нь судалгаанд үндэслэн, энэ жил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 60 баг, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаар 15 баг буюу нийт 75 багийг улсын хэмжээнд холбохоор төлөвлөсөн. Сонгон шалгаруулалт хийхдээ бүх дэд бүтцийг байгуулаад, эцэст нь хүлээлгэж өгөх байдлаар зарласан бөгөөд одоогоор амжилттай хэрэгжиж байна. Энэ 75 баг холбосны дараа үлдэх нь 100 орчим баг байгаа. Үүнийг 2028 онд багтаан бүх багийг сүлжээнд холбохоор төлөвлөж байна.

Хоёрдугаарт, цахим орчинд гарч байгаа залилантай холбоотой гомдол, санал маш ихээр ирж байна. Үүнтэй холбогдуулан бид Кибер цагдаагийн газар, олон улсын платформ Мета компанитай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл, залилан явуулж байгаа пэйжүүдийг Харилцаа холбооны зохицуулах хороо болон Цагдаагийн ерөнхий газраар дамжуулан мэдэгдэж хаалгадаг. Хамгийн гол асуудал нь, иргэд мөнгөө шилжүүлсний дараа тухайн мөнгийг авч чадахгүй, удалгүй өөр данс руу шилжүүлсэн эрсдэлээс болоод буцааж авч чадахгүй байдал үүсч байна. Тэгэхээр хэрэв тухайн дансан дахь мөнгө санамсаргүй байдлаар алдагдсан тохиолдолд шууд Цагдаагийн ерөнхий газар луу утасдаж, тэндээс Кибер цагдаагийн газар банкуудтай хамтран тухайн дансан дахь мөнгийг царцааж, цааш шилжүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллаж байна. Ер нь үүнийг сайжруулахын тулд бүх нийтийн цахим ур чадварыг үндэсний хэмжээнд зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүний асуултад Сангийн яам хариулаарай.

Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Анар : Гишүүний асуултад хариулъя. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ангилалд 6,2 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 5,6 тэрбум төгрөг гарсан байна. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал дээр нийтдээ 32,1 тэрбум төгрөг батлагдсанаас 19,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх ангилал дээр 6 тэрбум 567 сая төгрөг батлагдсанаас 5,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл 5 сарын эцсийн байдлаар гарсан байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн нэмж тодруулъя.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Энэ Малчны тухай хуулийг ярьж байгаа бид нар яагаад цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудал ярив? Яагаад малчдад төрийн үйлчилгээ очиж чадахгүй байна вэ? Төвд байгаа үйлчилгээ яагаад хөдөө айлд очиж чадахгүй байна вэ? Энэ ялгаанаас болоод яагаад малчид тэнд хохироод байна вэ?

Яагаад залуу малчин хот суурин руу яваад байна вэ? Яагаад залуу малчингүй болж байна вэ гэхээр, бидний энд боловсруулж байгаа бодлого, үйл ажиллагаа тэгш, хүртээмжтэй байж чадахгүй байгаа асуудал. Энэ үйл ажиллагаа малчдад хүрэх бүрэн боломжтой. Аймаг бүрд ХАА-н газар гэж бүхэл бүтэн газар ажиллаж байна бүтэцтэй, орон тоотой, 3-4 давхар байшинтай. Сум бүрд ХАА-н тасаг ажиллаж байна мал зүйч, малын эмч, газар тариалан, ХАА-н мэргэжилтэнтэй, үндсэндээ 5–6 орон тоо ажиллаж байна. Тэгэхээр ийм бүтэц, бүрэлдэхүүн өнөөдөр төсвөөс цалинжаад ажиллаж байхад яагаад малчдад мэдлэг, мэдээллийг хүргэж өгч чадахгүй байна вэ гэдэг асуудлыг ярьж байна.

Олон малчин цахим гэмт хэрэгт холбогдож хохирч байгаа нь үндсэндээ бидний үйл ажиллагаа хүнд хүрэхгүй байгаа явдал. Эдгээр хүмүүст “ийм залилан, ийм гэмт хэрэг яваад байна” гэдгийг сэрэмжлүүлж байх ёстой. Малчдыг хөгжүүлэх сургалт, семинарыг байнга хийж, мэдлэг, мэдээлэлтэй болгох ёстой.

Гол зорилго нь л энэ. Ингэх гэж төрөөс эдгээр хүмүүсийг цалинжуулдаг. Тэгэхээр манай ХХААХҮЯ энэ бүтэц, орон тоогоор яагаад ажлаа хийхгүй байна вэ, ямар ажил хийж байна вэ, яагаад ийм байдал давтагдаж байна вэ гэдгийг асууж байна. Ерөнхий байдлаар ярих нь утгагүй. Энэ хууль өөрөө хүнд хүрэх гэж гарсан. Энэ хууль эзэнтэй, хариуцах байгууллагатай байх ёстой. Хариуцдаг байгууллага нь танай яам.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ХХААХҮЯ хариулт өгье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. 21 аймагт Хүнс, хөдөө аж ахуйн газар, 330 суманд 3 хүний бүтэцтэй ХАА-н тасаг ажиллаж байна. Орон нутгийн боловсон хүчний асуудал нэлээд төвөгтэй байна. Бид энэ дээр тодорхой хэмжээний судалгаа хийсэн. 330 сумын ХАА-н тасагт 3 мэргэжлээр нийт 990 хүн ажиллах ёстой атал өнөөдөр 600 гаруй хүн ажиллаж байна.

Гэвч энэ 3 мэргэжлийн албан тушаал дээр шаардлага хангасан 54

мэргэжлийн хүн ажиллаж байна. Орон нутгийн боловсон хүчний хомсдол үндсэндээ 3 хүн тутмын 2 нь ажиллаж, нэг нь ажиллахгүй байгаа дүр зурагтай. Зарим суманд бол огт ХАА-н тасгийн мэргэжилтэнгүй ажиллаж байгаа нөхцөл байдлыг судалгаагаар тогтоосон.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ц.Болорчулуун дарга аа, яг наад асуудлыг чинь шийдэх гэж бид нар хөдөөдөө амьдарсан, хөдөөдөө өссөн хүүхдүүдийг тодорхой мэргэжил эзэмшүүлээд, буцаад орон нутагтаа очиж ажилла гэсэн заалтыг хуульд оруулсан. Тэгэхээр үүнийг ХХААХҮЯ-гаа хамтран улам дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлж, боловсон хүчний асуудлыг шийдэх гэж хуулинд оруулсан. Боловсролын яам аль аль нь харж байгаад энэ дээрээ ажиллаач. Бүр онцгой анхаарах хэрэгтэй. Боловсон хүчний асуудлыг хуульд заагаад өгсөн байна. Х.Баасанжаргал гишүүн.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Сонсголд оролцож байгаа малчдадаа хэлэхэд, Та бүхэн энэ боломжийг ашиглаж, салбарын яамдын тавьж байгаа илтгэлтэй холбогдуулан тодруулмаар зүйлээ аль болох сайн асуугаасай. Тэгэхгүй бол энэ боломжийг сайн ашиглаж чадахгүй байгаа мэт харагдаж байна. Үүнийг анхаараарай.

Би Сангийн яамнаас хэд хэдэн зүйл асууя. Нэгдүгээрт, сүү, ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал гээд 2026 онд ноосны урамшуулал 13,6 тэрбум, сүүний урамшуулал 12,1 тэрбум, арьс ширнийх 5,4 тэрбум, нийт 31,1 тэрбум төгрөг 2026 оны төсөвт тавигдсан байна. 2025, 2024 он гээд тасралтгүй төсөвт тавигджээ. Гэтэл нэг малчин дөнгөж сая бид нарт ноос, сүүний урамшуулал, арьс ширний урамшуулал огт олгогдохоо больсон гэж хэлж байна. Тэгэхээр энийг яг хаана, хэнд, ямар шалгуураар олгож байгаа юм бэ гэдгийг тодорхой хэлээч. Малчид аваагүй гэж байна. Үүнийг тодорхой хэлэх нь зөв.

Хоёрдугаарт, ипотекийн зээлтэй холбоотой асуулт байна. Орхон аймгийн Эрдэнэт хотод жишээ нь 991 орон сууц, хамгийн өндөр нь Дархан-Уул аймагт 617 орон сууц ипотекийн зээлээр олгогдсон байна. Энэний цаана малчид байгаа юу? Малчид биш биз дээ. Тэгэхээр орон нутагт олгож байгаа ипотекийн зээлийн ард хэдэн малчин байгаа юм, хэчнээн малчин энэ зээлийг авч байгаа юм, малчдад хэрэгтэй зээлийн үйлчилгээ мөн үү гэдэг дээр дүн шинжилгээ хийсэн үү? Учир нь малчны тухай хууль дээр арай өөр төрлийн зээл байх ёстой гэж тодорхойлсон өвөлжөө, хаваржаа сайжруулах гэх мэт. Тэр төрлийн зээлүүд гарч байна уу, үгүй юу гэдэг 2 дахь асуулт.

Гуравдугаарт, Сангийн яамны танилцуулсан слайдтай холбоотой асуулт байна. Улсын төсвөөс хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа 5 жилээс ихгүй байна гэсэн. Энэ хуулийн 16.1-тэй холбогдуулан 5 жилийн хугацаанд төлнө гэдэг бол, 2 жил энэ журам батлагдаагүй болохоор үндсэндээ гуравхан жил л үлдэж байна. Журам батлагдаагүй гээд хуулиа яах вэ? Буцаагаад хугацааг нь сунгах уу? Энэ дээр манай УИХ болон ХХААХҮЯ ямар байр суурьтай байгаа вэ гэдэг асуулт байна.

ЦХИХХЯ-аас 2–3 асуулт асууя. Та бүхэн сумдад интернэт сүлжээ сайжирсан гэж хэлж байх шиг байна. Гэтэл би өчигдөр, уржигдар Дашинчилэн суманд ажиллахад сүлжээ маш муу байсан. Бид багаараа дөрөв, тавуулаа явж байна. Сүлжээ огт ажиллахгүй, маш удаан, автоматаар 3G руу орчихдог байсан. Тэгэхээр яг ямар газар сүлжээ сайн, ямар газар муу гэж байгаа юм, тухайлбал Дашинчилэн сумын нөхцөл байдлыг тодруулаад хариултыг нь хэлээд өгөөч.

Хоёрдугаарт, малын эмчээс маш их гомдол ирж байна. ХХААХҮЯ болон ЦХИХХЯ хоёулаа энэ дээр хариулаарай.

Малын эмчид олгогдох ёстой үйлчилгээний төлбөр, хураамж олгогдохгүй байна. Сүүлдээ малын эмч нарын ашигладаг байсан аппликэйшн ажиллахаа больжээ. Яасан гэхээр төр мөнгөө өгөхгүй байна, эсвэл малын эмч нь мөнгөө өгөх ёстой гэнэ. Тэгэхээр бүхэл бүтэн малын эмч нарын ашигладаг байсан энэ бүх дата, мэдээлэл хувийн компанийн эзэмшилд байсан гэсэн үг үү? Энэ ямар учиртай юм бэ? Үүнийг тодорхой тайлбарлаач.

Малын эмч нарын орлого, үйлчилгээтэй холбогдуулан энэ 2 яамны хооронд ямар нөхцөл байдал үүсээд дандаа гомдол, санал тасардаггүй юм бэ? Оны өмнө бол бүр жагсаал дээрээ тулж байсан. Малын эмч нарын асуудал энд яг ямар байна вэ гэдгийг тодорхой хэлээч. Хамгийн сүүлд ЦХИХХЯ-аас асууя. Малчдын цахим бичиг үсэг тайлагдалтын асуудал дээр ямар бодлого барьж байгаа вэ? Маш олон цахим үйлчилгээ гаргаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эхлээд Сангийн яам, ЦХИХХЯ, ХХААХҮЯ хариулна уу.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Урамшууллыг хэрхэн тооцдог вэ гэдэг асуултын хувьд, төсөвт сууж байгаа урамшууллын тоо хэмжээ нь төсөв тооцох, төлөвлөх үед ХХААХҮЯ ийм хэмжээний урамшуулал олгох шаардлагатай гэсэн тоо ирдэг. Тухайн жилийнхээ төсвийн боломжоос хамаараад, төсвийн хязгаартаа багтаан төсөвт тусгадаг.

Бидэнд байгаа мэдээллээр ХХААХҮЯ нь өөрөө урамшууллын цахим системтэй. Тэр системээрээ бүртгэж, хянасны дараа санхүүжилтийг нь манайх бөөн дүнгээр салбарын яам руу олгодог. Тэндээс салбарын яам өөрийн бүртгэлжүүлсэн цахим системээрээ хянаж тухайн санхүүжилтийг олгодог. Тэгэхээр яг дэлгэрэнгүйг нь ХХААХҮЯ нэмж хариулсан нь дээр байх.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тухайд түрүүн ГБХНХЯ-аас танилцуулсан. Хэрэв энэ хуулийг хэрэгжүүлээд явах юм бол 2027 онд 6,8 мянган малчны тэтгэвэрт 42,8 тэрбум төгрөг, 2028 онд 9,2 мянган малчны тэтгэвэрт 68.2 тэрбум төгрөг, 2029 онд 11 мянган малчны тэтгэвэрт 98.6 тэрбум төгрөг, 2030 онд 14,8 мянган малчны тэтгэвэрт 136 тэрбум төгрөг буюу эхний 5 жилийн хугацаанд малчны тэтгэврийн зардалд 375,5 тэрбум төгрөг зардлын талд тавигдахаар байна. Зардлын талд гэдэг нь юу гэсэн үг вэ гэвэл, одоогоор нийгмийн даатгалын сан өөрөө алдагдалтай, улсын төсвөөс татаастай. Тэр татаас нь 1,4 их наяд орчим төгрөг байгаа. Нийгмийн даатгал төлж байгаа иргэдээс цуглуулж байгаа орлого нь хүрэхгүй учраас нэмж улсын төсвөөс 1,4 их наядын татаасыг, жишээ нь 2025 оны хувьд нийгмийн даатгалын сан руу өгч, түүгээрээ тэтгэвэр, тэтгэмжээ олгосон.

Орлогын талд бол, энэ хууль хэрэгжээд явах юм бол тэтгэврийн даатгалын шимтгэлийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 5 хүртэл жилээр тооцож нөхөн төлүүлэхэд, 38,2 мянган малчин хамрагдаж, тэтгэврийн даатгалын санд 194,4 тэрбум төгрөг төвлөрөх тооцоололтой байна. Энэ бол ГБХНХЯ-аас ирүүлсэн тооцоо. Тэгэхээр энэ 2-ын зөрүүг бодвол ойролцоогоор 170 орчим тэрбум төгрөгийн татаасыг жил болгон улсын төсвөөс нэмж олгоно гэсэн үг. Нийгмийн даатгалын сангийн тогтолцоо бол

өөрөө төлсөн шимтгэлээрээ, ажил хийж байгаа хүн төлсөн орлогоороо буцаагаад шимтгэлийнхээ үр шимийг авдаг тогтолцоо. Тэгэхээр төлөөгүй байж байснаа шууд улсын төсвөөс даагаад төлөөд явна гэвэл улсын төсөвт авч байгаа ачаалал жил ирэх тусам улам томрох болно.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран: Монгол Улсын хэмжээнд үүрэн холбооны үйлчилгээний хувьд сум болгон дээр ядаж нэг 4G оператор байх бодлогыг бид барьж, төлөвлөж байна. Учир нь энэ маш их хөрөнгө оруулалт болохоор давхардсан хөрөнгө оруулалт гэдэг үүднээс ингэж явсан.

Хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр давхардсан байдлаар операторууд орж байгаа. Булган аймгийн Дашинчилэн сумын хувьд нийт 4 багтай юм байна. Багийн мэдээллээр харахад 1 дүгээр багт зөвхөн Юнителийн 4G, 2 дугаар багт Мобиком, Юнител, Скайтел, Жимобайл дөрвүүлээ орж 4G үйлчилгээ үзүүлдэг, 4 дүгээр баг буюу төвд нь Юнител, Скайтел, Жимобайл байдаг юм байна. Магадгүй та Мобикомтой байсан байж болзошгүй. Тэгэхээр тэр асуудлыг тодруулж шалгая. Бидний хувьд хамгийн түрүүнд дата, дараа нь хэрэглэгчийг заавал ярих үндсэн шаардлага, хэрэгцээ хангахаар төлөвлөсөн. Зарим сумын хувьд эхлээд 3G орчихоод, дараа нь хөрөнгө оруулалт хийх замаар 4G болдог тохиолдол байдаг.

Тэрэнтэй холбогдуулан 3G орчихсон газар техник, технологийн шинэчлэл хийгээгүй байх боломжтой тул түүнийг тодруулъя. Хоёр дахь асуудлын хувьд, мэдээлэл хариуцагч байгууллага нь ХХААХҮЯ-ны Мал эмнэлгийн газар юм шиг байна. Манайх дээр ямар нэгэн мэдээлэл байхгүй. Тэгэхээр ХХААХҮЯ малчны аппликэйшнтэй холбоотой мэдээллийг өгөх байх. Малчны цахим бичиг үсэгтэй холбоотой асуудал бол хамгийн чухал асуудал болж байна.

Бид өнгөрсөн хугацаанд малчин гэлтгүй бүх нийтийн цахим ур чадварыг сайжруулах чиглэлээр маш олон сургалт хийсэн. Гэвч үүнийг хэрэгжүүлэхэд орон нутгийн томилолтыг төсвөөс хязгаарлачихдаг зэрэг асуудал тулгардаг. Тэрнээс үүдээд хүртээмжтэй явуулахад хүндрэлтэй. Учир нь цахимаар үйлчилгээ хэрхэн авах вэ гэдгийг цахимаар заана гэдэг өөрөө хүртээмж муу байгаа асуудал. Энэ жилийн хувьд бид цахимаар нэн тэргүүнд буюу дижитал фёрст аяныг 6 сегментэд өндөр настан, малчин, төрийн албан хаагч, 10-н жилийн хүүхдүүд болон багш, сурган хүмүүжүүлэгч гэсэн чиглэлээр сургалт оруулж эхлээд явж байна. Баярлалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл: Мал эмнэлэгийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Алтангэрэл байна. Х.Баасанжаргал гишүүний асуултад хариульъя. Мал эмнэлгийн нэгдсэн систем нь Швейцарын хөгжлийн агентлагийн төсөл хэрэгжих үеэс анх нэвтэрсэн. Үүний зохиогчийн эрх нь “Дижитал Медик” компани дээр явдаг бөгөөд өмчлөгч нь Мал эмнэлгийн ерөнхий газар юм. Энэ программын үйл ажиллагаа явуулах хугацаанд өмнөх удирдлагууд тодорхой компаниудыг нь сольж, тасалдал үүсгэх асуудал гарч байсан. Үүнийг өнгөрсөн 7 хоногоос тухайн “Дижитал Медик” компанитай гэрээ хийж, тогтвортой явах боломжийг бүрдүүлж байна.

Хоёрдугаарт, үйлчилгээний хөлсний хувьд мал эмнэлэг 2025 онд нийтдээ 17,3 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан. Үүний 7,2 тэрбум төгрөг нь тарилгын үйлчилгээний хөлс байгаа. 2026 оны хувьд олгох үйлчилгээний хөлсний 70 хувийг олгочихсон байгаа. Үлдсэн 30 хувийг тарилга дуусгаж, холбогдох баримт бичгийг

хянасны дараа олгоно. Гол асуудал нь 2025 оны 7,2 тэрбум төгрөгийг цаашид төсвийн тодотголоор шийдвэрлэх тул яаманд хүсэлт өгөөд байна.Баярлалаа.

УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал: Би яагаад малын эмч нарын хэрэглэдэг аппликэйшнийг ЦХИХХЯ-аас асуусан бэ гэвэл, бид маш олон үйлчилгээгээ цахим болгож байна гээд хувийн компаниудтай гэрээ контракт хийж, мэдээллээ өгч, бүх иргэдийн эмзэг, чухал мэдээлэл нэг компанийн дата болж хувирч байна. Тэгэхээр энэ дээр ЦХИХХЯ ямар хяналт тавьж, ямар бодлого барьж байна вэ? Тэр компани мөнгөө аваагүйн төлөө аппликэйшнээ хааж чадаж байна. Энэ чинь өөрөө аймаар том эрсдэл. Үүнийг цаашид яаж харах вэ гэдгээ бид хармаар байна. Энэ зөвхөн малын эмч нар дээр гарч байгаа жишээ боловч олон төрийн үйлчилгээнд, тэр дундаа эрүүл мэндийн үйлчилгээнд ч хамаатай. Тэгэхээр энэний аюулгүй байдлыг энэ 2 яам хоорондоо яаж зохицуулдаг юм бэ гэдэг асуулт байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ЦХИХХЯ хариулт өгье.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран: ЦХИХХЯ-аас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу шинээр хөгжүүлж байгаа мэдээллийн системүүд дээр үнэлэлт, дүгнэлт, хяналт хийж байна. Яг саяын яриад байгаа систем дээр нэлээд хяналт хийгдсэн юм шиг байна. Сүүлд манайд хандаж, E-Mongolia академитай хамтран системийн үнэлгээ хийсэн. Мал аж ахуй болон үүнтэй холбоотой мэдээллийн сан үндэсний аюулгүй байдлын асуудал болсон гэдэг үүднээс манайхаас хамтарсан үзлэг, үнэлгээ хийж, дүгнэлтээ өгсөн байгаа. Тэгэхээр сайжруулах асуудлууд яригдаж байгаа. Өмнөх компанийн хувьд гэрээгээр тогтоосон гэрээний асуудал байгаа юм шиг байна. Бид зүгээр дүгнэлтээ өгчихсөн байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Лувсанбямбын Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя. Нийгмийн даатгалын асуудал маргааш орж ирнэ.

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан: Малчны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гэж байна. Эндээс огт хэрэгжээгүй нь энэ хуулийн 13, 14 дүгээр зүйл болон 9 дүгээр зүйлийн хэрэгжээгүй хэсгүүд байна. Энэ дээр хамгийн чухал заалт болох малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах нь ерөөсөө хэрэгжээгүй. Дээрээс нь 14 дүгээр зүйл бол санхүүжилт Малчны сан байгуулах нь ямар эх үүсвэрээс бүрдэх вэ гэдэг асуудал. Түрүүн Сангийн яамнаас тэр журам батлагдаагүй гээд баахан тайлбар хийсэн. Тэгэхээр та нар хууль тайлбарлах эрхгүй. Шалтгаан тайлбарлах биш, нэгэнт цаасан дээр гарчихсан хуулийг та нар биелүүлэх ёстой.

Энэ хуулийн 15 дугаар зүйлд хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага гэж байгаа 15.1, 15.2. Тэгэхээр энэ хариуцлагыг, дарга аа, энэ төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нартай тооцох юм уу, үгүй биз дээ. Сайдүүдыг авчирмаар байна. Маргаашийн энэ сонсгол дээр тэгж байж малчдынхаа эрх ашгийг хамгаалж, төрийн эрх барих дээд байгууллагын баталсан хуулийн хэрэгжилтийг ярина. Тэгэхгүй бол энэ төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар хууль тайлбарлаад байна.

Хууль тайлбарлах эрх та нарт байхгүй, шууд хэрэгжүүлэх ёстой, даган мөрдөх ёстой. Энэ дээр УИХ онцгой бүрэн эрхээрээ хяналт тавих ёстой. Өнөөдөр

энийг сонсох гэж байгаа шүү дээ. Тэгэхэд энд хариуцлага хүлээх нэг ч сайд байхгүй байна. Хөдөө орон нутгаас хол газраас ирсэн малчид сууж байна. Энэ хуулийн бас нэг ноцтой хэрэгждэггүй заалт нь 7 ба 7.3. Малчид өнөөдөр өвөлжөө, хаваржааны газар нь лицензийн талбайд өртчихөөд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн. Хаана очихоо мэдэхгүй, очих газаргүй болсон. Манай тойрогт ийм байгаа, манай тойргоос энд хүмүүс сууж байна. Тэгэхээр энэ бүх хэрэгжилтийг тооцох сайд нарыг маргаашийн сонсгол дээр дуудаж ирүүлээд, энэ хуулийн зүйл, заалтуудад хариуцлага тооцох талаар ярьж болохгүй юу? Би тийм санал оруулж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Маргаашийн сонсгол дээр ер нь бүх сайд нарыг дуудсан байгаа. Өнөөдрийн энэ сонсголыг ард нийт бүгдээрээ шууд нэвтрүүлгээр харж байна. Төрийн байгууллагуудаас гишүүд ямар асуулт асууж байна, төрийн байгууллагуудыг хэн нь төлөөлж байна, сайд нь ирэхгүй байгааг ард иргэд харж байна.

Төлөөлж байгаа ТНБД нар хэрхэн хариулж байгааг харж байна. Гэрч болон оролцогчид хүрч ирээд харж байна. Бид энийг л хүсэж байгаа. Хэнтэй хариуцлага тооцох вэ гэвэл, УИХ-ын ганц онцгой бүрэн эрх бол Засгийн газартай хариуцлага тооцох асуудал. Тэгэхээр саналыг авч байна. Маргааш бүх сайд нарыг байлгана. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд маргааш ирнэ. Ц.Болорчулуун дарга ганцаараа гүйж яваа хэрэг биш, бүх сайд нарыг маргааш дуудаж байлцуулна. Санал хэллээ. М.Мандхай гишүүн асуултаа асууя.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Засгийн газрын танилцуулга дээр маргааш нийгмийн даатгалын асуудлыг ярих юм байна. Үндсэндээ малчид нийт нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн хөтөлбөрт хамрагдаж байгаа нь 20 хувь л байна гэж харагдаж байна. Тэгэхээр яг бодитоор яагаад 20 хувьд хамрагдаад байгаа юм бэ?

Малчид нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадахгүй байгаагийн цаад шалтгаан нь юу вэ? Тэгвэл энийг улс бид яаж хангах вэ? Энэ чинь хүнсний аюулгүй байдал. Сум, орон нутгийг хамгаалж, иргэд, хэрэглэгчдийг махаар тасралтгүй хангах ийм ач холбогдолтой. Эдийн засгийг хамгаалж байгаа энэ бүлэг дөнгөж хорьхон хувийн хэрэгжилттэй, нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадахааргүй түвшинд байна гэж үү гэдэг дээр би маргааш хариулт авмаар байна.

Хоёрдугаарт, нэн чухал асуудал байна. Малын дархлаажуулалт гээд бүх дархлаажуулалтын төсөв жил ирэх тусам унаж байна. Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн төсөв өнгөрсөн жил 4,9-өөс 1,2 болж буурсан байна. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6,3, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төсөв дахиад л өнгөрсөн жилээсээ буураад эхэлсэн байна. Энэ бол яг хамгийн чухал төсөв. Малыг эрүүл байлгаж, өөрсдөө эрүүл малаа идэх гэж бид зорьдог байтал малынхаа халдваргүйжүүлэлтийн төсвүүдийг ингэж бууруулаад өгдөг нь яг ямар учир шалтгаантай юм бэ? Үнэнийг хэлэхэд, мал эмнэлгийн чиглэлээр сурч байгаа оюутнуудыг хуулийн тэтгэлэгт хамруулна гэсэн нэг балай заалт яриад байх юм.

Энэ хамгийн хэрэггүй зүйл. Үндсэндээ Монгол Улсаар дүүрэн ажилгүй малын эмч нар байна. Малын эмч нар нь өөрөө малын өвчнийг мөнгө гэж харчихсан. Албаар тариад, улам дархлааг нь унагааж байна. Өнөөдөр малчид хэлж байна шүү дээ ямар ч малаа хаана тарихаа мэдэхгүй, малын эмч гэсэн нэртэй хүн очоод харчихдаг, малынхаа хөлийг хавдаачихдаг, би малаа зарж чадахгүй гэж. Ийм нөхцөл байдалд малчид бухимдалтай яриад байхад, оюутнуудыг хуулийн тэтгэлэгт

хамруулна гээд ямар ч нэг бодлогогүй ажиллаад байх юм. Тэгээд энэ төсвийн санхүүжилт яагаад ер нь буурч байгаа юм? Энэ буурсантай холбогдуулан ямар эрсдэл үүсээд байгаа юм бэ гэдэг асуудалд хариулт авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам М.Мандхай гишүүний асуултад хариулъя.17

Сангийн яамны Төрийн нөрийн бичгийн дарга Б.Анар: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Малын дархлаажуулалттай холбоотой зардлууд яагаад буурсан бэ? гэж асууж байна. Ер нь 2024, 2025 онд буурсан. Гэхдээ та сүүлийн жилүүдэд төсөв батлагдаж байсан процессыг санаж байгаа бол, бид салбарын яамнаас ирсэн санал, ялангуяа малын дархлаажуулалттай холбоотой зардлууд дээр бараг өөрчлөлт оруулахгүйгээр тэр саналаар нь УИХ-д өргөн барьдаг. УИХ-ын холбогдох байнгын хороод дээр зарим зардлын ангиллыг өөрчлөх, зориулалтыг өөрчлөх саналууд гардаг.

Тэр өөрчлөлтийн дагуу өргөн барьсан төсвүүд дээр зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ангиллаас бууруулах, зарим дээр нэмэгдүүлэх зохицуулалтын арга хэмжээ авагддаг. Үүний нэг нь малын дархлаажуулалттай холбоотой зардлаас хувьчлаад бууруулсан. Сүүлд 2025 оны төсөв, 2026 оны төсөв дээр төрийн албан хаагчдын цалин, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотой санал дэмжигдэхэд, түүнтэй зөрүүлж төсвийн бусад ерөнхийлөн захирагч нараас тодорхой хэмжээний зардлын хэмнэлт гаргах шаардлага үүссэн. Энэ хүрээнд бидний ойлгож байгаагаар Төсвийн байнгын хороон дээр холбогдох байнгын хороодтой зөвшилцсөний үндсэн дээр эдгээр зардлыг хэмнэлтийн зорилгоор зарим хэмжээгээр бууруулсан тохиолдол гарсан. Энэ дотор уг ангилал хамаарч байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл: Мал эмнэлэгийн ерөнхий газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Х.Алтангэрэл. М.Мандхай гишүүний асуултад хариулъя.

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 971 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 1,424 мал эмч ажиллаж байна. Үүнээс их эмч 858, бага эмч 364, техникийн ажилтан 202 буюу нийтдээ 1,424 хүн ажиллаж байна. Стандартаар нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 40 мянган мал ногдох ёстой. Жил ирэх тусам нэг нэгжид ногдох малын тоо өсөж байна. Хоёрдугаарт, төсвийн хувьд 2025 онд 57,9 тэрбум төгрөг байсан бол 2026 оны төсөв 50,1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ хүрээнд бид дархлаажуулалт, оношилгоо, шинжилгээ, ариутгал, халдвар бүртгэлийн ажлаа зохион байгуулж хэрэгжүүлж байгаа. Хүндрэлтэй асуудал бол өнгөрсөн 2025 онд 17.3 тэрбум төгрөгийн өглөг гарсан. 2026 оны намрын шүлхийн дархлаажуулалтаас урьдчилж аваад өр төлбөрөө барагдуулах чиглэлээр эхний хагас жилийн байдлаар арга хэмжээ авч байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Мандхай гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Ингээд зүгээр хэдэн тоо яриад, иргэд, малчид ирчихсэн байхад тэр хүмүүсийн толгойг эргүүлэх гэж байгаа юм шиг хариулт сонсмооргүй байна. Энэ төсөв дээр Сангийн яам үнэнийг хэлэхэд малын эрүүл,

эрүүл ахуйн асуудлыг мэдэх ч үгүй. Гэхдээ өвчтэй малыг, махыг нь идээд сууж байгаагаа ч мэдэхгүй сууж байна. Бид өнөөдөр юу чухал гэдгээ ерөөсөө ялгаж салгаж чадахгүй байна. Гол хариуцаж байгаа хүмүүс нь төсөв буурснаар шүлхий нэмэгдчихсэн байна. Малын эрүүл мэндийн асуудал, түүний 90 хувь нь яг бодитоор малчдад ямар хүндрэл учруулж байгаа юм бэ? Энэ дээр нэг дорвитой, бодитой, хөрсөн дээр буусан хариулт хүсье.

Хоёрдугаарт, би түрүүн нэг асуултаа асуугаагүй үлдчихлээ. Ер нь хүнсний хувьсгал гэдэг дээр газрын дарга ийм хариулт өгөхөө болимоор байна. Гишүүдийн хувьд таны танилцуулж байгаа хариултыг сонсож байгаа гишүүдийг асуудлыг мэдэхгүй хүмүүс гэж бүү бодоорой. 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо 100 хувь үйлдвэрлэх гэсэн, 3 жил үргэлжилсэн, 1,2 их наяд төгрөг аль хэдийн гарчихсан төсөл дээр өнөөдөр зөвхөн үйлдвэрүүдэд өгсөн гээд сууж байна. Би үр дүн асууж байгаа. Малчин, тариаланч, ногоочдод энэ ямар шууд нөлөө үзүүлсэн юм бэ? Бүтээгдэхүүнээ баталгаатай борлуулах, түүхий эдээ борлуулах гэрээ нэмэгдэх ёстой. Түүхий эдийн улирлын үнэ өсөж байгаа байдал тогтворжих ёстой. Агуулах, хөргөлт нэмэгдэх ёстой. Цагаан алт хөтөлбөр дээр ноос, арьс шир нь жалга дагуулж хаягдаж байна. Арьс шир, ноосноос эргэлтэд орох ёстой. Өнөөдөр хүртэл малчид та нар яваад өөрсдөө үз. Одоо хүртэл жалга дагуулж хаяж байна шүү дээ. Хаана эргэлтэд ороод байгаа юм бэ? Цагаан алт хөтөлбөр явснаараа ийм бодит үр дүн гарсан, боловсруулах үйлдвэрт зээл олгосон гээд сууж хариулахаасаа ичих хэрэгтэй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Тайлбарыг ХХААХҮЯ хариулна уу.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Хөтөлбөрүүд өөр өөрсдийн гэсэн зорилготой байгаа. Хүнсний хувьсгалт хөдөлгөөний хүрээнд боловсруулах үйлдвэрүүдэд зээл олгож аваад, нийтдээ шинээр 53 үйлдвэр ашиглалтад орж, 1000 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нэмэгдсэн ийм үр дүн гарсан.

Таны асууж байгаа төмс, хүнсний ногоо, махны хадгалалтын зоорины хэмжээ энэ зээлийн үр дүнд 55 мянган тонноор нэмэгдсэн. Газар тариалангийн тариаланчид өөрсдөө жил болгон тариалалтаа хийх техник, тоног төхөөрөмжийн нөөцтэй болж, технологийн хугацаандаа хурааж авах техник, тоног төхөөрөмжийн бааз суурьтай болсон гээд хөтөлбөрийн үр дүнгүүд гарч байгаа. Тэртээ тэргүй энэ хөтөлбөр 2026 онд дуусч байгаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тайлан гаргаж, үр дүнг нь дүгнэнэ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: 3 минут болсон. Гүйцээж хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун: Цагаан алт хөтөлбөр бол малчдад зээл олгох хөтөлбөр биш. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ гэсэн зорилттой. Энэ зорилтынхоо хүрээнд л ажиллаж байгаа. Өнгөрсөн жил дотоодын үндэсний үйлдвэрүүд анх удаа түүхий ноолуурынхаа 60 орчим хувийг өөрсдөө худалдаж авсан.

Урьд нь гаднын хөрөнгө оруулалттай компаниуд худалдаж авдаг байсан. Эндээс ахиц дэвшил гарч, үндэсний үйлдвэр сэргэж байна. Зөвхөн ноолуур дээр

авч үзэхэд, угааж гаргадаг байсан бол одоо самнаж, ээрч, утас ээрч, эцсийн бүтээгдэхүүн болгож гаргах боломж нөхцөл бүрдэж байна. Ингээд хөтөлбөрүүд тодорхой хэмжээнд тавьсан зорилтынхоо хүрээнд үр дүнгээ өгөөд явж байгааг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Мандхай гишүүн, маргааш Ц.Идэрбат сайд өөрөө илтгэл тавина, тэрэн дээгүүр тодруулаад явъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дараагийнхаа илтгэл рүү оръё. Малчны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, эрүүл мэндийн даатгалын хүрээнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр танилцуулга хийнэ. Н.Эрдэнэбаярыг урьж байна.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр: Эрхэм хүндэт УИХ-ын гишүүд, энд хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид, Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Малчны тухай хуулийн биелэлтийн хүрээнд малчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар та бүхэнд танилцуулга бэлдсэн. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нийт малчдын тоо 300 мянгаас дээш давж, жил бүр нэмэгдэж байгаа тоон үзүүлэлт байна. Малчдын нүүдэллэн амьдрах онцлог, алслагдсан бүс нутагт оршдог зэрэг нөхцөл байдал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хангахад тодорхой хэмжээний сорилт учруулдаг.

Хуулийн биелэлтийг дэмжих үүднээс Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон орон нутгийн захиргаа нягт хамтран ажилладаг. Жил бүр Засаг дарга нартай Эрүүл мэндийн яамны сайд гэрээ байгуулж, гэрээнд тодорхой заалтуудыг тусгаж ажилладаг. Бодлого, эрх зүйн орчны хувьд хэд хэдэн асуудал байна. Эрүүл мэндийн салбар 2020 оноос эхлэн гүйцэтгэлийн санхүүжилтэд орсон.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т Монгол Улсын иргэн санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна гэж заасан. Даатгалын тухай хуулийн 6.1.3-т малчин нь Эрүүл мэндийн даатгал (цаашид “ЭМД” гэх)-ын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэний ангилалд хамаарна гэж заасан. Засгийн газрын 2025 оны 2 дугаар тогтоолоор малчны сарын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиас доошгүйгээр шинэчлэн тогтоосон буюу сард ойролцоогоор 15,840 төгрөг болж байгаа.

Хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд орон нутгийн Засаг даргын төлөвлөгөө байдаг. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх жилийн төлөвлөгөөг жил бүр баталж, тайланг гаргадаг. Энэ хамтын ажиллагааны гэрээг жил болгон дүгнэж, зорилтуудыг тусгаж, хэрэгжилтийг үнэлж ажилладаг. Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт орон нутгийн түвшинд харилцан адилгүй байна. Даатгалын төлөвлөгөөг ерөнхийд нь дүгнэж үзэхэд, даатгалын хамрагдалтын хувь 40 хувьд хүрэхгүй байгаа үзүүлэлттэй байна. Хамрагдалтын хувь хэмжээг 2024, 2025 он, мөн 2026 оны эхний 5 сарын байдлаар харуулсан.

Гүйцэтгэлийн тоог авч үзвэл, 2024 онд 51,187 малчин даатгалд хамрагдсан бол 2025 онд буурч 37,387 болсон. 2026 оны эхний 5 сарын байдлаар 8,790 малчин хамрагдсан байна. Энэ хүснэгтэд ЭМД-ыг дэлгэрэнгүй байдлаар гаргасан. Малчдын тоо жил бүр нэмэгдэж, 2026 онд Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр 313,195 малчин байгаа. Гэтэл жилийн хамруулах төлөвлөгөө арай бага тоо харагдаж байгаа нь дараах учиртай.

Нэгдүгээрт, малчдын тоо бүртгэлд тэтгэврээ тогтоолгосон малчид багтсан байгаа бөгөөд тэдний даатгалын асуудлыг улсаас хариуцдаг тул энэ тоо нэлээн эрс зөрөөтэй харагддаг. Нөгөө талаас төрөөс даадаг хүүхэд, насанд хүрээгүй иргэд, жирэмсэн болон амаржсан ээжүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг бүлгийг хасахаар энэ тоо үндсэндээ 2 дахин бага үзүүлэлттэй харагддаг. Шимтгэлийн мөнгөн дүн ерөнхийдөө 1 жилд дунджаар 8,2-8,4 тэрбум төгрөг хуримтлагддаг. Энэ онд нэлээн их буурч, 1,7 тэрбум төгрөгийн шимтгэл төлөгдсөн буюу нийт төлөлтийн 10.3 хувь гэсэн маш бага үзүүлэлттэй байна.

Гэхдээ энэ нь жилийн эцсийн дүн биш. Хавар цаг өөрөө малчдын хувьд мал төллөдөг, ажил ачаалал ихтэй үе тул хамрагдалт сул байгаатай холбоотой. Нөгөө талаас орон нутагт төв болон багаасаа алслагдсан байдал нь төлөвлөлтөд нөлөөлдөг гэсэн дүгнэлт хийж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан малчдын тохиолдлын тоог төрөл бүрээр нь, 2024, 2025, 2026 он гээд сүүлийн 3 жилээр харьцуулан гаргасан. Ерөнхийдөө зарчмын том зөрүү харагдахгүй байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж байгаа малчдыг аваад үзэхээр 2024 онд 123,667 тохиолдлууд байна. Тохиолдол гэдэг маань 1 малчин 2-3 давхар үзүүлсэн тоо байгаа.

Оношилгоо, шинжилгээ, диализын тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх эмчилгээ гээд авч үзвэл, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ нэлээн өндөр хувьтай байна. Энэ тохиолдлын тоо нийт үзүүлж байгаа хүмүүсийн 42.5 хувь нь 2024 онд хэвтүүлэн эмчлэх үйлчилгээнд хамрагдсан бол 2025 онд 48.9 хувь болж нэмэгдсэн. Эсрэгээрээ даатгалын төлөлт нь 2024 оноос 2025 онд буурсан үзүүлэлттэй байна. Гэхдээ авч байгаа тусламж үйлчилгээний хувьд 2026 оны эхний 5 сарын байдлаар хэвтүүлэн эмчлэх дээр 47.7 хувьтай буюу нэлээн нэмэгдэх төлөвтэй байна. Тохиолдол гэдэг нь нэг малчин 2-3 удаа үзүүлдэг давхацсан тоо байгааг дашрамд хэлье. Даатгалаас авч байгаа эмийн хөнгөлөлт нийт зардлын хэдэн хувь байна вэ гэдгийг авч үзвэл, дунджаар жилээс жилд нэмэгдэж байгаа буюу 5 хувь, 6.5 хувь, 7.5 хувь болж байна.

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ дунджаар 20 орчим хувьтай байдаг бол 2025 онд жоохон буурч 16.5 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх эрт үзлэг, эрт илрүүлгийн асуудал нь малчны тухай хуульд эрүүл мэндийн салбарт тухайлан зааж өгсөн заалт байдаг. Үүнийг авч үзэхэд 2024 онд 6.2 хувьтай, 2025 онд 3.8 хувьтай, 2026 онд 0 хувьтай байна. Үүний учрыг хэлэх ёстой. ЭМД-ын Үндэсний зөвлөлийн шийдвэрээр 3 жилийн хугацаатай гэрээнүүд байгуулагддаг бөгөөд 2025 оны 10 сараас эрт илрүүлгийн ажлууд үндсэндээ зогссон.

Сая шинэчилсэн ЭМДҮЗ-ийн тогтоол батлагдаж, эрт илрүүлгийн журмыг шинэчлэх ажил хийгдэж байгаа. Хязгаарлагдмал нөөцийн хүрээнд хамгийн оновчтой байдлаар явуулах зорилтот бүлгүүдийн чиглэлээ журамдаа нарийвчлан тусгаж, малчдын онцлогийг харгалзан тооцож байна. Амбулаторийн үзлэг болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээ дотроо ямар ялгаатай байгааг гаргаж үзсэн. Хэвтүүлэн эмчилж байгаа дээр мэс заслын тусламж үйлчилгээ буюу яаралтай үеийн тусламжийн нэг тохиолдлын дундаж өртөг нэлээн өндөр байна. Энэ нь оношны бүлгээрээ өндөр өртөгтэй эмчилгээнүүд явж байгаатай холбоотой. Малчдын дунд өвчлөлийн байдлыг авч үзэхэд зүрх судасны өвчин өндөр байна.

Энэ нь нийт монгол хүмүүсийн дунд ч өндөр байдаг бөгөөд малчдын дунд адил үзүүлэлттэй байна. Хавдрын өвчлөл бас өндөр байна. Тулгуур эрхтний

тогтолцооны өвчин ч нэлээд харагдаж байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, ЭМД-ын хамрагдалтыг насны бүлгээр нь авч үзсэн. Төрөөс дааж байгаа хүүхдүүд болон ахмад настан энэ дээр ороогүй. Ер нь 18-30 нас, 31-45 нас, 46-60 нас, 61-ээс дээш нас гэж ангилсан. Тухайн малчид өөрсдөө тэтгэврээ тогтоолгоогүй хүмүүс учраас энд хамрагдсан байгаа. Насны бүлгээр авч үзвэл, 2024 онд 31-45 насныхан бусад наснаасаа арай илүү хамрагдсан бол 2025 онд төдийлөн ялгаа харагдахгүй байна.

Өөрөөр хэлбэл 31-60 насны хооронд үндсэндээ ойролцоо хувьтайгаар эрт илрүүлэг үзлэг, даатгалын хамрагдалт явсан үзүүлэлттэй байна. Эрт илрүүлгийн талаар нэмэлт мэдээлэл өгье. Малчдын наслалттай холбогдуулан эрүүл мэндийн салбар нэлээн онцгой анхаарч ажилладаг. Энэ дээр явуулын хэлбэрээр эрт илрүүлэг, үзлэг, оношилгоог хийж байгаа. Сүүлийн үед оруулж ирсэн мобайл технологи буюу овор багатай төхөөрөмжийг авч явж, дата мэдээллээ хийгээд, эхо болон цусны ерөнхий шинжилгээ зэргийг тухайн газартаа очиж хийх боломжийг бүрдүүлсэн нь техникийн хувьд нэлээн дэвшилт тал болсон.

Энэ мэдээллүүдээ нэгтгэж, дата бааз үүсгэн, анализ хийж, цаашдын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгийн чиг хандлагаа тодорхойлж байна. Явуулын эмнэлгийн хамрагдалтын 2024 оны тоогоор нийт 18,707 хүн хамрагдсан байна. Гэхдээ энэ нь цэвэр 100 хувь малчид биш, сум дээр сууж байгаа хүмүүс ч багтсан давхацсан тоо. 21 аймгийн нийт 114 суманд очсон байна. Энэ бол хангалтгүй үзүүлэлт 330 сумаас явуулын эмнэлгээр гуравны нэг орчим дүйцэхүйц суманд хүрч ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 71 дүгээр тушаалаар урьдчилан сэргийлэх үзлэг хийх тусгай зориулалтын автомашин ашиглах түр журам баталж, түүнийгээ мөрдөж ажиллаж байна. Цаашид хэд хэдэн зүйл дээр анхаарах юм байна. Энэ танхимд орон нутгаас төлөөлж ирсэн малчид болон улсын хэмжээнд бүх хүмүүс үзэж байна. Малчдын хувьд эрүүл мэндээ хамгаалуулах нь хамгийн чухал.

Гэхдээ төрийн бодлого, хууль тогтоомжийн хүрээнд даатгалын хамрагдалтаа нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Яагаад гэвэл эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтэд орсон бөгөөд гүйцэтгэлийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь олон улсаас зөвлөдөг хэмжээнээс дор байгаа учраас урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн зардал өндөр гардаг. Тийм учраас хамтын төлбөрийн хүрээнд малчид өөрсдөө ЭМД-аа төлж, эрүүл мэндээ хамгаалах чиглэлд анхаарч хамтран ажиллавал цаашид энэ боломжууд нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, 40 хувьд хүрэхгүй байгаа хамрагдалтыг ядаж энэ ондоо 50 хувиас дээш гаргаж, жил болгон нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Хоёрдугаарт, явуулын болон теле-медицины үйлчилгээ байна. Алслагдсан, нүүдлийн нөхцөлд амьдарч байгаа малчдад тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд явуулаар очиж үйлчлэхгүй бол малчид сумын төв, багаасаа алслагдсан газраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг. Тийм учраас энэ дээр тоног төхөөрөмж, машин тэрэгнээс эхлээд хүний нөөцийг бэхжүүлэх ажил байна. Дараагийн зүйл бол урьдчилан сэргийлэх үзлэгийн зохион байгуулалтыг нүүдлийн болон цаг уурын онцлогтой уялдуулж шинэчилж ажиллаж байгаа. Мөн ахмад настнуудыг ахмадын хүрээнд давхар тооцож явдаг. Миний сүүлийн слайдад сүүлийн 2 жил болон энэ оны эхний 5 сарын байдлаар харьцуулж харуулсан. Тухайн слайд бүрд зарим дүгнэлтийг хийсэн бөгөөд цаг дуусаж байгаа тул дэлгэрэнгүй танилцуулахгүйгээр энд орхиё. Анхаарал хандуулсанд баярлалаа. Асуултад хариулахад бэлэн байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Хөтөлбөрийнхөө дараагийн танилцуулгыг сонсьё. Бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулж хэрэгжүүлэх хүрээний зарим асуудлаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай танилцуулга хийнэ. А.Энхманлайг индэрт урьж байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулж хэрэгжүүлж байгаа хүрээний зарим асуудлаар Та бүхэнд товч мэдээлэл хүргэе. Монгол Улсын газар нутаг нийт 156 сая 400 мянган га талбайтай. Үүнээс 85.7 хувь буюу 134,1 сая га талбай нь ХАА-н газарт хамаарагдаж байна. ХАА-н газрын мөн 96 хувь нь өнөөдөр бидний ярьж буй бэлчээртэй холбоотой газарт хамаарагдаж байна. Тэгэхээр цаашид уур амьсгалын өөрчлөлт, бүтээн байгуулалт, уул уурхайн хөгжилтэй холбогдуулан бэлчээртэй холбоотой газрын асуудлыг нарийвчлан шийдэх зайлшгүй шаардлага тулгамдаж байна. Малчны тухай хууль батлагдсан.

Энэ хуультай холбогдуулан газрын харилцаатай холбоотой дараах заалтууд батлагдсан. Малчны тухай хуулийн 7.3 дахь заалтад Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно гэж заасан. Мөн 7.4 дэх заалтад залуу малчин гэр бүл болон хот, суурингаас шилжин очиж 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сумын Засаг дарга шийдвэрлэнэ гэсэн зохицуулалт батлагдсан.

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтад бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана гэж заасан. Отрын бэлчээр, дамжин өнгөрөх бэлчээр, ус, цэцэг, хужир, мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдлаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээний дагуу ашиглуулж болно гэсэн хуулийн эрх зүйн орчин бүрдсэн.

Энэ хуулиас өмнө, анх удаа Газрын тухай хууль батлагдсанаас хойш хэрэгжиж байгаа 52.7 дахь заалтад өвөлжөө, хаваржааны доорх газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно гэж заасан. Эдгээр хуулийн зохицуулалтууд өнөөдөр хэрэгжээд явж байна. Газрын тухай хууль дээр газрын харилцаа, тэр дундаа ХАА-н эдэлбэр газар, бэлчээрийн ашиглалттай холбоотой асуудлыг дараах үндсэн зарчмуудаар зохион байгуулж, газар эзэмших, ашиглах эрх олгох асуудлыг шийдвэрлэж байна. ХАА-н эдэлбэр газартай холбоотой бэлчээр ашиглалтын асуудал нь бэлчээрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг. Гэсэн хэдий ч шийдвэр гаргаж байгаа этгээд нь сум, дүүргийн Засаг дарга нар юм.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу бэлчээрийн газрын асуудлыг зохицуулж байна. Энэ нь газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг үндэслэж газар олгох асуудал шийдэгддэг. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын

ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гэсэн үндсэн хөгжлийн төлөвлөлтийн бодлогын баримт бичгүүдэд үндэслэж боловсруулагддаг. Эдгээр боловсруулсан төлөвлөгөөг сум болон нийслэл, дүүргийн ИТХ баталж шийдвэрлэдэг. Үүгээр баталсныг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг эдгээр төлөвлөгөөг шалгаж, хянаж, дүгнэлт гарган Засгийн газарт оруулж, жагсаалтыг баталснаар тухайн жилд эзэмшүүлж, ашиглуулах газрууд батлагддаг.

Энэ зөвлөгөөн, сонсгол дээр яригдаж байгаатай холбоотой тусгай зөвшөөрөл буюу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг мөн 2024 оноос өмнө шууд олгож байсан. Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль хоорондоо уялдаа холбоо муутайгаас болж газрын давхцал үүсэх асуудал гарч байсан. 2024 онд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газраар дүгнэлт гаргуулж, жагсаалтыг жил болгон баталдаг болсонтой холбогдуулан, Ашигт малтмалын газраас олгож байгаа бүх тусгай зөвшөөрөл дээр дүгнэлт гаргаж байж тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлүүлж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт минут өгье.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: ...үйл ажиллагаа явагдсантай холбоотойгоор газар олголт болон тусгай зөвшөөрөл олгох харилцаа хоорондоо уялдаж, газрын давхцал үүсэх асуудал шийдвэрлэгдсэн гэж үзэж байна.

Засгийн газрын энэхүү шийдвэрийн дараа тухайн шатны иргэд, Засаг дарга нар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрүүдийг гаргаж байна. Гарсан шийдвэрийг үндэслэн дүүрэг болон сумын газрын алба, даамлууд тухайн газрыг нэгдмэл санд бүртгэж, газрын гэрээ, гэрчилгээг цахимаар олгодог. Олгогдсон газар дээр сум, дүүргийн Засаг дарга нар хяналт тавьж ажилладаг. Мөн бэлчээрийн газарт манай байгууллага болон Ус, цаг уур, орчны шинжилгээний газар хамтран төлөв байдал, чанарын мониторингийг жил бүр хийдэг. Нөхөн сэргээх үйл ажиллагааг Байгаль орчны яам, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэж байна.

Бэлчээрийг ашиглахаас гадна зөв зохистой хамгаалах, нөхөн сэргээх асуудал бидний өмнө тулгамдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн орон нутгийн онцлогт тохирсон бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг баталж мөрдүүлнэ гэсэн заалт бий. Энэ заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2025 онд манай байгууллагаас бүх аймагт бэлчээр ашиглах, хамгаалах журмын төслийг боловсруулж хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар нийт сумдаас 79 сум энэ журмыг баталж, хэрэгжилтийг хангаж зохион байгуулж байна. Цаашид энэ журмыг бүх суманд баталж мөрдүүлэх шаардлагатай.

Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх үйл ажиллагаа нь 2003 онд Газрын тухай хуулийг шинэчлэн баталснаас хойш хэрэгжиж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 111,551 байршилд 39,313.2 га талбайг эзэмшүүлсэн статистик гарч байна. Өнөөдөр хэлэлцэж байгаа Малчны тухай хууль хэрэгжсэнээс хойш буюу сүүлийн 2 жилийн хугацаанд 9,299 байршилд 3,224.24 га газрыг өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлсэн байна. Энэ хуулийн гол зохицуулалт болох залуу малчин гэр бүлд 2,099 нэгж талбар газрыг эзэмшүүлсэн байна. Мөн хот суурин газраас шилжиж очсон, 2 жилээс дээш хугацаанд тасралтгүй мал маллаж байгаад малчин болсон өрхөд 99 нэгж талбар газрыг эзэмшүүлсэн

мэдээлэл газрын нэгдмэл сангийн цахим системд бүртгэгдсэн байна.

Аймгуудаар энэ хуулийн хэрэгжилтийг гаргаж үзэхэд хамгийн өндөр хэрэгжилттэй нь Хөвсгөл, Хэнтий, Архангай аймгууд байна. Улсын хэмжээнд эзэмшүүлж, өмчлүүлж байгаа өвөлжөө, хаваржааны газрыг он тус бүрээр харуулсан бөгөөд хууль хэрэгжсэн онд нэлээдгүй газрын асуудлыг шийдвэрлэсэн. 2025 он болон 2026 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 1,519 өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлээд байна. Хуульд хамаарагдаж байгаа бүлгүүдийг хүйсээр нь ангилж үзвэл эмэгтэй малчинд газар эзэмших эрх олгосон нь 6%, эрэгтэй малчдад олгосон нь 94% байна. Энэ жил бүх сум газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө баталж, цахим системд бүртгүүлсэн.

Энэ жилийн төлөвлөгөөгөөр 6,656 нэгж талбар газрыг малчдад өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлэхээр төлөвлөсөн бөгөөд одоогоор 1,519 газрыг эзэмшүүлээд байна. Цаашид 4 мянга гаруй нэгж талбар газар одоогоор шийдэгдээгүй байна. Өвөлжөө, хаваржааны газраа аваагүй байгаа иргэд сумын Засаг дарга нартаа хандаж энэ асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой.

Хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дурдвал, бэлчээр, газрын асуудал болон салбар хоорондын уялдаа холбоог шийдвэрлэх үүднээс Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж байна. Энэ төсөлд ашигт малтмалын асуудал, бүтээн байгуулалт хэрэгжиж байгаа газруудын газар ашиглалт, ойн сан, усан сан зэрэг газартай холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр тусгаж байгаа. Бэлчээр ашиглалттай холбоотой зохицуулалтуудыг мөн энэ хуулийн төсөлд нарийвчлан тусгахаар төлөвлөж байна.

Цаашид зөвхөн өвөлжөө, хаваржааны газрын асуудлаас гадна малчин өрхийн бэлчээрийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, лиценз авсан талбайтай давхцаж байгаа зөвхөн өвөлжөө, хаваржааны газраас гадна тухайн малчин өрхийн хамаардаг бэлчээр дээр нөхөн олговор тооцдог болох нарийн зохицуулалтуудыг энэ хуулийн төсөлд оруулж шийдвэрлэнэ. Одоо ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн төсөл боловсруулах ажлыг бүх салбарын оролцоотойгоор хийж байгаа бөгөөд намрын чуулганаар энэ хуулийн төслийг өргөн барина гэж үзэж байна.

Хоёрдугаарт, бэлчээрийн фото мониторингийн үнэлгээг жил бүр хийдэг. 2020–2026 оны үр дүнд суурилсан, хоёр дахь удаагийн Үндэсний тайланг боловсруулж дуусаж байгаа бөгөөд энэ тайланг удахгүй болох КОП-17 олон улсын хуралд танилцуулахаар бэлтгэсэн.

Дараагийн ээлжид малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах журам болон гэрээний загварыг боловсруулах ажлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран хийж, малчдаар хэлэлцүүлэн батлуулах үе шатанд явж байна. Мөн бэлчээр ашиглах, хамгаалах жишиг журмын төслийг 2025 онд аймгуудад хүргүүлсэн бөгөөд үүнийг бүх сумдад батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.

Цаашид малчдын бэлчээр ашиглах эрхийн баталгааг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангах эрх зүйн орчныг бий болгож боловсронгуй болгох ажилд анхаарч ажиллах шаардлагатай. Мөн 2026 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар тусгагдсан газруудаас Малчны тухай хуульд заасан залуу гэр бүл болон хот суурин газраас шилжиж очсон малчдад эзэмшүүлэх асуудалд анхаарал

хандуулж, аль болох чирэгдэлгүй зохион байгуулахаар ажиллана.

Малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээ, байршлыг зураглаж мэдээллийн санд оруулах, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих цахим системийг шинээр хөгжүүлэх ажлыг эхлүүлж байна. Энэ ажлыг дуусгаж, хуулийн хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа хандуулна. Мөн бэлчээрийн мониторингийн үйл ажиллагаагаар цугларсан өгөгдөл, мэдээллийг хүртээмжтэй байдлаар бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон, малчид болон орон нутгийн удирдлага зэрэг олон нийтэд үнэн бодит мэдээллээр үйлчлэх мэдээллийн санг хөгжүүлэхээр ажиллаж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Одоо оролцогчдоос ирүүлсэн хүсэлтийн дагуу санал хэлнэ. Нийт 7 оролцогч саналаа ирүүлсэн байна. Архангай аймгийн Хашаат сумын О.Отгонцэрэн Та 5 дугаар микрофоны ард сууж, 3 минутад багтаан үгээ хэлнэ үү.

Оролцогч О.Отгонцэрэн: Архангай аймгийн Хашаат сум 300 гаруй мянган толгой мал, 700 гаруй малчин өрхтэй. Хашаат сумын нутагт тусгай хамгаалалттай газар болон бусад газар нь хот төлөвлөлтөд орсон, тухайлбал Өвөрхангай аймгийн Хархорин хотын гол газар төлөвлөлтөд хамрагдсан байгаа. Тэгэхээр тусгай хамгаалалтад орсон газарт байгаа малчид тухайн газартаа ямар ажил эрхлэх боломжтой вэ? Аялал жуулчлал, газар тариалан эрхлэх боломж байна уу? Хот төлөвлөлтөд газар нь орсон, байшин барилгаа тохижуулсан малчдын байшин барилгын үнэлгээ хэрхэн тогтоогдох вэ? Тэр Малчны тухай хуульд хэрхэн тусгасан бэ? Малчид цаашид хэрхэн хэвийн ажиллаж амьдрах

Архангай аймгийн Хашаат сумын Жаргалант баг, Бага Бэрх гэдэг газарт уул уурхайн лиценз олгосон гэж яригдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор иргэдийн дунд үл ойлголцол үүсэж байна. Энэ газар уул уурхай болох уу, эсвэл хот болох уу гэдэг дээр малчдын дунд эргэлзээ байна. Тийм учраас Хангайн бүсээс сонгогдсон гишүүд энэ асуудал маш тодорхой хариулт өгөх болов уу гэж бодож байна. Өнөөдөр малчдын хувьд ерөнхийдөө ийм асуулт байна. Малчны тухай хуульд малчдын өвөлжөө, хаваржааны доорх газрыг малчдад баталгаажуулж, төрөөс уул уурхай болон бусад чиглэлээр ашиглахыг хориглоно гэсэн заалт бий. Энэ заалтаар малчдын эрхийг ямар байдлаар хамгаалах вэ? гэдэг асуултад тодорхой хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын иргэн С.Цэцэгсайхан, Та 3 дугаар микрофоны ард сууна уу.

Оролцогч С.Цэцэгсайхан: Сайн байцгаана уу? Би Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын хөдөө аж ахуйн бэлчээр хариуцсан мэргэжилтэн. Манай сум Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутаг бөгөөд гаднаас малчид маш ихээр орж ирдэг. Оршин суугаа малчдын мал зуданд нэрвэгдэж үхдэг. Гэтэл гаднын малчид ирэнгүүт өвөлжөө, хаваржааг нь авч, хажуу хавийн өрхүүд хоорондоо муудалцдаг асуудал үүсдэг.

Хоёрдугаарт, эрт илрүүлгийн эмнэлгийн талаар хэлье. Хөдөө орон нутгийн эмнэлэгт орон тоо цөөн, ганц ерөнхий эмчтэй байдаг. Шүдний эмч, эмэгтэйчүүдийн эмч зэрэг нарийн мэргэжлийн үзлэгт заавал аймгийн төв орох шаардлагатай болж, маш их дараалал үүсдэг. Сум, орон нутагтаа нарийн мэргэжлийн эмчийн орон тоо бий болгох боломжтой юу? Мөн сумдад хөдөө аж ахуйн тасаг байдаг бөгөөд энэ нь

3 хүний орон тоотой байх ёстой атал нэг хүн 3 хүний ажлыг хийж байгаа тохиолдол бий. Энэ 3 орон тоог бүрэн бий болгох боломж байна уу?

Бас ипотекийн 3 хувийн зээлийн талаар хэлье. Хэнтий аймаг нийтдээ 3.4 сая малтай, 915 малчинтай, Орхон аймаг 161,300 толгой малтай. Хоёр аймгийн ялгаа асар их байтал 2023–2025 оны хооронд Хэнтий аймагт нийт 121 малчин ипотекийн зээлд хамрагдсан байхад Орхон аймагт 991 малчин хамрагдсан байна. Энэ ямар учраас ийм зөрүүтэй байгааг асууж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, судлаач Г.Алтанхуяг, та 2 дугаар микрофоны ард сууна уу.

Оролцогч Г.Алтанхуяг: Малчны тухай хуулийн бас нэг гол асуудал бол бэлчээр мөн. Малчны тухай хуулийн 7.3 дахь заалт утгагүй байна. Тэнд эзэмшүүлэх үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно гэж заасан, Газрын тухай хуулийн 52.7-д өвөлжөө, хаваржааны доорх газрын тухай заасан байдаг. Тэгэхээр энэ зохицуулалтыг Байгаль орчны яаманд энэ хуулийн төсөл очихдоо ямар саналтайгаар оруулж ирсэн юм бэ? гэдгийг асуумаар байна. Зун, намар, зуслангийн бэлчээрийг малчид хууль зөрчиж ашиглаад 2 жил болчихлоо. Тэгэхээр заавал иргэдийг хууль зөрчүүлсэн ийм заалтыг байлгах хэрэгтэй юу? гэдэг асуудал байна.

Хоёрдугаар асуудал бол энэ хуулийн 5.1.2, 5.1.3, 5.3.2, 5.4.4 зэрэг сайн заалтууд байгаа боловч тэдгээр нь зөвхөн 7 дугаар зүйлийн гурван заалтаар хязгаарлагдчихаад байна. Тэгэхээр бусад заалтууд нь хэрхэн хэрэгжих юм бэ? Бүхэл бүтэн хууль гарсан атал түүний ар талд журам гаргах ямар ч шаардлагагүй гэж үзэж байна. Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулиар бэлчээрээ дундаа яаж эзэмших вэ? Хоршоо, бүлэг байгуулаад сумын Засаг даргатайгаа гэрээ байгуулан явах боломж бий. Энэ хуулийн заалтаар шууд хэрэгжүүлж болно. Гэвч Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль гэдгийг сумын Засаг дарга нар болон малчид огт мэдэхгүй байна. Тийм учраас үүнийг сурталчлах нь нэн шаардлагатай. Хуулийн 7.4-т 2 жил болоод залуу малчинд сумын багийн иргэдийн Нийтийн Хурлаар газар, өвөлжөө олгоно гэж заасан. Гэтэл зүүн зүгт хуулиа мэдэхгүй байж зохицуулалт хийгээд явчихсан байна. Учир нь газрын эзэн буюу өвөлжөөний эзэн 100-200 малтай байхад туслах малчин болж очиж байгаа хүн нь мянган малтай байдаг. Ийнхүү ямар хуулийн зохицуулалтаар хийсэн юм бэ? гэж асуухад сумын Засаг дарга нь надад хүн хэлж өгсөн, ингэж хийвэл болно гэж л ярьдаг.

Тэгэхээр хуулиа мэдэхгүй байж тэнд зохицуулалт явагдаад эхэлчихсэн байна. Зүүн талын 3 аймагт, ялангуяа бэлчээрийн бүс нутгуудад тийм зохицуулалт явагдаж байна. Эрүүл мэндийн асуудал. Говийн 3 бүс, 103 сумын иргэд нуруу, хүзүүний шохойжилт, элэг, нүдний өвчлөл маш өндөр байна. Усан дээр хяналт тавьж, ус цэвэршүүлэх үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэй. Энэ талаар Эрүүл мэндийн яам ямар судалгаатай байгаа вэ? Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын С.Мааманхүү, 3 номерын микрофоныг нээж өгнө үү.

Оролцогч С.Мааманхүү: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бидний хүсэн хүлээж, мөрөөдөж байсан энэ хэлэлцүүлгийг өнөөдөр хийж байгаад миний хувьд маш их баярлаж байна. Би гурван зүйл дээр товч ярья.

Нэгдүгээрт, цахим хөгжлийн талаар. Цахим хөгжил анх гарч ирэхэд малчид бид соён гэгээрүүлэх сайхан зүйл гэж дуртайяа хүлээж авсан. Гэвч зарим газар 1960-аад оны үеийнх шиг, жалганд байдаг хэвээрээ байна. Цахим хөгжил хөдөөд хүрэхгүй байна, интернэт маш муу. Би аймгаас 20 км-ийн зайд амьдардаг атлаа цахим үйл ажиллагаанд оролцож чаддаггүй. Олон төрлийн тоног төхөөрөмж тавьсан ч цахим хөгжилтэй хөл нийлүүлж явж чадахгүй байгаа малчин олон бий. Хэрэв цахим хөгжил хөгжвөл малчдыг соён гэгээрүүлэх ажил түүн дотор яваа. Малчид бид интернэт хаягтайгаа фэйсбүүк рүүгээ орж чадахгүй байна, иймд сургалт хэрэгтэй байна. Малчдын өмнөөс дуу хоолой болж яваа төрийн бус байгууллагуудаар дамжуулан аймаг бүрт цахим хөгжлийн сургалт явуулж өгөөч. Жишээ нь Н.Баярсайхан гэдэг хүн маш сайхан сургалт явуулдаг бөгөөд хүн бүр түүний сургалтыг дагах сонирхолтой байдаг. Ийм сайн жишээ байгаа тул эдгээр төрийн бус байгууллагуудаар дамжуулан малчдаа хөгжүүлж, соён гэгээрүүлээч.

Хоёрдугаарт, бэлчээрийн асуудал. Бидний өвөлжөө, хаваржааны дэргэд, 500 метрээс 2 км-ийн зайд асар их газрыг өгчихсөн байдаг. Хэзээ өгснийг мэдэхгүй, малчдын хурлаар хэлэлцээд 5–10 га газрыг өгчихсөн байдаг. Энэ нь малчдын дунд маш их маргаан үүсгэдэг. Уг газрыг мод тарих зориулалтаар яг малын бэлчээр дээр өгчихсөн байдаг тул иргэдийн дунд маш их зөрчил гардаг. Үүн дээр ямар хууль байдгийг асуумаар байна. Энэ нь дэндүү хэцүү болж байна, тэр дундаа манай Өмнөговьд. Сайн зүйлийг хэлэхэд эрүүл мэндийн талаар Өмнөговь аймагт явуулын үйлчилгээ хүний эрүүл мэндэд маш сайн хүрч байгаа нь сайн туршлага гэж бодож байна.

Гуравдугаарт, уул уурхайн талаар хэлье. Эхлээд өөрийгөө товч танилцуулъя. Би дэлхийн нүүдэлчин уугуул иргэдийн ВАНИФ хорооны гишүүнээр 20 орчим жил ажиллаж байна. Тийм учраас уул уурхайн талаар хэлэхээс өөр аргагүй. Энэ мэдээллийг дамжуулъя. Бидэнд өнөөдөр уул уурхай бидний өрсөлдөгч болж гарч ирж байна. Малчид бид уул уурхайтайгаа хэрхэн ажиллах ёстой вэ гэдэг асуудал тулгамдаж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын М.Батболд. 4 номерын микрофоныг өгье.

Оролцогч М.Батболд: Малчдыг нэг татвар төлдөггүй юм шиг төвийнхөн ойлгоод байх юм. Бид нар малын хөлийн татвар, хог хаягдлын татвар, бууны татвар, унаж байгаа портер, мотоциклийн татвар, нохой, муурны татвар зэргийг төлдөг шүү дээ. Гэтэл малчид татваргүй, улсаас тэжээгдэж байгаа юм шиг бодогддог. Үүнийг бас ойлгож үзээрэй. Эрүүл мэндийн талаар би түрүүн хэлсэн. Малчдын эрүүл мэнд хохирч байна. Аймагтаа олигтой оношлуулах боломжгүй байна. Оношийг нь тогтоосон бол цаана нь эмчилдэг эмч бэлэн байх ёстой. Оношоо тогтоолгочихоор хэвтэх эмнэлэг олддоггүй, улсын эмнэлэг 2 сар хүлээлгэдэг, хувийн эмнэлэгт очих боломж байдаггүй.

Тэгэхээр малчин нэг удаа өвдөхөд оношийг нь тогтоосны дараа шууд эмнэлэгт хэвтүүлдэг байх асуудлыг энэ хуульд сайн тусгаж өгөөч гэж бодож байна. Оношоо тогтоолгож байгаа ч хэвтэх эмнэлэг олддоггүй. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Юмжирмаа, 4 номерын микрофон.

Оролцогч Б.Юмжирмаа: Хот, малчид гээд хоёр тал болж хуваагдан талцдаг асуудлыг өнөөдөр сонсож байгаад талархаж байна. Хэлэлцэх асуудлын хүрээнд өнөөдөр хоёр асуудлаар яригдаж байгаагаас зөвхөн нэг дээр нь л ярих боломжтой тул эрүүл мэндийн талаас асууя.

Манай аймгийн нийт өрхийн 12 мянга нь малчин өрх байдаг. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн хувьд өнөөдөр, маргаашийн хоёр сонголд мал аж ахуй, малчны хуулийн асуудал ямар байгааг сонсохоор сууж байна. Эрүүл мэндийн яамны танилцуулгаас харахад үнэхээр хангалтгүй байна. Нэгдүгээрт, сум, аймгаар нь ялгасан, Засгийн газраас гарч байгаа бодлогыг сум, аймгийн түвшинд хэрхэн хэрэгжүүлж байгаа тоон мэдээлэл алга байна. “40%-д хүрэхгүй байна”, “50%-д яаж хүргэх вэ гэж бодож байна” гэж ярьж байгаа нь зөвхөн бодох түвшинд байна шүү дээ. Ямар ч төлөвлөгөө, үйл ажиллагаа, гүйцэтгэл, шалгуур үзүүлэлт, арга хэмжээ алга. Бид нар ийм байдлаар танилцуулга сонсож сууж байна. Малчид яамны илэрхийлж байгаа тооноос юу ч олж авч чадахгүй байна. Бүхэлд нь баахан тоо илэрхийлээд, улсын хэмжээнд ийм явж байна гэж байна.

Бид нар аймгийн хурал дээр ч малчдад эрүүл мэндийн чиглэлээр зориулж хийсэн ажил, арга хэмжээний талаар нэг ч удаа сонсож байгаагүй. Тэгэхээр багийн түвшинд, малчид, өрх дээр хэрхэн очиж байгаа дээр яам хариуцлагатай хандаж ажилламаар байна.

Хуулийн 4.2.6-д жил бүр үнэ төлбөргүйгээр урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авна гэж заасан. Өөрсдөө хуульдаа заачихсан атлаа ямар ч хэрэгжилт байхгүй байна. Үүнийг Засгийн газрын журам батлагдсан уу? эсвэл аймаг, сумд хэрэгжүүлдэггүй юм уу? гэдэг дээр хариулт хэрэгтэй байна. Энэ буурч байгаа үзүүлэлт нь малчин өөрөө шимтгэлээ төлдөг ангилалд ордогтой холбоотой юу? эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжгүй байгаатай холбоотой юу? Төлсөн ч төрөөс үйлчилгээ авч чадахгүй байна гэж малчид төлөлтөө бууруулж байгаа юм уу гэдэгт яагаад анализ хийхгүй, холбогдох арга хэмжээ төлөвлөхгүй байна вэ гэдгийг асуумаар байна. Хиймэ оюун ухаанаар гаргачихсан гэлтэй тоонууд байна. 2026 онд 61-ээс дээш насны малчны хамрагдалт тэг хувьтай байж байхад яагаад арга хэмжээ авах төлөвлөгөө байхгүй байгаа вэ, үнэхээр хангалтгүй байгааг хэлмээр байна...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн оролцогч, “Хил хязгааргүй алхам” ТББ-ийн Н.Баярсайхан, та 12 дугаар микрофоны ард сууна уу.

Оролцогч Н.Баярсайхан: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын илтгэлтэй холбогдуулан асуулт асуух гэсэн юм. Малчдын талаар төрөөс аливаа шийдвэр гаргахдаа дата, шинжилгээ, судалгаанд үндэслэх хэрэгтэй. Монголын 330 сумын 300 нь уул уурхайн ямар нэгэн лицензэд хамрагдаж байгаа. Тэгэхээр дийлэнх малчид ямар нэг байдлаар уул уурхай, түүний дэд бүтцийн нөлөөллийн бүсэд амьдарч байна. Уул уурхайн лицензийг хөдөө аж ахуйн газар дээр олгодог. Монгол Улс газраа зургаан ангилдаг бөгөөд уул уурхай нь хөдөө аж ахуйн ангилал дээр байдаг. Гэтэл лицензийн талбайд өртсөн малчин өрхийн тоо гэвэл байдаггүй юм байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас гаргаж өгнө гэсэн боловч одоо хүртэл гаргаж өгөөгүй байна. Тэгэхээр энэ тоо байхгүй.

Малчны тухай хуулийн 4.1.1, 5.1.2-т бэлчээрийн газраа баталгаажуулах заалт байгаа. Хуулийн 7.3 бол маш чухал заалт. 7.3-ыг баримталбал 2024 оны 6

дугаар сарын 5-наас хойш малчны бэлчээр дээр давхцаж олгогдсон лицензүүдийг хүчингүй болгуулахаар Захиргааны хэргийн шүүхэд хандахад энэ хуулийг хэрэглэх боломжтой болчихоод байна. Тэгэхээр ийм хууль хоорондын болон салбарын бодлогын уялдаагүй байдал нь эргээд бусад салбарт эрсдэл үүсгэж байна. Тийм учраас маргаашийн сонсгол дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөллийг заавал байлгаж, хөдөө аж ахуйн ангиллын газар дээр мал аж ахуй, уул уурхайн салбар хамт үйл ажиллагаа явуулдаг асуудлаар нүүр тулсан асуулт, хариулт хийх нь зүйтэй гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За, маргааш Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төлөөллийг дуудъя. Таны саналыг тэмдэглэж авлаа. Дараагийн оролцогч, Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Ц.Ундармаа. 4 номерын микрофон.

Оролцогч Ц.Ундармаа: Та бүгдэд өдрийн мэнд хүргэе. Хүрмэн сумын малчдын өвөлжөө, хаваржааны газрын талаар ярих гэж байна. Хамгийн урд цэг болох Орвог гашууны бор толгойгоос наашаа 17 км-т анхны айл байдаг. Тэрнээс наашаа айлууд бүгд лицензтэй талбай дээр байна. Хүрмэн сумын хоёр багийн нутаг дэвсгэр бүхэлдээ лицензтэй талбай юм. Нэг хятад иргэний нэр дээр 3 лиценз байх шиг байна. Лицензтэй талбайг, жишээ нь Эрдэнэбулагийн уурхайгаар татахад 3–4 айлын малын бэлчээрийг хашчихсан байдаг. Тэгээд ботго торон хашаанд орчихоод төөрч, эргэж чадахгүй хоносон тохиолдол гардаг. Дээрээс нь зэрлэг ан амьтан тэр бэлчээрт орооцолдож, малын бэлчээр хашигдсан байдаг. Өвөлжөө, хаваржаатай давхар лиценз олгогдсон ийм асуудлууд Өмнөговь аймгийн Хүрмэн сумд байна.

Эрүүл мэндийн тал дээр ч маш их хохирч. Малчид малынхаа завсараар арай гэж аймаг ороод үзүүлэхэд дандаа дараалалтай. Малаа хаяад нэг өдрийн дотор явж ирэх хүмүүс үзүүлж чаддаггүй. Малчдыг үзэх өдөр, эсвэл малчдыг аймгийнхаа иргэдтэй давхцуулахгүй хуваарьтай болговол боломжтой юм болов уу? гэж бодож байна. Мөн сул орон тоо хэрэгтэй байна. Хамгийн захын бригадын малчид өвдвөл хамгийн урд талын цэгээс 260 км явж байж хүрч байна. Багийн эмч цалин аваад сууж байдаг ч багийнхаа төв дээр биш, сумын төв дээр байдаг. Багийн эмч сумын төв дээр суугаад цалин авдаг. Хэрэв ойрхон малчдынхаа дунд, багийн төв дээр байх юм бол малчид багийнхаа төвөөс үйлчилгээ авах боломжтой болно. Гэтэл авч чадахгүй байна, хөдөөгийн эрүүл мэндийн асуудал үнэхээр хэцүү. Нэг малчин “төрөх гэж л нэг удаа эмнэлэг орсон, тэрнээс хойш ороогүй” гэж хэлж байсан. Зарим үед хатуу боловч үнэн үг. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам энэ асуудалд анхаарах нь зүйтэй. Малчид цаг заваа гаргаж, малаа хаяж явж чаддаггүй тул эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах тал дээр анхаарах нь зүйтэй. Дараагийн оролцогч, Дорноговь аймгийн Б.Амгаланбаяр. 4 номерын микрофон.

Оролцогч Б.Амгаланбаяр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас асуух гэсэн юм. Монгол Улсад уул уурхайтай давхацсан өвөлжөө, хаваржаатай айл хэд байдаг вэ? Энэ тоо гараагүй байсан. Уул уурхайтай давхцаж, бэлчээр нь хумигдсанаас малчид бэлчээргүй болж байна. Бэлчээр хумигдсанаас хүний эрүүл мэнд ихээхэн хохирч байна. Хүмүүс эрүүл мэндээрээ их хохирч, үзүүлж эмчлүүлж чадахгүй, нөхцөл байдал маш хүнд байна. Хөдөөгийн амьдралын талаар түрүүн Өмнөговь аймгийн төлөөлөл хэллээ. Үүнтэй уялдуулан хөдөө орон нутгийн малчдыг 1 дүгээр шатлалын эмнэлэгт сум, аймгаар нь хуваарилж, сар бүр цаг тогтоож өгвөл хөдөөгийн малчид үзүүлэхэд хэрэгтэй байна.

Бэлчээрийн асуудал дээр нэг зүйл хэлье. Уул уурхай газрыг авсан тохиолдолд малчид бэлчээргүй болж, тоос тоосонцроос болж мал ихээр өвчилж байна. Дээрээс нь хүний астма, зүрх, цусны даралт ихсэх тохиолдол маш их байна. Уул уурхайгаас болж стресс ихэснэ, стрессээс болж хавдар үүсэх магадлал өндөр байна гэж эрүүл мэндийн талаас харж байна. Хариуцлагагүй уул уурхайгаас болж хүмүүс маш их стресст ороод байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: За, оролцогчид үг хэлж, саналаа илэрхийлж дууслаа. Одоо үг хэлэх УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү. Р.Сэддорж гишүүнээр тасаллаа. Р.Сэддорж гишүүн, та үгээ хэлнэ үү.

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Энэ нь малчны тухай хуульд орсон эрүүл мэндийн асуудал тул Эрүүл мэндийн яамнаас тодруулж асууя. Малчдын нийгмийн даатгалын мөнгөөр зардлуудаа арай хэтэрхий зарцуулаад байгаа юм биш үү? Малчдын эрүүл мэндэд зарцуулах ёстой мөнгө янз бүрийн барилга, байшин болон бусад зардал болж яваад байна уу? Энэ дээр Эрүүл мэндийн яам тодорхой тайлбар өгөөч. Хэрэв малчдын эрүүл мэндийг санхүүжүүлэх, яаралтай тусламж үйлчилгээ очиход санхүүжилт байхгүйгээр бүх мөнгийг нь зарцуулчихаж байгаа бол энэ зарцуулалт үнэхээр буруу байна. Нэгдүгээрт зарцуулах ёстой зүйлдээ зарцуулахгүй байна. Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн яамнаас тайлбар авъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам хариулъя. 15 номерын микрофон

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр: Р.Сэддорж гишүүний асуултад хариулъя. Түрүүн миний хэлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн талаар, нийгмийн даатгал биш ЭМД-ын сангийн талаар асуусан гэж бодож байна. ЭМД-ын сангийн орлого болон эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлыг авч үзвэл, 2025 онд төсвийн тухай хуулиар 1.7 их наяд төгрөг батлагдсан байгаа. Энэ нь үндсэндээ улсын төсвийн байгууллагуудаар дамжин явж байна. Урсгал зардал нь 1,5 их наяд, хөрөнгийн зардал нь 145,9 тэрбум төгрөг байна. Өөрөөр хэлбэл нийт зардлын дийлэнх хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой зардал байна.

Мөн тусдаа батлагддаг ЭМД-ын сангийн төсөв байдаг. 2025 оны байдлаар эрүүл мэндийн сайдын багцад 2,4 их наяд батлагдсан. Үүний бүрдлийг авч үзвэл, ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл нь 1,1 их наяд, төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл буюу хүүхэд, ахмад настан, жирэмсэн, төрөх ээжүүдийн шимтгэл нь нэлээн бага буюу 352 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт нь 921 тэрбум төгрөг, бусад даатгуулагчаас төлөх шимтгэл нь 49.8 тэрбум буюу нийт орлого ингэж бүрдэж байна. Зарцуулалтыг авч үзвэл, 2025 оны төсвийн жилд 2,2 их наядын зарцуулалт гарсан. Үүнээс ЭМД-ын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт нь 963,7 тэрбум, төрөөс хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт нь 1 их наяд, хөнгөлөлттэй эм 171 тэрбум төгрөг, бусад урсгал зардал буюу агентлагийн үйл ажиллагаа, ЭМД-ын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд 113,9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ нь өндөр хэмжээний барилга, байгууламж зэрэг зүйл рүү ерөөсөө зарцуулагдаагүй.

Бидний илтгэлийн хугацаа 10 минут учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломж хязгаарлагдмал байгааг зөв ойлгоорой. Бид бүх аймаг, сумдаараа гаргасан мэдээллийг бүрэн хэмжээгээр бэлэн болгосон. Сумын хэмжээнд аймгийн төвөөсөө

алслагдсан байдлаас нь хамаарч А, Б, В гэсэн 3 зэрэглэлийн сум байдаг бөгөөд 1, 2, 3 дугаар зэрэглэлд хуваагдсан. Хүн амын тооноос хамаарч сумын Эрүүл мэндийн төвийн стандарт тогтоогдсон. Жишээ нь мянган хүн тутам 1 эмчтэй байна гэх мэт. Энэ стандартаар явдаг учраас зарим нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломж зарим талаар хязгаарлагдмал байна. Төрөөс үүнд нэлээн анхаарч байгаа. Сумд ажиллаж байгаа эмч Улаанбаатарт ажиллаж байгаа эмчээс орон нутгийн 40 хувийн нэмэгдэл, аймгийн төвд 20 хувийн нэмэгдэл авч байгаа. Цалингийн систем нь орон нутагт ажиллахад илүү таатай байхаар зохион байгуулагдсан боловч харамсалтай нь өнөөдрийн хүний нөөцийн байдлыг авч үзвэл аймаг, орон нутгийн түвшинд хангалтгүй байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Р.Сэддорж гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлайгаас асууя. Аймаг, сумдын хилийн асуудал, өвөлжөө, хаваржааны асуудал дээр та тодорхой шийдэл хэлэх үү? Аймаг, сумын хилийг ер нь хэдэн онд өөрчилсөн юм бэ, өөрчлөхийн тулд УИХ-аар орсон уу? Манай өвөг дээдэс энэ бууц, өвөлжөөн дээр насаараа нутаглаж ирсэн атал одоо гэнэт өөр аймаг, өөр сум болчихоод манай сумын нутгаас яв гэж байна. Энэ асуудал яагаад гарсан юм бэ? Дэлхийн өөрчлөлтөөс болоогүй биз дээ? Усны зөвшөөрөл авахын тулд сумын хилийг өөрчилж, хэл ам гаргадаггүй сумынх нь иргэдийн хурлаар гаргуулчихсан ийм тохиолдол гарсан шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай хариулъя.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 58.2 болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14.1 дэх хэсэгт зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ батална гэсэн эрх зүйн орчинтой байна. Монгол Улсын хувьд 1960-аад оноос эхлэн сумдууд байгуулагдахтай холбоотойгоор сумдын хилийн цэсийг баталсан байдаг. 1977 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 75 дугаар зарлигаар бүх сумдын хилийн цэсийг нэг удаа бөөнд нь баталсан. Үүнээс хойш шинээр сум байгуулагдах, зарим сумд тус тусдаа салах бүрд сумдын хилийн цэсийг шинэчлэн баталдаг ийм хууль эрх зүйн орчинтой.

Одоогийн байдлаар АИХ-ын зарлигтай буюу хуучин 1977 оны зарлигтай 287 сум байна. Сүүлд шинээр нэмэгдсэн болон хуваагдсан, аймаг байгуулагдсантай холбоотой 52 сум УИХ-ын тогтоолоор шинэчлэн батлагдсан. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд ердөө 9 сум дээр л газрын хилийн цэсийн маргаантай асуудал байна. Энэ нь дандаа УИХ-ын тэр үед баталсан тогтоолтой холбоотой маргаан юм. Бусад маргаанууд бол газар зүйн нэрийн асуудалтай холбоотой. Гишүүний дурдсан өвөлжөө, хаваржаа аль суманд хамаарагдаж байгаа гэдэг нь бодит бус маргаан гэж үзэж байна. Хэрэв маргаантай асуудал гарвал Засгийн газрын журам байдаг. Энэ журмын дагуу орон нутгийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж, тухайн асуудал дээр очиж шалгаад дор дор нь шийдвэрлэдэг зарчимтай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Г.Тэмүүлэн гишүүн, та асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдуулан энэ танилцуулгаас хэд хэдэн зүйл асууя. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 40%-д хүрэхгүй байна гэж байгаа. Үүнийг яг ямар бодлого, зарчмаар, ямар арга хэмжээ авч, ямар төлөвлөгөөгөөр нэмэгдүүлэх ёстой вэ? Суурь шалтгаан нь юу вэ? Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлийг хийх асуудлыг хот, хөдөө бүгд ярьдаг. Тусламж үйлчилгээний хамрагдалтыг нэмэх, бүх иргэнийг хамруулах зайлшгүй шаардлага байна. Гэтэл сүүлийн үед ЭМД-ын сангийн санхүүжилттэй холбоотойгоор иргэд гомдоллож, эмнэлгүүд ч энэ асуудлыг ярьж байна. Санхүүжилтийг үндэслэлгүйгээр хасах, хумих бодлогоос болоод тусламж үйлчилгээн дээр квот тогтоож, санхүүжилтийн дээд хязгаар тогтоодог болсон. Тухайн эмнэлгийн өвчлөлөөр үзэх, хэвтүүлэх квот дуусвал өвчтөн сар, хоногоор хүлээх асуудлууд гарч байна. Тусламж үйлчилгээ иргэнээсээ холдсон гэдэг асуудал яригдаж байна.

Тэгэхээр та хэд энэ тогтолцооны шинэчлэлийг хэзээ хийх юм бэ? ЭМД-ыг шинэчлэх, санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох, иргэн хэрэгцээтэй үедээ тусламж үйлчилгээ авах боломжийг хэзээ бүрдүүлэх вэ? Тусламж үйлчилгээ багасаж, чанар муудаж, иргэн хохирох асуудал хүндээр хөндөгдөж байна. Сая Р.Сэддорж гишүүний хэлсэн асуудалтай нэг ийм зүйл бий. Архаг хууч өвчний хувьд ЭМД-ын сангаас санхүүжүүлэх, эмчлэх асуудал хасагдсанаас болоод өндөр настай хүмүүс хүндэрч, эсвэл харваж, нөхцөл байдал дордож, эмнэлэг дээр улам их санхүүжилт, зардал гарах асуудлууд үүсэж байна. Тэгэхээр бид нар илүү урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлого руугаа явах ёстой. Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог нэмэгдүүлэх асуудал тавигдах ёстой.

2025 оны 10 дугаар сараас хойш урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо байхгүй болчихлоо гэдэг асуудал байна. Энэ хэзээнээс сэргэх вэ? Хуульд тавьсан заалт, хэрэгжилт хэзээнээс хэрэгжих вэ, хамрагдалтыг нэмэгдүүлэх цаг хугацаа, график, тоо хэмжээ та бүхэнд байна уу? Ямар төлөвлөгөө, тооцоололтой байна, хэдий хэмжээнд хүргэх вэ? Ер нь хүнээ хамгаалах, хүнийхээ эрүүл мэндэд анхаарах асуудал явж явж мал аж ахуйн салбарын гол асуудал болсон. Мөн боловсон хүчний асуудал байна. Хүнийхээ хөгжлийг хамгаалах, эрүүл мэндийг нь анхаарах асуудал хамгийн нэгдүгээрт тавигдах ёстой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: ЭМЯ хариулъя. Г.Тэмүүлэн гишүүний асуултад Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар хариулна. 14 номерын микрофон.

Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар: Ерөнхийдөө статистик үзүүлэлт дээр нийт дүнгээр 308,748 малчин байна. Эдгээр малчдаас тэтгэврийн орлоготой буюу тэтгэвэр, тахир дутуугийн халамжид хамрагдаж байгаа 81,844 өндөр настан, нийгмийн халамж, тусламж үйлчилгээ шаардлагатай өрхийн 85 мянган хүн, мөн насанд хүрээгүй 12 мянган хүн, нийт 190 мянган малчин төр хариуцах шимтгэлтэй даатгуулагчид хамрагдаж байна. Түрүүний 116 мянга гэдэг тоог хасаад нийт дүнгээр нь тооцвол нийт малчдын 75 хувь нь ЭМД-д хамрагдсан байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ЭМД-ын сангаас санхүүжиж байгаа бөгөөд оноштой хамааралтай 684 бүлэг, 15 мянган оношийн тусламж үйлчилгээг авах нөхцөл бүрдсэн байгаа.

Гишүүний асуултад нэмж хэлэхэд, миний дурдсан 190 мянган хүн төр шимтгэлийг нь хариуцдаг 2.3 сая иргэний дотор багтаж байгаа. Өнгөрсөн жилийн

байдлаар төр хариуцах үйлчилгээнд 384 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 800 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан. Тэнд гарсан 1.7 сая иргэний дотор төр хариуцах иргэдийн, дурдсан 4 бүлгийн малчид багтаж явна. Тэгэхээр нийт дүнгээрээ ингэж явж байгаа. Хамрагдалтын түвшин буюу өөрөө шимтгэлээ хариуцдаг, ЭМД-ын тухай хуулийн 6.1-д заасан үлдсэн малчдын түвшинд хамрагдаж байгаа дүн 38,700 гэж гарсан. 2026 оны эхний байдлаар 8 мянга буюу буурсан дүнтэй байна. Түрүүн Төрийн нарийн бичгийн дарга бас хэлсэнчлэн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнээс гадна ЭМД-ын талаас даатгуулагчдыг хамруулах чиглэлээр 4 контент, 48 төрлийн видео хийж, нийт даатгуулагчид хүргэж байгаа.

Даатгалын шинэчлэлийн бодлогын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас Монгол Улсын Ерөнхий сайдын 70 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, 2025 оны 11 дүгээр сарын 27-нд ЭМД-ын сангийн талаарх 151 дугаар Засгийн газрын тогтоолыг батлуулсан. Энэ хүрээнд Эрүүл мэндийн яамнаас ЭМД-ын санг 2026–2028 онд даатгалыг хөгжүүлэх бодлогын төлөвлөгөө боловсруулж байна. Үүн дээр 9 зорилт бүхий 35 арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар хүргүүлэх бүрэн боломжтой. Энэний хамгийн гол зорилтын нэг бол ЭМД-ын шинэчилсэн найруулгын төслийг энэ онд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн, батлуулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Үүн дээр засаглал, орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн, та асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: ЭМД-ын сангаас аймгийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүд мөнгөө авч чадахгүй байна. Жишээ нь, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг тэрбум төгрөг авч чадаагүй байна. Сумын Эрүүл мэндийн төвүүд 20–30 сая төгрөг авч чадахгүй байна. Энэ мөнгө юу вэ? гэвэл эмч нарын цалин, бас тусламж үйлчилгээ үзүүлэх хэрэгсэл юм. Тэгээд энэ асуудлыг яаж шийдэж байгаа юм бэ? Нэг хэсэг улсууд хулгай хийгээд, дээрэм тонуул болсон гэсэн. Энэ хүмүүстэй хариуцлага тооцож чадсан уу, тэр мөнгийг олж авч чадсан уу? Энэ дээр тодорхой мэдээлэл өгөөч, хэдэн төгрөгийн асуудал байгаа юм бэ?

ЭМД-ын сангаас 2024 онд 36,9 тэрбум, 2025 онд 26,9 тэрбум, энэ оны мөн үед ердөө 5 тэрбум л байна. Бүр доошоо унаж байна. Малчдын, Монголын ард түмний эрүүл мэнд хөсөр хаягдсан байна. Та хэд үүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Тоон мэдээлэл ч өөрөө хэлж байна. Суман дээр очиход юу ярьж байна гэвэл, манайх хүнээ хэвтүүлээд тоо гүйцчихсэн, таныг авахгүй, мөнгө байхгүй гэж байна. Энэ сарын хүн хэвтүүлэх ёстой квот дуусчихсан, мөнгө байхгүй гэж байна. Энэ юу гэсэн үг вэ? Үүнийг нэг хариулж өгөөч. Энэ салбарыг та нар яаж ийм байдалд хүргэв? Энэ арга, технологиоо хэлж өгөөч.

Эрт илрүүлэг гэж байгаа, зардал мөнгө муу байна гээд малчиндаа хүрч чадахгүй байна гэж байгаа. Үгүй ээ, аймгийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүд бүгдээрээ машин, техник хэрэгсэлтэй. Яагаад малчиндаа хүрч чадахгүй байна вэ? Би өөрөө яагаад үүнийг хэлээд байна вэ гэвэл би өөрөө аймаг удирдаж байсан хүн. Та нар аймгийн Засаг дарга нартай гэрээ байгуулдаг шүү дээ. Энэ эрт илрүүлэг дээр мөнгө зарцуулдаг шүү дээ, байгаа шүү дээ. Яагаад үүнийгээ зарцуулахгүй байгаа юм бэ? Нийт Монголын ард түмэн, тэр тусмаа малчин, иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн бааз бүрдсэн үү, ер нь ийм юм та нарт байна уу? Уг нь бид нар бүх хүмүүсээ үзчихээд, иргэд ийм өвчтэй юм байна, ийм зовуурьтай юм байна, үүнд нь зориулаад ийм эмчилгээ явуулна гээд төлөвлөгөө

гаргаж, аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд ажиллаж байх ёстой. Уг нь ингэх гэж л эрт илрүүлэг хийдэг. Тэгээд яг тэр мэдээллийн баазаа бүрдүүлж чадсан уу, энэ дээр төлөвлөгөө гаргаж ажиллаж чадаж байна уу? Аймгийн Засаг даргатай яг ямар гэрээ байгуулдаг юм бэ? 40%-с дээш гаргана гэж гэрээ байгуулдаг юм уу, 60-80%-д хүргэнэ гэж гэрээ байгуулдаг юм уу?

Дараагийнх нь хорт хавдар. Өмнөх оноос, бүр 2–3 жилийн өмнөх оноос өнөөдрийг харьцуулсан тоог хэлж өгөөч.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам хариулъя.

Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулах түвшинд ЭМД-ын ерөнхий газар аймгийн Засаг даргатай байгуулах гэрээн дээр тухайн зорилтот түвшиндээ малчдынхаа тоог гаргадаг. Түрүүн та бүхэнд өгсөн мэдээлэл дээр жилээс жилд хамрагдалтын түвшин 140, 116, 85 гэдэг тоо бол өөрөө шимтгэл төлдөг хамрагдагчдын тоо. Өөрөө төлдөг хамрагдагчдын зорилтот бүлгийг яаж гаргадаг вэ гэвэл, аймгууд байгуулж байгаа гэрээ дээрээ зорилтот бүлгээсээ тэтгэвэр болон бусад чиглэл рүү шилжсэн малчдынхаа тоог хасаад, аймаг болгон өөр өөр зорилт тавьж гэрээ байгуулж байгаа. Гэхдээ гэрээний хэрэгжилт нь сайн дураараа төлнө гэж байгаа учраас малчид өөрсдийнх нь мэдлэг, хандлагаас шалтгаалан нэмэгдэхгүй байгаа чиг хандлага харагдаж байна.

Өмнөх жилүүдэд буюу 2025 онд ЭМД-ын ерөнхий газраас төсвийн хууль болон бусад шалтгааны улмаас хатуу буюу архаг, төлөвлөгөөт, цочмог гэсэн хэлбэрийн хязгаарлалттайгаар явсан. ЭМД-ын тухай хуульд батлагдсан төсөв, гэрээний тоо хэмжээний хүрээнд эрүүл мэндийн байгууллагатай гэрээ хийж, зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд гэрээний санхүүжилт гаргадаг хуультай. Тэгэхээр 2024 оноос шилжиж ирсэн 318,6 тэрбум төгрөгийн өр 2025 оны төсөвт шууд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, бид нар 2025 онд зарцуулах мөнгөнөөсөө 318 тэрбум төгрөгийн өрөө барагдуулсан тул ийм хатуу квоттойгоор явж байсан.

Оны төгсгөлд Засгийн газраас авсан бодлогын арга хэмжээний үр дүнд ЭМД-ын сангийн санхүүжилт, өр төлбөрийн ажлыг сайжруулах ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Энэ хүрээнд оны төгсгөлд 198 тэрбум төгрөгийн он шилжсэн өрийг гаргасан. Өөрөөр хэлбэл, 520 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсэхээс сэргийлж, балансын талдаа даатгалын сан тэнцэл ашигтай гарсан бодлогын арга хэмжээ авч ирүүлсэн.

Энэ оны хүрээнд ЭМД-ын тухай хуулийнхаа дагуу ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 18 дугаар тогтоолоор санхүүжилтийн нарийвчилсан хуваариудыг батлуулсан. Хатуу хэмжээний квотын асуудлыг ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 4 дүгээр сарын 16-нд хэлэлцсэн 7 дугаар тогтоолоор буюу лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ дээр хатуу квотоос зөөлөн хязгаар руу шилжих, бүх тусламж үйлчилгээг (архаг, цочмог, төлөвлөгөөт) санхүүжүүлэх бодлогын өөрчлөлтүүдийг хийсэн. Энэ бол 2026 оны 6 дугаар сарын 20-ноос эхлэн хэрэгжиж байна. 2025 оны төгсгөлд ЭМД-ын сан эрүүл мэндийн байгууллагуудад төлөх 198.3 тэрбум төгрөгийн өглөгтэй байсан. Сая 6 дугаар сарын байдлаар бүрэн барагдуулж дууссан бөгөөд эрүүл мэндийн сайд үүнийг барагдуулсан гэдгийг хэлсэн байгаа. Таны түрүүн асуусан асуултын хүрээнд, эхний 5 сарын байдлаар хянагдсан түвшнээр 89,1 тэрбум төгрөгийн гэрээнээс давсан гүйцэтгэл гарсан. Үүнийг эрүүл

мэндийн сайд шийдэж, ЭМД-ын ерөнхий газраас барагдуулахаар ажиллаж байгаа.

Таны өгсөн мэдээлэл дээр 116 мянган малчнаас даатгалын тусламж авсан хүмүүсийн тоон дээр 5 тэрбум төгрөгийн үйлчилгээ гэсэн байгаа. Тэгэхээр түрүүний 190 мянга бол 2.3 саяын иргэний 800 тэрбум дотор явж байгаа учраас 190 мянган малчдыг ялгаж гаргах боломжгүй. 116 мянга нь өөрөө хариуцан төлдөг буюу танилцуулга дотор явсан дүн гэж 2 өөр салгаж ойлгох хэрэгтэй.

Тогтоолоор 4 төрлийн эрт илрүүлэг явж байсан. Бид эрт илрүүлгийн чанар, үр дүнг сайжруулах зорилгоор өөрчлөлтүүд оруулж байгаа. Өмнө нь насны бүлгээр явж байсан бол энэ насны бүлгийн түвшинг хорт хавдар луу чиглүүлсэн. 6 төрлийн хорт хавдрын эрт илрүүлэг хийхээр ЭМД-ын Үндэсний зөвлөлийн тогтоолд 20 тэрбум төгрөгийг урьдчилсан байдлаар суулгаад явж байна. Ер нь 9 дүгээр сард тогтоолдоо, сайдын тушаалд өөрчлөлт оруулж, зорилтот буюу яг илрүүлэх чиглэл рүүгээ хорт хавдрын чиглэлээр буюу элэг, ходоод, умай, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг хийхээр төлөвлөж байна. Энэ илрүүлэг 9 дүгээр сард, яг зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн байдлаар эхлэхээр төлөвлөгдсөн.

Нэгдсэн мэдээллийн сангийн хувьд ЭМД-ын сангийн өнгөрсөн жилийн гүйцэтгэлээр нийт хамрагдалт 93.2% хувьтай байгаа. Манай ЭМД-ын сан бүрэн цахимжсан...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Хорт хавдрын тоог, өмнөх 2 жилтэй харьцуулсан тоон дээрээс нь хэлж өгөөч. Мөн та сая эрт илрүүлэг гэлээ. Бид нар өнөөдөр юу хийх гээд байна вэ гэвэл бүх хүмүүсээ үзээд жишээ нь тэдэн хүн хорт хавдартай, тэдэн хүн зүрх судасны, эс бол даралттай гэдэг яг ийм мэдээллийн бааз суурь байна уу гэж асууж байгаа юм. Иргэдээ хэдүүлээ мэддэг болмоор байна шүү дээ. Эрэгтэй нь хэд, эмэгтэй нь хэд юм? Хэдэн хүн ямар өвчтэй байгаа юм бэ? гэдэг судалгаагаа хэлж өгөөч. Дараагийнх нь газартай холбоотой асуудал. Хайгуулын лицензийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас шууд олгочихож байгаа юм. Үүнийг ер нь та хэдээс зөвшөөрөл авдаг юм уу? Та хэд ер нь яадаг юм бэ? Шууд газраа тавиад туучихдаг юм уу? Баахан хайгуул хийж, ухаж төнхөж, энд тэнд цооног тавьж байгаад буцаагаад хаячихаж байгаа юм. Хэн энэ газрыг хүлээж авдаг юм бэ? Хэн бэлчээрийн талбай руу шилжүүлдэг юм бэ? Энэ дээр ер нь бидэнд хараа хяналт гэж байна уу? Эзэн байна уу? Хэн хариулах вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар. 6 номерын микрофон.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Тусгай зөвшөөрөл олгох буюу ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шийдвэрлэж олгодог эрх зүйн орчинтой. Гэхдээ түрүүн миний дурдсан 2024 оны Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр, ийм төрлийн хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөл олгохдоо бэлчээрийн газар дээр малчдын өвөлжөө, хаваржааны газартай давхцуулан олгож байгаа зөрчлүүд маш их тулгамдаж байгаа тул, үүнийг цаашид гаргуулахгүй байх үүднээс заавал газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем дээр хяналт шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулж байж зөвшөөрлийг олгоё гэсэн шийдвэр гарсан. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэхийг

АМГТГ болон манай байгууллага хоёрт даалгасан. 2024 оноос хойш гарч байгаа хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо заавал энэ дүгнэлтийг үндэслэж шийдэж байгаа. Өөрөөр хэлбэл, давхцал, зөрчил гаргуулахгүй шийдвэр гаргаж байна.

Түрүүн сонсголд оролцогч асууж байсан, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй давхцалтай нийт 1,333 нэгж талбар, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхцалтай 3,389 нэгж талбар байна. Эдгээрийг бид нээлттэй мэдээлдэг. Энэ сонсголын хүрээнд 7.4 дэх заалтын дагуу хэрэгжилтийг гаргаж өгсөн. Болдын Уянга гишүүнээс говийн бүсийн малчдаас асуусан асуултыг бидэнд тавьсны дагуу, 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр лицензтэй давхцалтай байгаа газруудын мэдээллийг нээлттэй, албан бичгээр хүргүүлсэн. Мөн зарим тахилгатай уул, овооны нэрсийг тодруулж авсан. Тийм учраас манай байгууллагын хувьд нээлттэй ажиллаж байна...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам нэмж мэдээлэл өгнө үү.

Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар: Гишүүний асуултад хариулъя. Түрүүн хэлсэнчлэн даатгалд хамрагдсан 116 мянган хүний хувьд, хорт хавдрын туяа эмчилгээнд 2024 онд 330 мянга, 2025 онд 216 мянга, 2026 оны эхний байдлаар 81 мянган хүн хамрагдсан байна. Мөн хими эмчилгээнд 2024 онд 65 мянган хүн хамрагдсан байна. Улсын хэмжээний дүнг харвал жилдээ 8,015 шинэ тохиолдол илэрч өвчилж явж байна. Хавдар судлалын төв болон бусад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж байгаа, хавдарт зарцуулсан нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн жил 140 орчим тэрбум төгрөг байсан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар. 6 номерын микрофон.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: Д.Жаргалсайхан гишүүний асуултад тодруулж хариулъя. Уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаад тухайн газраа эргээд хүчингүй болгож, тусгай зөвшөөрөл нь цуцлагдахад яаж буцааж хүлээж авах вэ? энэ дээр ямар хяналт тавигдаж байгаа вэ? гэсэн асуулт байна. Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиар энэ салбарын хяналт шалгалтын асуудал хариуцсан байгууллагууд хяналт тавих ёстой. Буцааж нөхөн сэргээх, хүлээж авахад орон нутгийн хариуцах ажлууд байгаа. Газрын ангиллын хувьд шилждэггүй. Тухайн зөвшөөрөл хүчингүй болсноор тэр газар нь орон нутгийн өөрийнх нь мэдлийн газар болж, өөр зориулалтаар ашиглаж болно. Ийм зохицуулалттай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Мандхай гишүүн, Та асуултаа асууна уу.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Эрүүл мэндийн яамнаас асууя. Ажиллах хүчний 4/1 нь малчин өрх байна. Даатгалд хамрагдаж байгаа тоог харахад 154 мянган малчин өрх даатгалд хамрагдаж байна. 2025 оны байдлаар эрүүл мэндийн төлөвлөгөөт биелэлтэд 37,387 малчин хамрагдсан байгаа. 2026 онд хагас жил болж байхад 8,790 буюу энэ тоо 2025 онтой харьцуулахад буурч харагдаж байна. Үндсэндээ 17 мянган хүн хамрагдаагүй гэсэн үг үү? гэдгийг нэгдүгээрт тодруулъя. Энэ нь нийт малчин өрхтэй харьцуулахад ердөө 0.08 хувь л хамрагдаж байна. Тэгэхээр нэгдүгээрт, энэ малчдад эрүүл мэндийн баталгаа байгаа юу? Ажиллах хүчний 4/1-ийг хамарч байгаа эдгээр малчин өрхүүдэд эрүүл мэндийн баталгаа, ер

нь амьд явах эрх байна уу? гэдгийг бодлого боловсруулж, хэрэгжүүлж байгаа яамнаас нь асуумаар байна.

Хамрагдалтыг нэмэгдүүлэхэд ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юм бэ? Малчны тухай хуулийн эрт илрүүлэхтэй холбоотой заалт хэрэгжих ямар ч үндэслэл харагдахгүй байна. Эрт илрүүлгээс гадна, ахмадууд сумдаар ярьж байна. Үе солиулах, зүрх судасны өвчлөл малчдад нэмэгдэж байна. Сумдад ахмадууд л амьдарч, залуучууд малгүй болж, бүгд хот суурин газар луу хар ажил хийхээр явсан байна. Сум, орон нутагт үлдсэн ахмадууд хэдэн малаа хариулж үлдсэн хүмүүс үеэ солиулж чадахгүй, зүрх судасны өвчлөл ихтэй, ЭМД-д нь хамрагдаж чадахгүй, наад зах нь 3–6 сарын дараа цаг авах боломж гарч байна. Эрүүл мэндийн яам бид нарыг хаячихсан, зүгээр л орон нутагтаа үх гэж байгаа юм байна гэдэг асуудал ярьж байна. Энэ дээр эрүүл мэндийн байгууллага яг ямар бодлого баримтлах юм бэ? Үүнээс урьдчилан сэргийлэх юу хэрэгжүүлэх юм бэ? малчин өрхтэй харьцуулахад хамрагдалт нь 0.08 хувьтай байхад ямар арга хэмжээ авах юм бэ гэдгийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, газартай холбоотой асуудал дээр өвөлжөө, хаваржаатай холбоотой. Тодорхой хэдэн малын тоо ихтэй газрууд нэлээн өндөр хамрагдалттай байна. Гэхдээ төвийн бүс, ялангуяа Өвөрхангай аймаг, бүр Завхан гээд нэлээн өндөр малын тоо толгойтой мөртлөө бага өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшсэн тоо баримт байна. Тэгэхээр ямар шаардлагад дээр үндэслэж газрууд олгогддог, ямар газрууд нь...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам хариулъя.

Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Түрүүн нийт малчдын статистикаар 313 мянган малчны 190 мянган малчинг төр хариуцах гэдгээр шууд хамрагдаж байгаа буюу 62.9 хувь нь эрүүл мэндийн бүх тусламж үйлчилгээ авах эрх нь нээгдсэн байгаа. 116 мянган малчнаас өөрөө төлдөг малчны 37,800 нь сая дурдсан тусламж үйлчилгээнд хамрагдаж явна.

Тэгэхээр нийт дүнгээр нь авбал 2025 оны хувьд нийт 303 мянган малчны 227 мянга орчим малчин ЭМД-д хамрагдсан байна. Энэ тоо нь зорилтот буюу өөрөө шимтгэлээ төлдөг малчдын хүрээнд харьцуулахад ийм бага хувьтай гарч байгаа юм. Үүнийг нэмэгдүүлэх чиглэлээр түрүүн хэлсэн бодлогын арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. ЭМД-ын хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд ч гэсэн төр шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх вэ? төрөөс хариуцах тусламж үйлчилгээний орлогыг хэрхэн нэмэгдүүлж даатгалын сангийн орлогыг найдвартай эх үүсвэртэй болгох вэ? гэсэн бодлогын өөрчлөлт хийхээр төлөвлөж ажиллаж байна.

Өвдөгний үе солиулах чиглэлээр Монгол Улсад өвдөгний үе солиулдаг 5–6 орчим байгууллага ажиллаж байна. Жилийн батлагдсан төсвийн хүрээнд 1,100–1,200 орчим үе сольж байгаа. Тендерийн хуулийнхаа дагуу 20 хувьд нь гэрээ байгуулж, 200 орчмыг нэмж гэрээ байгуулдаг. Сүүлд ирсэн судалгаагаар өвдөгний үе солих 5 мянга орчим иргэн байна гэсэн судалгаа байгаа. Манай үзүүлж байгаа хүчин чадлын түвшин жилдээ 1,500 орчим учраас хүлээгдэл үүсээд байна. Одоогийн байгаа хүчин чадлаа нэмэгдүүлж хийх төсвийн болон бусад бололцоо одоогоор байхгүй байна. Ер нь үе шаттайгаар үүнийг шийдэж, нэмэгдүүлж явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар. 6 номерын микрофон.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Газрын тухай хуульд 2024 онд өөрчлөлт гарч хэрэгжиж эхэлсэн. Энэ өөрчлөлтөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилд эзэмшүүлж, ашиглуулах газрын хэмжээ, байршил, зориулалтыг дүгнэлт гаргаж, Засгийн газраар хэлэлцэж батлах эрх зүйн орчинтой болсон. Үүнтэй холбоотойгоор бид Засгийн газраар 2024, 2025, мөн 2026 оны төлөвлөгөөг нэгтгэж баталсан. Газрын тухай хуулиараа газар олгох, төлөвлөх асуудлыг сумын ИТХ, аймгийн ИТХ, нийслэл, дүүргийн ИТХ шийддэг. Харин төлөвлөсөн газар нь хориглосон, хязгаарласан бүсүүдтэй давхцаж байна уу? зөрчил байна уу? гэдгийг газрын агентлаг шалгаж хянадаг.

Газар олгох эрх нь Засаг дарга нарт өөрсдөд нь байдаг. Тэгэхээр аймаг, сумд тухайн жилд эзэмшүүлж, ашиглуулах газрынхаа тоог их, бага баталж байгаа нь тухайн сумын иргэдийн хурлаас л хамаарч байгаа гэсэн үг. Сумын иргэдийн хурал тухайн сумынхаа газрын нөөц бололцоо, малчдын хүсэлтийг үндэслэн хэдий хэмжээний газрыг тухайн жилд эзэмшүүлэхээ өөрсдөө иргэдийн хурлаараа баталж түүнийг нь Засаг даргаар шийдвэрлэгдэж явахад бүрэн боломжтой. Эндээс хасаж, хязгаарлаж, багасгаж байгаа янз бүрийн шаардлага, үйл ажиллагаа байхгүй гэдгийг энэ ташрамд хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: М.Мандхай гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Газартай холбоотой нэг тодруулга байна. Бүсийн тоогоор нь авч үзвэл, 35–54 насны эмэгтэй, 35–59 насны эрэгтэй малчин өрхүүдийн тоог харлаа. Хангайн бүс нийтдээ 188,259, бүсээр нь харвал дунджаар 50 мянга орчим малчид байна. Олгогдож байгаа өвөлжөө, хаваржааны газар ердөө 100 дотор л эргэлдэж байна. Тэгэхээр энэ газрууд өөр зориулалтаар олгогдож байгаа учраас өвөлжөө, хаваржааны газрыг өгөхгүй байгаа юм уу? Яагаад малчин өрх, малын тоо толгойтойгоо харьцуулахад газрын эзэмшил ийм бага байгаа юм бэ? гэдэг логик асуултыг асууя.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн салбар дээр дахиад хэлье. Ойлгож байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа боловч энэ тооны үзүүлэлт өөрөө бүгд унаад байна шүү дээ. Маш хангалтгүй байна 0.1–1.6 хувийн гүйцэтгэлтэй буюу эзлэх хувь нь ийм бага байгаа нь миний түрүүн хэлээд байгаа...(минут дуусав)

ИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар. 6 номерын микрофон.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай: Өвөлжөө, хаваржааны газрыг одоо байгаа малчид нэг жилд шийдэх ийм заавал шаардлага байхгүй. Учир нь тухайн жилд эзэмшүүлж, ашиглуулах газрыг тухайн сумын өөрийнх нь газрын нөөц, өвөлжөө, хаваржааны хэмжээ, байршлаас хамааруулан төлөвлөж оруулж ирж байгаа. Тийм учраас иргэдийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил болгон 9 дүгээр сарын 15 хүртэл иргэдээс санал авч боловсруулж байж дараа жилийнхээ төлөвлөгөөг баталдаг. Тэгэхээр энэ саналд өвөлжөө, хаваржааны газар авах шаардлагатай иргэд өөрсдөө хүсэлтээ

гаргавал тухайн сумын ИТХ төлөвлөгөөндөө оруулж батлаад, дараа жилд нь өвөлжөө, хаваржааны газрыг шийдэх бүрэн боломжтой. Эндээс өвөлжөө, хаваржааны газрыг хэдийг нь олго гэсэн чиглэлийг олгодоггүй. Харин баталсан төлөвлөгөөг бид мэдээллийн санд бүртгэж...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Эрүүл мэндийн яам хариулья.

Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар: Хамрагдалтын түвшин эхний 5 сарын байдлаар 8,790 гэж гарсан нь малчдын орлого болон бусад асуудалтай холбоотойгоор энэ саруудыг жилийн дүнтэй харьцуулахад буурч харагддаг. Жилийн өссөн дүнгээр харьцуулж явбал нэмэгдэх боломжтой. Нөгөө талаас, өөрөө шимтгэл төлөгч иргэдийн хувьд ЭМД-ын тал дээр нэг сөрөг нөлөөлөл байдаг. Зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах үедээ шимтгэлээ төлж хамрагддаг. Үүнтэй холбоотойгоор тоо хувь буурдаг. Эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээ үүссэн үедээ төлөөд өдөртөө тусламж үйлчилгээнд хамрагддаг ийм зүйл байгаа нь үүнтэй холбоотой байхыг үгүйсгэхгүй. Дээрээс нь Малчны тухай хуулийн 4.2.6-д эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах хүсэлт гаргасан малчныг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүр үнэ төлбөргүй хамруулна гэж заасан байгаа. Хуулиараа малчин өөрөө хүсэлт гаргаад, гаргасан хүсэлтийн дагуу явахаар ийм заалт байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа (алх цохив). Өнөөдрийн хэлэлцсэн нийт асуудлуудтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. (алх цохив). Р.Сэддорж гишүүн, Та үгээ хэлнэ үү.

УИХ-ын гишүүн Р.Сэддорж: Өнөөдөр Малчны тухай хууль хаана, ямар учир шалтгаанаар хэрэгжихгүй байгаа талаар орон даяар сонсгол явуулж байна. УИХ-ын хяналтын дээд хэлбэрийн нэг бол сонсгол юм. Эндээс хаана гацаж байгаа гарц, гацааг арилгах ёстой. Малчдын дуу хоолойг хүргэдэг төлөөллүүд, нутаг орныхоо иргэдийн төлөө явдаг сайн, идэвхтэй хүмүүс ирсэн байна. Та бүхэн зардал гаргаад, цаг заваа гаргаж хүрэлцэн ирсэнд баярлалаа. Сонсгол маргааш бас үргэлжилнэ. Монгол Улсын парламентын хувьд хамгийн чухал асуудал бол малчид, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Монгол Улсын тусгаар тогтнол малчдын нуруун дээр явж байна. Өв соёлыг тээгч нар бол малчид юм.

Тэгэхээр энэ хуулиа засаж залруулаад, сайжруулаад, 100% хэрэгжүүлдэг хууль болгоё. Яамдууд яагаад үүнийг хэрэгжүүлэхгүй байгаа тухайгаа нэн яаралтай тайлбараа ирүүлэх хэрэгтэй. Энэ сонсголын үр дүнд юу хийх? юуг өөрчлөх? ямар бодлоготой зөрчилдөж, яагаад хэрэгжихгүй байгаа тал дээр яамдууд бодлогоо яаралтай гаргаж ирэхгүй бол малчид цаана чинь хүлээсээр, Та бүгдийг харсаар байна. Яамдын төлөөллүүд, сайдуудыг бүрэн сууна гэдэгт итгэлтэй байна. Сайдаа төлөөлж ирж байгаа та нар маш хариуцлагатай ажиллах хэрэгтэй. Та бүхэн өдөрт хэдэн гэр бүл салж байгаа, өдөрт хэдэн малчин айл усгүй байгаа, тоос шорооны улмаас мал нь бэлчих аргагүй байгааг сайн мэдэрч ажиллах хэрэгтэй.

Энэ сумын дарга, багийн дарга нар бас маш сайн ажиллах хэрэгтэй байна. Төрийн дуу хоолойг УИХ, яаманд маш сайн тавих хэрэгтэй. Аймгийн дарга нар маш хариуцлагатай ажиллах хэрэгтэй байна. Монголчууд хаяа багтахаараа бууж, хошуу багтахаараа идэж, нутаг бэлчээрээ ашигладаг ийм уламжлалтай ард түмэн. Тэгэхээр энэ газрын харилцаан дээр А.Энхманлай дарга яг сумын хил дээр байгаа

ч гэсэн өөрийн нэр дээр аваад, өөр хүн очиж амьдрахгүй болгож амьдраад байж болохгүй шүү дээ. Энэ дээр та нэг тодорхой санал өгөөч. Энэ хуульд ингээд болохгүй байна гээд. Тэгээд үүнийг бариад бид нар явъя. Мөн Боловсролын яам малчдын хүүхдийн боловсролын асуудалд онцгой анхаарч, 9 дүгээр сарын 1-нээс нэг ч гэсэн аймгийг хувилбарт сургалтаар сургавал тэнд хэмжих аргагүй их үр дүн гарна. Үүнд итгэлтэй байж болно. Малчдыг дагаад хилчид, заставын хүүхдүүд бас энэ дээр хамрагдах...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Мэндбаярын Мандхай гишүүн.

УИХ-ын гишүүн М.Мандхай: Ямар ч байсан өнөөдөр энэ чухал хуулийн хэрэгжилттэй холбоотой сонсголд цаг заваа гаргаж хүрэлцэн ирсэн бүх малчид, мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдад баярлалаа гэж хэлмээр байна. Нэлээн сайн мэдээллүүдийг тодорхой түвшинд авч байгаа болов уу гэж харж байна.

Өнөөдрийн байдлаар дүгнээд үзэхэд энэ салбарын бодлого гэж зүйл ер нь алга болчихжээ. Салбарын бодлого, салбар хоорондын уялдаа холбоо, хуулийн хэрэгжилтийн нийцэл гэдэг зүйл огт хэрэгжихгүй байгааг зөвхөн нэг хууль дээр харж байна. Бүхэл бүтэн салбарыг удирдах нь чухал хуулийн хэрэгжилт ийм түвшинд байгааг бүгд харж байна.

Малчны тухай хуульд хамгийн чухал зүйл нь малчдыг мэдлэг мэдээллээр хангах, мэдлэгжүүлэх, чадавхжуулах гэдэг маш чухал асуудал бүрэн орхигдчихсон байна. Энэ нь ганцхан яамны дарга нарын асуудал биш засаг захиргаа, сумын Засаг дарга хүртэл залуу малчнаа чадавхжуулах, орон нутгийн хөгжлийн сангийн төсөв, мөн ажлаа хийдэг хүмүүс байх шаардлагатай байна. Ганцхан сумын Засаг дарга гээд зогсохгүй, орон нутгийн боловсон хүчний чадавхын асуудал бүр шалдаа буучихсан байгааг малчид хэлж байна. Малчнаасаа дор мэдлэгтэй болчихсон боловсон хүчинтэй бид амьдарч байна. Энэ дээр онцгой анхаарах шаардлага байна. Холбогдох байгууллагууд нь байгаа учраас хэлж байна.

Гуравдугаарт, хөдөө аж ахуйн эдэлбэр газар буурч байгаа гэсэн энэ статистик тоонд би итгэхгүй байна. Яагаад гэвэл би өөрөө Хөдөө аж ахуйн тухай хуулийн анхдагч хуулийг гаргахдаа судалгаа хийж үзэхэд статистик тоо 70% руу хүрчихсэн байсан, гэтэл энд 87% гэжээ. Энэ ямар, хэзээний тоо тавьсан гэдгийг би мэдэхгүй байна. Хоёрдугаарт, өвөлжөө, хаваржааны газрын газар олголт буюу үнэхээр эзэмшүүлэх газрын тоо хангалтгүй байна. Ганцхан статистик тоон дээр харьцуулсан 3–5 жилийн харьцуулалт биш, зөвхөн нэг тоо тавьчихаад түүн дээрээ тайлбар өгөөд сууж байгаа бол хангалтгүй гэж хэлж байна. Маргааш энэ тоогоо харьцуулсан байдлаар нэг үзүүлээрэй. Сүүлийн 5 жилийн хугацаанд малчдад хэчнээн эзэмшүүлэх газар олгогдсон юм бэ? Үүнийг би бас мэдмээр байна.

Дөрөвдүгээрт, төрийн хүүгийн дэмжлэгтэй зээл олгосон асуудал. Үндсэндээ үйлдвэрлэлд өгсөн зээл нь өөрөө үр дүн биш шүү. Хөдөө аж ахуйн яам ийм хариулт хэлэхээ болимоор байна. Малчны орлого яг нэмэгдсэн юм уу? Энэ олон хөдөлгөөн явуулж хэдэн их наядаар мөнгө гарчихаад бодитой үр дүн нь юу вэ? Ногоочны борлуулалт баталгаажсан уу? Хэдэн малчид ногооч, тариаланчтай гэрээ хийсэн юм бэ? Хэрэглэгчийн хүнсний үнэ тогтвортой болсон уу? Жил ирэх тусам импортын хүнс нэмэгдээд байна шүү дээ. Манай төрийн албаныхан өөрсдөө хөрсөн дээрээ бууж, дэлгүүр, хоршоогоор явж үзье, зах, бөөний төвөөрөө яв.

Хэдэн дотоодын бүтээгдэхүүн өнөөдөр хүнсэнд хангагдаж байгаа юм, хэд нь импортоор хангагдаж байгаа юм бэ, жил ирэх тусам шүү дээ. Өнөөдөр хүнсний үйлдвэрүүд дотооддоо үйлдвэрлэхийн оронд эсрэгээрээ импортын бүтээгдэхүүн ирээд сурталчилаад зогсож байна шүү дээ. Дээр гаргаж байгаа шийдвэр доор хөрсөн дээрээ ерөөсөө буухгүй байна шүү дээ. Бүгд хөрсөн дээрээ явж ажилламаар байна. Манай эрүүл мэндийн байгууллага ч гэсэн та хэд суман дээр очиж яг ард иргэдийнхээ эрүүл мэндийн асуудлыг өөрсдөө очиж үзэх хэрэгтэй. Өнөөдөр энэ нэг тоо ерөөсөө бодит амьдралтай зөрөөд байна. Тоогоо ч гэсэн яг ингэж харьцуулж хэлж чадахгүй байна. Өнөөдөр малчин өрхийнхөө тоог хүртэл бүгдээрээ алдаатай хэлж байна шүү дээ. Ийм байхад бодлого, шийдвэр чинь яаж зөв гарах юм бэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн: Бид бүхэн 2 жилийн өмнө батлагдсан Малчны тухай хуулиар өнөөдөр УИХ хяналтын сонсгол хийж байна. Энэ бол Монгол Улсын Их Хурлын түүхэнд анх удаагаа хуулийнхаа хэрэгжилт дээр хийж байгаа, анх удаа зохион байгуулж байгаа хяналтын сонсгол юм.

Энэ хууль анх удаа малчдын эрх зүйн үндсийг иж бүрэн байдлаар тодорхойлж, олон чиглэлээр зохицуулалтуудыг бий болгосон. Үндсэндээ мал аж ахуйн анхдагч буюу малгай хууль гэж хэлж болохоор хууль юм. Өнөөдөр бид бүхэн энэ хуулийн 2 дахь жилийн нүүрэн дээр нь хэрэгжилтийг нь шалгаж байна. Хүндрэл бэрхшээлүүд байна. Хуулийн зохицуулалтууд бүрэн, дүүрэн хэрэгжээгүй, Засгийн газраас гаргах байсан 11 журмаас магадгүй тал нь хэрэгжилт хангалтгүй, уялдаа хангагдаагүй байна. Нэг талаараа тал еэвэнгийн үлгэр шиг, тал дутуу нөхцөл байдалтай байна. Мэдээж бид нар энэ асуудлыг өнгөрсөн борооны хойноос цуваа нөмрөв гэдэг шиг асуудлыг хүндрүүлэхгүйгээр, Монгол Улсын амин чухал салбар болсон, өнөөдөр стратегийн буюу эдийн засгийн аюулгүй байдалтай шууд хамааралтай, хүнсний хангамжтай шууд хамааралтай ийм чухал стратегийн салбарын асуудлыг төр анхааралдаа авах зайлшгүй шаардлага байна.

Өнөөдөр телевиз, радиогоор энэ мэдээллүүд бүрэн дүүрэн гарч, иргэд нэлээн сайн мэдээлэл авч байгаа. Засгийн газраас хийх байсан хууль сурталчлах ажлыг ч өнгөрсөн 2 жилийн хугацаанд хангалттай хийгээгүй.

Гэхдээ нэг сайн тал нь өнөөдөр бид энэ сонсголын хүрээнд, энэ багц асуудлуудын хүрээнд хуулийн зорилго, зорилт, үндсэн суурь агуулгыг сайтар ойлгож авч байна. Өнөөдөр бидний ярьсан асуудал үндсэндээ малчны хөгжил, боловсрол, залуу залгамж халаагаа бэлтгэх, эрүүл мэнд, газрын харилцаа, мал аж ахуйн цахим шилжилттэй холбоотой олон чухал асуудлууд байлаа. Маргааш үлдсэн асуудлууд хөндөгдөж яригдана. Эндээс дүгнэж хэлэхэд, бид нар хүнээ хөгжүүлэхгүйгээр хөгжлийг ярих ямар ч боломж, бололцоо байхгүй. Мянган мэргэжлийн эзэн болсон малчид руугаа анхаарч, хүнийхээ хөгжилд анхаарч, хэрэгжихгүй байгаа журмуудыг гаргуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар УИХ онцгой анхаарч ажиллах зайлшгүй шаардлага бий болсон байна гэдэг дүр зураг харагдаж байна. Бид нарын гол зорьж байгаа зүйл бол энэ хууль хэрэгжсэнээр цаашид бид нар хүн засагладаг биш, хууль засагладаг гэдгийг бодит ажил хэрэг болгох ийм сонсгол болно гэж харж байна.

Өнөөдөр Монгол Улсад 937 хууль байгаагаас олон мянган иргэдийн эрх ашгийг хөндсөн Малчны хууль шиг, Багшийн хөгжлийн хууль шиг, Ахмад настны

тухай хууль шиг, Залуучуудын хөгжлийг дэмжих хууль шиг олон хууль байна. Тэгэхээр бид нар хууль болгон дээр цаашид үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг гүйцэтгэх засаглалаар, Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд зайлшгүй шаардах шаардлага байна.

Өнөөдөр хууль хэрэгжихгүй бол ширэнгийн хууль үйлчилнэ. Дүрэм, журам мөрдөгдөхгүй бол энэ улс оронд хөгжлийг ярих боломж, бололцоо байхгүй. Энэ салбар онцгой чухал стратегийн салбар гэдгийг би дахин онцолж хэлье. Яагаад гэвэл энэ зөвхөн хөдөө орон нутагтай холбоотой, малчин хүнтэй холбоотой, мал аж ахуйн салбартай холбоотой асуудал биш. Энэ хотын айл өрх бүрийн мах, сүү, хүнсний бүтээгдэхүүний үнэ, чанарт буцаад шууд нөлөөлдөг стратегийн чухал бодлогын асуудал юм. Энэ хүнсний аюулгүй байдал, улс орны аюулгүй байдалтай холбоотой чухал асуудал учраас Монголын төр чухал асуудалдаа үүрэг хариуцлагатай хандах зайлшгүй шаардлага байна.

Маргаашийн хуралдаанд хариуцлагатай албан тушаалтнуудыг заавал оролцуулах, сайд нарыг заавал байлгах шаардлагатай байна гэсэн энэ хүсэлтийг хуралд даргалагчид тавьж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Д.Жаргалсайхан гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Жаргалсайхан: Малчны тухай хууль маш муу хэрэгжиж байгаа юм байна. Энэ хуулиар олон нөхцөл боломжийг малчин хүнд, тэр тусмаа Монголын нийт өрхийн 4/1-д буюу 250 мянган өрхөд хүргэх, илүү тодорхой болгох ийм хууль юм. Энэ нь төрийн бодлого, үйл ажиллагаанаас хаягдаж, орхигдож байгаа, мэдлэг мэдээлэл дутуу байгаа хүмүүст хүргэх хууль юм. Гэсэн хэдий ч манай төрийн байгууллагууд, тэр тусмаа газар хариуцсан яам, агентлагууд муу ажиллаж байгаа юм байна.

Үүнийг ямар байдлаас хэлж байна вэ гэвэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ малчин хүнд хэрхэн хүрч байгааг та бүхэн сая сонслоо. 40%-д хүрэхгүй байна. Жил ирэх тусам ЭМД-ын сангаас олгогдож байгаа санхүүжилт буурч байна. Энэ нийгмийн баялаг иргэн хүндээ очихгүй байна. Тэр үүднээс иргэдийн эрүүл мэнд маш их хохирч байна. Тооцоо, судалгааг харахад, хорт хавдар жил ирэх тусам 10–20 хувиар өсөж байна. Өнөөдөр Эрүүл мэндийн яам иргэдийнхээ эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх ажил дээр маш муу ажиллаж байна. Олон улсын болон төсвөөс маш их санхүүжилтийг ЭМЯ хувьсах зардлаар авч байгаа. Олон эрүүл мэндийн төв, газрууд, хувийн эмнэлгүүд ажиллаж байгаа хэрнээ их хэмжээний зардал гарч байгаа болов иргэддээ хүрч чадахгүй байна. Үүний цаана хулгай, луйвар л явж байна.

Мөн малчин хүний амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, түүнтэй холбоотой газар нутгийн, бэлчээрийн асуудал байна. Бэлчээрийн асуудал дээр гэхэд л өнөөдөр бид бүхэн өөрсдөө газар нутгаа мэдэхээ байсан. Хуучин бол бараг л багийн ИНХ-аар ард иргэд, малчин өрхүүд хоорондоо ярилцаад хайгуулын лиценз олгох уу, олгохгүй юу гээд ярьдаг байсан бол одоо больсон. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сумын Засаг дарга оролцдог байсан бол одоо оролцохоо больсон. Бид нар газар нутагтаа эзэн байхаа больсон.

Ийм байдлаараа цаашдаа Монгол Улсын иргэн бүр төрөө барьж байна уу, үгүй юу гэдгийг ярих цаг болсон. Мөн цаашид залуу малчдыг хөгжүүлэх, мэдлэг мэдээлэлтэй болгох дээр бас асар муу ажиллаж байгаа юм байна. Хөдөө аж ахуйн

яам үнэнээ хэллээ шүү дээ. Санхүү, мөнгө байхгүй, бид нар малчдадаа хүрч чадахгүй байна, ямар нэгэн сургалт, семинар хийгээгүй л гэж байна. Тэгэхэд энэ байгаа бүтэц, орон тоо чинь тэгээд юу хийж байгаа юм бэ? Хөдөө аж ахуйн газар чинь энэ яамтайгаа гэрээ байгуулаад ажиллаж байгаа шүү дээ. Яагаад малчдадаа хүрч чадахгүй байгаа юм бэ? Үүнийг муу гэж үзнэ.

Малчид өнөөдөр даатгалд хамрагдаж, зээл авахдаа малаа даатгуулсан юм уу гэж байгаад л авч байгаа. Мөнгө төлж байгаа, гэтэл төлсөн мөнгөө буцаагаад авч чадаж байна уу, үгүй юу гэвэл авч чадахгүй байгаа. Ган, зуд зөндөө, олон саад бэрхшээлд малчид маань өртөж байна. Тэгэхэд үндсэндээ даатгуулсан даатгалынхаа мөнгийг авч чадахгүй байна шүү дээ.

Дээрээс нь малын гоц халдварт өвчнүүд маш их гарч байна. Гэтэл түрүүн та бүхэн тоо баримтуудыг л харлаа. Улсын төсвөөс гоц халдварт өвчинтэй тэмцэхэд зориулаад 55 тэрбум төгрөг энэ жил хуваарилагдсан байна, гүйцэтгэл нь гараад явчихаж. Тэгэхэд яагаад Монголын газар нутаг бүрд өнөөдөр шүлхий гарч байгаа юм бэ? Яагаад үүнээс урьдчилан сэргийлэхэд хүрэлцэхгүй байгаа юм бэ? Хамрах хүрээг нь хумиад энэ өвчлөлийг бууруулж чадахгүй байгаа гэхээр яахын аргагүй л манай төрийн байгууллагууд ажлаа маш муу хийж байна. Үнэхээр хатуухан хэлэхэд ерөөсөө хулгай, дээрэм л ярьдаг болсон. Хэн нь хэдэн төгрөгийн хулгай хийсэн, хэдэн төгрөгийн авлига авсан бэ? гэж л ярьдаг болсон. Тэрнээс биш ажил хийлээ, амжилт гаргалаа гэдэг тоон мэдээлэл өнөөдөр бүх яамны танилцуулга дээр харагдсангүй шүү. Яг үнэндээ та бүхэн бүгдээрээ сонсоод сууж байлаа...(минут дуусав)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд үг хэлж дууслаа (алх цохив).

Өнөөдөр бид нийт 7 илтгэл сонслоо. Илтгэлтэй холбогдуулан УИХ-ын гишүүд асуулт асууж, төрийн байгууллагууд, удирдах ажилтнууд тодорхой хариултуудыг өглөө. Үүгээр бид нар төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төрөөс зохицуулж, хэрэгжүүлж байгаа ажлын талаар сонслоо. Малчны тухай хуульд ямар зүйл, заалтууд дутуу хэрэгжиж байгаа, яагаад, ямар учир шалтгаантай гэдэг дээр төрийн байгууллагууд бүгд тодорхой хэмжээний хариултуудыг өглөө. Үүнд УИХ-ын гишүүд өөрсдийн дүгнэлтийг хийж, цаашид бид нар сонсголоос тодорхой шийдвэрүүдийг УИХ-д хэлэлцүүлж, Засгийн газарт тодорхой хэмжээний шаардлага, баримтыг хүргүүлэх болно.

Хүрэлцэн ирсэн, идэвхтэй оролцсон УИХ-ын гишүүддээ талархал илэрхийлье. Мөн оролцсон төрийн байгууллагынхан болон нийт малчдын төлөөлөл, иргэдийн төлөөлөл, олон нийтийн байгууллагын төлөөллүүд, өөр өөрсдийн саналаа хэлэхийн тулд орон нутгаасаа хүрэлцэн ирсэн нийт оролцогчдоодоо талархал илэрхийлье.

Малчны тухай хуулийн хэлэлцүүлгийн хүрээнд бичгээр ирсэн саналуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу уншиж танилцуулах, сонсголын тэмдэглэлд оруулах журамтай. Та бүхэнд ирсэн 3 саналыг уншиж танилцуулъя.

1 дүгээр санал. Говь-Алтай аймгийн Бугат сумын 1 дүгээр багийн малчдын төлөөлөл Х.Намсрайжав, Б.Хадбаатар, Б.Билигсайхан, Г.Даваадорж, Т.Батдорж, Ц.Нанзаддорж, Н.Нямцэрэн, Г.Галбаатар нарын 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр гаргасан санал. Малчдын тухай хуулийн 4.2.9 дэх хэсэгт “Хуульд заасан

өндөр настны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ” хэмээн заасан байдаг. Энэ зохицуулалтыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулахаар хуульчилжээ.

Гэвч малчны нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх дээрх зохицуулалт бодит амьдралд огт хэрэгжээгүйн зэрэгцээ Засгийн газар, холбогдох салбарын сайд нар хууль тогтоомжийг биелүүлэх үүргээ огт биелүүлээгүйд сэтгэл дундуур байна. Малчид бид тогтмол орлогогүй, намар болон хаврын улиралд ноолуур, ноосоо борлуулж орлогын эх үүсвэртэй залгадаг. Сар тутам төрийн албан хаагч нартай адил тогтсон хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөх ямар ч боломжгүйг УИХ-ын гишүүд сайн мэдэж байгаа. Нэг удаа нөхөн төлөх дээрх зохицуулалтаар тэтгэвэртэй гарч чадаагүй, эсвэл тэтгэвэрт гарах дөхсөн малчдад боломж олгосон атал үүнийг Засгийн газар дур мэдэн хэрэгжүүлээгүйд эмзэглэж байна.

Түүнчлэн Малчны тухай хуулийн 16.1-д зааснаар 2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд дагаж мөрдөхөөр хуульчилсан байв. Гэвч малчид бид Малчны тухай хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадсангүй, эрхээ эдлэх боломжоор огт хангагдаагүй гэж үзэж байна. Иймд дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх гарц, гаргалгааг гаргаж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

2 дугаар санал. Увс аймгийн иргэн, малчин Батням. 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр гаргасан санал. Дээхэн үед малчид, тариаланч иргэдийн үр хүүхдийг цэргийн албанаас чөлөөлдөг байсан. Одоо үед цэргийн албыг хотод суралцаж байгаа оюутан хүүхдүүд “оюутан цэрэг” хөтөлбөрөөр хаадаг болжээ. Цэрэгт татагдаж байгаа хүүхдүүд нь малчин ардын л хэдэн хүүхэд болсон байна. Энэ хэдэн эрчүүд нь аймаг, сумандаа мал ахуйгаа эрхлээд байж байвал нэмэртэй байна. Орон нутгаас хүүхдүүдээ оюутан болгоод явуулахаар тэндээ үлдэж, эргэж аймаг, сумандаа ирэхээ байсан. Иймд малчин, тариаланч залуучуудыгаа цэргийн албанаас чөлөөлөх асуудлыг зохицуулж өгнө үү.

3 дугаар санал. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын малчин Э.Мядагмаа. 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр гаргасан санал. Малчны тухай хуулийн нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх, шимтгэлээс хөнгөлөх зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Ийм гурван санал ирсэнийг Та бүхэнд уншиж танилцууллаа. Сонсголын тэмдэглэлд эдгээр саналыг тусгах болно. “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт Ерөнхий хяналтын сонсголын эхний өдрийн үйл ажиллагаа өндөрлөж байна.

Та бүхэнд маргаашийн хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Маргааш буюу 6 дугаар сарын 24-ний өдөр 9 цаг 30 минутад бүртгэл явагдаж, 10 цагт сонсгол эхэлнэ.

Нэгдүгээрт, “Малчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зээл санхүүжилтийн нөхцөл байдал, Малчны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой үр дүн”-гийн талаар Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, хоёрдугаарт, “Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, гамшигт болон аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирол, түүнийг даван туулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”-ний талаар ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, гуравдугаарт, “Малчны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн,

цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, дөрөвдүгээрт, "Малчны хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал"-аар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, тавдугаарт, "Малчны хамтын санаачилга, хоршил - Шинэ хоршооны явц, үр дүнгийн талаар" Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар илтгэл танилцуулна.

Өнөөдрийн сонсголыг хаасныг Та бүхэндээ мэдэгдье. Нийт оролцогчдодоо идэвхтэй, сайн оролцсонд талархал илэрхийлье.

Тэмдэглэлтэй танилцсан:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР